Devices designed to evacuate gas, fluid, tissue, or foreign materials from the body by means of vacuum suction. These devices usually consist of a powered (or less frequently) manual vacuum pump, a regulator and gauge, a suction tube, one or more collection canisters, plastic tubes connecting the components to each other, and an overflow protection and/or bacteria filter. Typically the pump creates a vacuum in the suction (e.g., tubes, catheters, cannulae) tubing which is inserted into the cavity; then the debris is removed and routed to a specimen container. The vacuum capacity varies from as high as 400 mm Hg or more to as low as 80-120 mm Hg or less; free flow rates may be as low as 5 liter/min or as high as 35 liter/min. Aspirators may be portable or mobile and line- or battery-powered. Dedicated aspirators are available for surgical procedures (e.g., general surgery, liposuction, and uterine suction); for breast milk extraction; and/or for clearing of secretion during dental; gastric; wound, and airway procedures. They are mainly used when suction from a central vacuum system is not available or appropriate.

Аспиратор нь хүний биеэс хий, шингэн, эс, гадны материалыг вакуум үүсгэн сорж, гаргах зориулалттай сорох аппарат юм. Сорох аппарат нь вакуум шахуурга, соролтын хүчийг (эсвэл бага зэрэг) тохируулагч болон соролтын хүчийг хэмжигч, сорох гуурс, нэг эсвэл хэд хэдэн хаягдал цуглуулах сав, эд ангиудыг хооронд нь холбогч гуурснуудаас тогтоно. Шахуурга нь өвчтөний шарх, ангархай, нүх, сүврүү орох гуурсны үзүүрт (гуурс, катетер, зүү гэх мэт) вакуумыг үүсгэн сорно. Сорох хэсгээс гарсан бохир үрсан хаягдлын саванд очно. Вакуумын чадлыг тохируулахдаа өндрийг 400мм.м.у.б-аас дээш, намыг 80-120 мм.м.у.б болон үүнээс багаар тохируулна. Урсгалын хурд нь багадаа 5л/м ихдээ 35 л/м байна. Сорох аппарат нь суурин, зөөврийн, 220в-оор тэжээгддэг эсвэл батарейтай байж болно. Тусгай зориулалтын сорох төхөөрөмж гэж байна. Үүнд хагалгааны (ерөнхий мэс засал, өөх соруулах мэс засал, шээс соруулах); хөхний сүү саах, ходоод, шүдний эмчилгээний үед үүссэн шингэнийг соруулах үед хэрэглэнэ. Сорох аппаратыг ихэвчлэн хагалгааны үед төвийн вакуум систем байхгүй эсвэл сорох төхөөрөмж хэрэглэх нь илүү тохиромжтой үед хэрэглэнэ.



ASPIRATORS, DENTAL

АСПИРАТОР/СОРОХ ТӨХӨӨРӨМЖ, ШҮДНИЙ

UMDNS CODE 10212

Aspirators designed to evacuate oral secretions, water, blood, and tooth debris from the mouth by means of vacuum suction during dental diagnostic, treatment, and/or surgical procedures. These aspirators generally consist of a vacuum pump (typically a low-pressure, high-volume evacuator), plastic tubes connecting the components to each other, one or more collection containers, a control valve or switch and suction tubes or cannulae which are inserted into the oral cavity. Dental aspirators may be portable or mobile and they are either line- or battery-powered. Aspiration using a central vacuum system is also available.

Аспиратор нь шүдний Оношилгоо, эмчилгээ, мэс ажилбарын үед амны хөндийн шингэн, ус, цус зэргийг соруулдаг сорох аппарат юм. Энэ сорох аппарат нь ерөнхийдөө вакуум шахуурга (ихэвчлэн бага даралттай, их хэмжээний багтаамжтай), иж бүрдлүүдийг хооронд нь холбосон гуурс, нэг ба түүнээс дээш цуглуулагч сав, хяналтын хавхлага, унтраалга, амны хөндий рүү оруулан соруулах гуурс зэргээс бүрдэнэ. Амны хөндийн сорох аппарат нь зөөврийн байж болох бөгөөд цахилгаанаар эсвэл батарейгаар ажиллана. Мөн төв соруулах системд холбогдох боломжтой байна.



ASPIRATORS, AIRWAY, NASAL, INFANT

АСПИРАТОР/СОРОХ ТӨХӨӨРӨМЖ НЯРАЙН АМЬСГАЛЫН ЗАМЫН

UMDNS CODE 10214

Airway aspirators designed to evacuate secretions, liquids (e.g., blood), and/or foreign bodies from the nasal cavity of infants. These aspirators consist of a device that provides the suction, such as a manually operated bulb, a battery-powered pump, or a device including a long tube placed against the nostril while the operator (e.g., the parents) use their own suction to draw mucus out of the child's nose.

Аспиратор нь нярайн хамрын хөндийгөөс ялгарах салтслаг шүүрэл, шингэн (ө.х цус) ба гадны биетийг зайлуулах зориулалттай сорох аппарат юм. Энэ сорох аппарат нь гараар удирддаг "шахуурга", зайгаар ажилладаг шахуурга, эсвэл хэрэглэгч (эцэг эх байж болно) бие даан хүүхдийн хамраас салстыг сорж авдаг хамрын нүхэнд байрлуулах урт хоолой бүхий хэрэгслийн тусламжтайгаар соролтыг гүйцэтгэдэг.



ASPIRATORS, SURGICAL

АСПИРАТОР/СОРОХ ТӨХӨӨРӨМЖ, МЭС ЗАСЛЫН

UMDNS CODE 10217

Aspirators designed to evacuate large volumes of gas, liquid, tissue and/or other debris from a surgical site by means of a high vacuum suction during surgical procedures. These devices usually consist of a powered vacuum pump, a regulator and gauge, one or more collection canisters, plastic tubes connecting the components to each other, and overflow protection and/or bacteria filter, and the suction tubing (e.g., tubes, catheters, cannulae). The vacuum capability should be at least 400 mm Hg; free-flow rates are usually higher than 25 liter/min. Surgical aspirators may be portable or mobile; line- or battery-powered. They are mainly used when suction from a central vacuum system is not available or appropriate.

Аспиратор нь мэс заслын үед өндөр вакуумжсан сорох хүчээр мэс засал хийгдэж буй хэсгээс хий, шингэн эд ба бусад жижиг биетийг сорох зориулалттай аппарат юм. Уг аппарат нь ихэвчлэн цахилгаанаар ажилладаг вакуум шахуурга, тохируулагч ба манометр /түвшин хэмжигч/, бохир цуглуулах сав, иж бүрдлүүдийг холбосон хуванцар хоолой, хэт дүүргэлтээс урьдчилан сэргийлэгдсэн ба/буюу бактерийн шүүлтүүр, түүнчлэн сорогч хоолой /жишээ нь хоолой, катетер, хөндийт хоолой/ зэргээс бүрддэг. Вакуумын чадал нь хамгийн багадаа 400 мм.м.у.б, чөлөөт урсгалын хурд нь ихэвчлэн 25 л/мин-с их байдаг. Мэс заслын сорох аппарат нь зөөврийн буюу хөдөлгөөнт байдлаар ашиглагддаг. Нэгдсэн цахилгаан тэжээлд холбогдох эсвэл батарейгаар ажиллах боломжтой. Төв сорох системтэй холбогдсон сорох аппарат нь энгийн хэрэглээнд тохиромжгүй.



ASPIRATORS, UTERINE

АСПИРАТОР/СОРОХ
ТӨХӨӨРӨМЖ, УМАЙН

UMDNS CODE 10222

Aspirators used to evacuate gas, fluid, tissue, or foreign materials from the uterus by means of suction. These aspirators typically include a powered high-vacuum (less than or equal to 400 mm Hg) and high-flow (>30 liter/min) vacuum pump; collection canisters; plastic tubes connecting the components to each other; an overflow protection and/or bacteria filter; and suction tubing (e.g., tubes, catheters, canulae). The aspirators are usually mobile units that may be line- or battery-powered, and mobile. Uterine aspirators are used mainly for dilation and evacuation therapy, to terminate early pregnancies up to 12 weeks, to treat incomplete spontaneous abortions or to remove some tissues after labor. Other uses also include diagnostic dilation and curettage intended to remove the outermost layer of uterine lining (endometrium) for an endometrial biopsy.

Аспиратор нь умайн хөндийгөөс хий, шингэн, эдээрэг гадны биетүүдийг соруулж авах зориулалт бүхий сорох аппарат юм. Сорох аппарат нь ихэвчлэн цахилгаанаар ажилладаг өндөр чадлын вакуум (400 мм м.ү.б буюу түүнээс багагүй) болон өндөр урсгалт вакуум шахуурга (>30 литр/мин), бохир цуглуулах сав, иж бүрдлүүдийг холбосон хуванцар хоолой, хэт дүүргэлтээс урьдчилан сэргийлэх бактерийн шүүлтүүр, түүнчлэн сорогч хоолой /жишээ нь хоолой, катетер, хөндийт хоолой/ зэргээс бүрддэг. Мэс заслын сорох аппарат нь ихэвчлэн зөөврийн буюу хөдөлгөөнт байдлаар эсвэл батареягаар ажиллах боломжтой. Гол төлөв 12-оос бага долоо хоногтой жирэмснийг таслах үеийн эмчилгээ буюу бүрэн бус үр хөндөлтийг эмчлэх, ажилбарын дараа зарим эдийг зайлуулах үед энэхүү умайн хөндийн сорох аппаратыг ашиглана. Түүнчлэн оношилгоонд зориулан эндометрийн биопси шинжилгээ хийх болон умайн ханан дахь салст хэт зузаарсан үед арилгах зорилгоор ашигладаг.



AUDIOMETERS

АУДИОМЕТР/ СОНСГОЛЫН БИЧЛЭГИЙН АППАРАТ

UMDNS CODE 10228

Instruments designed to measure and characterize hearing loss by determining the lowest audible level (i.e., hearing threshold) of a patient for pure test tones, signals (e.g., speech), or both. These devices include tone generators, amplifiers, and sound-level monitors. Audiometers are intended for conducting diagnostic tests for hearing disorders and assisting in other otologic disorders diagnosis.



Аудиометр нь цэвэр авиа гаргаж сонсголын босгыг хэмжих хийгээд үндсэн хэсэг нь дууны давтамжтай цахилгаан хэлбэлзэл үүсгэгч, генератор, тэжээлийн блокоор дамжуулан хүчдэл өгдөг ба олон янзын давтамжтай цэвэр авиаг үүсгэж, тэдгээрийн эрчмийг нь өөрчлөх боломж олгодог бөгөөд хариуг нь нарийн тодорхой найдвартай хэмждэг юм. Аудиометр нь сонсголын сонорыг хэмжихдээ өөр өөр давтамж дээр сонсох сэрлийн босгыг тод хэмжилтын үр дүнгээр байгуулах сонсголын босго дээрх аудиограмм буюу сонсголын бичлэгийн тусламжтайгаар чихний өвчин эмгэгийг оношлох үүрэгтэй.

BALANCES, ELECTRONIC

ЖИН, ЭЛЕКТРОН

UMDNS CODE 10263

Balances that include an electronic circuit that senses the deviation of the balance beam from the equilibrium point (e.g., a strain gauge sensor) and applies a restoring electromagnetic force, usually through a solenoid or torque motor. Typically, the current required to produce the balancing force in units of weight is displayed on a digital display. Most electronic balances include automatic calibration, temperature change compensation, and taring capability for easy subtraction of the mass of the container. Electronic balances frequently include a built-in interface so that they can communicate with printers, computers, and data-processing units.

Жин нь мөрийн (хөндлөвчийн) тэнцвэрийн цэгээс хазайх хазайлтыг мэдрэх (суналтын гэх мэт) мэдрэгчтэй, соленойд эсвэл цахилгаан хөдөлгүүрээр буцаан тэнцвэржүүлэх цахилгаан соронзон үйлчлэл үзүүлэх цахим хэлхээтэй. Ихэвчлэн, тэнцвэржүүлэх хүчийг гаргахад шаардлагатай гүйдлийг жингийн нэгжид хувирган тоон дэлгэцэд харуулдаг. Ихэнх электрон жин автомат тохируулгатай, орчны температурын нөлөөллийг тооцох, "тэглэх" буюу хэмжиж буй зүйлийн савны жинг хасч тооцох зэрэг боломжтой, компьютер, хэвлэгч болон өгөгдөл боловсруулах бусад төхөөрөмжтэй холбогдох холболттой байдаг.



BALANCES, MECHANICAL

ЖИН, МЕХАНИК

UMDNS CODE 10264

Balances designed to weigh by restoring the deviation of the balance beam to the equilibrium point by applying a mechanical force.

Жин гэдэг нь механик хүчний үйлчлэлээр мөрний хазайлтыг тэнцүүлэх зарчмаар ажилладаг хэмжих хэрэгсэл.



BEDS

ОР

UMDNS CODE 10342

Furniture designed with a comfortable surface appropriate for supporting the lying body of a person. Beds typically consist of a horizontal surface or support appropriate to hold a mattress and/or mattress and spring-box; they may also include a head and/or foot frame and sometimes lateral rails (i.e., siderails). Beds are mainly used in healthcare facilities (e.g., hospitals, nursing homes) and at home for rest-

Ор бол хүнийг хэвтүүлэх зориулалттай, тав тухтай гадаргуутай тавилга. Ор нь ихэвчлэн гудас (матрас) эсвэл матрас/пүрш тавих хэвтээ гадаргуу эсвэл хийцтэй байх ба толгой хөл тал нь өндийдөг, зарим тохиолдолд дагуу бариултай байна. Орыг эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, асрамжийн газар) болон гэрт амрах, унтах зориулалтаар, эсвэл сэргээн засах, эмчилгээ хийх зориулалтаар ашигладаг. Тогтмол урт өндөртэй болон өндөр, хэлбэрийг нь механик, цахилгаан, шингэн

ing and sleeping and also during recuperation and/or medical treatments. Beds with a fixed height and width and beds that permit the adjustment of the height and contour of the resting surface using mechanical, electric, and/or hydraulic mechanisms are also available. Some beds are intended for particular procedures, such as to provide alternating pressure, for birthing, and to perform radiographic procedures.

удирдлагаар тохируулах боломжтой олон төрөл бий. Мөн хувьсах даралттай, төрөх, рентген шинжилгээ хийх зэрэг тусгай зориулалтын ор байдаг.



BEDS, ELECTRIC

ОР, ЦАХИЛГААН

UMDNS CODE 10347

Beds designed with one or more built-in electric motors and remote electric or pneumatic controls that can be operated by the patient or staff members to adjust the bed surface, contour, or both. In most electric beds the mattress support is divided into three or more pivoted sections that can adjust the height and assume Gatch positions or Fowler positions (head and knees elevated) or tilt to Trendelenburg and reverse Trendelenburg positions (body straight; feet elevated or lowered, respectively). Most electric beds include movable and latchable siderails. Some beds may incorporate fixed endrails or a fabric framed canopy. Electric beds are mainly used in healthcare facilities (e.g., hospitals, nursing homes) and at home for resting and sleeping and also during recuperation and/or medical treatments (e.g., alternating pressure) and procedures (e.g., birthing, radiography).

Цахилгаан ор нь нэг болон түүнээс дээш цахилгаан хөдөлгүүртэй, өвчтөн болон эмнэлгийн ажилтан ажиллуулах орны гадаргуу, хэлбэрийг өөрчлөх цахилгаан болон гидравлик удирдлагатай. Ихэнх цахилгаан орны гудас (матрас) тавих хэсэг нь өндрийг нь тохируулах боломжтой гурав болон түүнээс дээш нугасан холбоостой хэсгээс бүрдэх ба өвчтөний цээжийг өндийлгөсөн, өвдгийг босгосон, хөлийг буулгасан гэх мэт (Гатт/Поулер байрлал) байрлалаар тохируулах боломжтой байх ба эвхдэг эсвэл салдаг дагуу бариултай, салдаггүй толгойтой, даавуун хөшигтэй байж болно. Цахилгаан орыг ихэвчлэн эмнэлэг, асрамжийн газар зэрэг эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх ба гэрт унтаж амрахад хэрэглэнэ. Мөн нөхөн сэргээх болон эмчилгээний (хувьсах даралттай) ба ажилбарын (төрөх, рентген зураг авах) зориулалтаар ашигладаг.




BEDS, ELECTRIC, RADIOGRAPHY/FLUOROSCOPY

ОР, ЦАХИЛГААН, РЕНТГЕН ЗУРГИЙН/
ХАРАЛТЫН

UMDNS CODE 10351

Electric beds designed to permit radiographic and/or fluoroscopic procedures on a patient. These beds typically include radiolucent mattresses and supporting surfaces, raising and lowering mechanisms that do not intervene in the path between the radiation source and image intensifiers, and dimensions and clearances that facilitate placement of the x-ray tube head under the bed. Radiography/fluoroscopy electric beds are mainly used for bedside procedures using mobile radiographic or fluoroscopic units.

Цахилгаан ор бол үйлчлүүлэгчийн рентген зураг авах болон харалт хийх нөхцөлийг хангах зориулалттай юм. Эдгээр ор нь ихэвчлэн цацраг туяа нэвтрүүлэх боломжтой гудас, дэмжих гадаргуутай байдаг. Түүнчлэн цацрагийн эх үүсвэр болон дүрсний өсгөгчийн хоорондох замд саад болохгүйгээр ихэсгэх, багасгах механизм, орон дээр рентген хоолойн толгойг зөв байрлалд байрлуулахад дөхөм болохуйц хэмжээтэй байдаг. Рентген зураг авах, харахад зориулсан цахилгаан ор нь зөөврийн Рентген болон Флюроскопийн зураг авах үед ашиглагддаг.



BEDS, MECHANICAL

ОР, МЕХАНИК

UMDNS CODE 10357

Beds designed with one or more mechanisms operated by manual crank handles or other controls that can be operated by the patient or staff members to adjust the bed surface, contour, or both. In most mechanical beds, the mattress support is divided into three or more pivoted sections that can adjust the height and assume Gatch positions or Fowler positions (head and knees elevated) or tilt to Trendelenburg and reverse Trendelenburg positions (body straight; feet elevated or lowered, respectively). Most mechanical beds include movable and latchable side-rails. Some beds may incorporate fixed endrails or a fabric framed canopy. Mechanical beds are mainly used in healthcare facilities (e.g., hospitals, nursing homes) and at home for resting and sleeping and also during recuperation and/or medical treatments (e.g., alternating pressure) and procedures (e.g., birthing, radiography).

Механик ор нь өвчтөн болон эмнэлгийн ажилтан гараар эргүүлэх хөшүүрэг болон бусад удирдлагаар орны гадаргуу, хэлбэрийг тохируулах механизмтай. Гудас (матрас) дэвсэх хэсэг нь гурав ба түүнээс дээш нугасан холбоотой хэсгээс бүрдсэн. Өвчтөний цээжийг өндийлгөсөн, өвдгийг босгосон, хөлийг буулгасан ((Гатт/Поулер байрлал)) байрлалаар тохируулах, нийтэд нь өндийлгөх, гудайлгах буюу өвчтөний бие тэгш байхад хөлийг өргөсөн эсвэл толгойг өргөсөн байрлалд оруулах (тренделенбург/Урвуу тренделенбург) боломжтой ор. Ихэнх механик ор салдаг эсвэл эвхэгддэг дагуу бариул, хашлагатай байх ба зарим тохиолдолд даавуун хөшигтэй байж болно. Механик орыг ихэвчлэн эмнэлэг, асрамжийн газар зэрэг эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх ба гэрт унтаж амрахад хэрэглэнэ. Мөн нөхөн сэргээх болон эмчилгээний (хувьсах даралттай) ба ажилбарын (төрөх, рентген зураг авах) зориулалтаар ашигладаг.



BEDS, FIXED, ORTHOPEDIC

ОР, ХӨДӨЛГӨӨНГҮЙ, ГЭМТЭЛ СОГОГ
СУДЛАЛЫН

UMDNS CODE 10360

Fixed beds designed for orthopedic treatment. These beds typically include a resting surface that has a permanent, fixed height and contour and one or more pre-attached traction (e.g., weights, pulleys) devices. Orthopedic fixed beds are mainly used in long-term treatment procedures due to illness or trauma (e.g., fractures).

Хөдөлгөөнгүй ор нь гэмтлийн эмчилгээнд зориулсан суурин ор. Ийм ор нь хөдөлгөөнгүй хэвтэх гадаргуу, тогтсон өндөр болон хүрээ, нэг эсвэл хэд хэдэн сунгах төхөөрөмжөөс /мөрнөөс татагч, түүхай/ бүтдэг. Гэмтлийн ор нь ихэвчлэн биеийн гэмтэл, ясны хугаралын үед удаан хугацааны эмчилгээнд зориулсан байдаг.



BRONCHOSCOPES

БРОНХОСКОП/УУШГИНЫ ДУРАН

UMDNS CODE 10491

Respiratory tract endoscopes designed to view the interior of the respiratory tract, particularly the trachea and the bronchi of the lungs for therapeutic or diagnostic purposes. These endoscopes usually consist of an outer sheath, a lighting system, and a working channel for catheters and operative devices; these endoscopes may be flexible or rigid. Therapeutic bronchoscopes (with operating channels) may be used to perform biopsies and laser surgery, remove foreign objects, aspirate fluids, and administer diagnostic agents or therapy using devices such as lasers, electrosurgical units, or surgical instruments. These endoscopes may be flexible or rigid.

Бронхоскоп нь амьсгалын замын дотор талыг ялангуяа гуурсан хоолой, бронхитын оношилгоо болон эмчилгээний зорилготой дуран юм. Дуран нь уян болон хатуу байх ба гадна бүрээс, гэрэлтүүлэх систем, гуурс болон ажилбарын багажуудад зориулсан ажлын сувагтай байдаг. Эмчилгээний бронхоскоп нь (ажилбарын сувагтай) эдийн шинжилгээ авах, лазер мэс заслын хутга, гадны биет авах, шингэнийг соруулах болон оношилгооны бодис эсвэл лазер болон цахилгаан коагуляц болон мэс заслын багажаар эмчилгээ хийхэд ашиглагдана. Эдгээр дуран нь уян болон хатуу байж болно.



CABINETS, TREATMENT, ULTRAVIOLET

КАБИНЕТ/ШҮҮГЭЭ, ЭМЧИЛГЭЭНИЙ,
ХЭТ ЯГААН ТУЯАНЫ

UMDNS CODE 10538

Cabinets with the interior walls lined with ultraviolet lamps to allow full body exposure with even distribution of ultraviolet radiation for the treatment of dermatological disorders.

Кабинет-шүүгээ нь дотор хананд хэт ягаан туяаны лампуудыг байрлуулж биеийн бүх хэсгүүдэд хүрэх хэт ягаан туяаны цацаргалтаар арьсны өвчин эмгэгийг эмчлэх зориулалттай.



CARDIAC OUTPUT UNITS

ЗҮРХНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРАЛТЫН ДОХИОНЫ ТӨХӨӨРӨМЖ

UMDNS CODE 10613

Instruments designed to measure the volume and flow rate of blood pumped by the heart. The measurements are typically displayed on the device in terms of liters and liters per minute respectively. These instruments typically include an electronic computerized unit, generators (e.g., radiofrequency, ultrasound), controls, a display, and appropriate sensors. Cardiac output is a vital indicator of overall cardiac status and the quality of tissue perfusion. There are several methods of measuring cardiac output, including thermal, impedance, radioisotope, dye dilution, and ultrasonic techniques.

Зүрхний үйл ажиллагааны төхөөрөмж нь зүрхэнд шахаж байгаа цусны эзлэхүүн ба урсгалын хурдыг хэмжих зориулалттай төхөөрөмж юм. Хэмжилтүүд нь ерөнхийдөө цусны хэмжээг 1 минутын туршид шахагдаж буй цусны литрийн эзлэхүүнээр дэлгэцэд харуулдаг. Эдгээр төхөөрөмж нь цахим компьютержуулсан хэсэг, үүсгүүр (ж.нь., радио долгион, хэт авиа), хяналт, дэлгэц болон шаардлагатай мэдрэгч элементийг багтаадаг. Зүрхний гаралтын дохио нь зүрхний ерөнхий байдал, эд эсийн эзлэхүүний чанарыг илэрхийлэх амин чухал үзүүлэлт юм. Эдгээр нь дулааны, эсэргүүцлийн, радиоизотоп, өнгө шингэрүүлэлт, хэт авианы арга техникийг багтаасан зүрхний гаралтын дохиог хэмжих хэд хэдэн аргатай байдаг.



CENTRIFUGES

ЦЕНТРИФУГ

UMDNS CODE 10778

Laboratory devices that apply centrifugal force to a specimen (e.g., suspended cells in a liquid), causing its separation according to component density. Centrifuge basic components are an electric motor, a shaft, and a rotor on which the centrifuge head turns. The two most common designs of rotors are fixed angle and horizontal or swinging bucket. Most cen-

Центрифуг нь лабораторийн сорьцонд (ж.нь., шингэн дэх түр зогссон эсүүд) төвөөс зугтах хүчээр нөлөөлөн бодисын нягтралын дагуу ялгах зориулалттай юм. Центрифугийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь цахилгаан хөдөлгүүр, гол, центрифугийн толгой эргэдэг ротор юм. Роторын хамгийн түгээмэл хоёр загвар нь хөдөлгөөнгүй зөөлөн ба хэвтээ эсвэл дүүжин хэлбэрийн байна. Ихэнх центрифуг нь хэд хэдэн солигддог

trifuges can operate with several interchangeable heads. Centrifugation of body fluids, commercial reagents, or mixtures of both with other additives is one of several sample preparation steps commonly required in the clinical laboratory before measuring analytes in a patient sample. The use of basket-style heads and draining-chamber inserts in some centrifuge models allows the continuous introduction of materials to be separated into the centrifuge until the basket is full (i.e., intermittent-flow mode); this mode is used to separate suspensions and emulsions.

толгойтой ажилладаг. Биеийн шингэн, нийтлэг урвалжын аль алинд нь бусад нэмэлт бодисуудыг холих үйл явц нь өвчтөний дээж дэхь анализуудыг шинжлэхийн өмнөх клиникийн лабораторид шаардлагатай хэд хэдэн дээж бэлтгэх энгийн үе шатуудын нэг юм. Сагс-хэлбэрийн толгой ба хатаах шүүгээний хэрэглээг зарим центрифугийн загварт нэвтрүүлсэнээр сагс дүүрэх хүртэл (ө.х тасралтгүй урсгалын горим) центрифуг руу ангилагдах материалыг тасралтгүй нэвтрүүлэх боломж олгоно. Энэ горим нь суспенз ба эмульсийг салгахад ашиглагддаг.



CENTRIFUGES, TABLETOP

ЦЕНТРИФУГ, ШИРЭЭНИЙ

UMDNS CODE 10780

Centrifuges designed to be mounted on a tabletop or bench and to process a small volume of specimens, possibly contained in a small number of test tubes. These centrifuges are typically compact, stationary structures and consist of an electric motor, a shaft, and speed and time controls; they also include a rotor on which one of several interchangeable heads is mounted. The rotor head includes slots into which tubes, cups, flasks, microplates, test tubes, and/or other sample holders can be fitted. The two most common rotor designs are fixed angle and swinging bucket (also known as horizontal). Tabletop-mount-

Центрифугийг ширээ эсвэл сандал дээр байрлуулж бага дээжтэй ажиллах зориулалттай ба цөөн тооны хуруу шилнүүд ашигладаг. Уг центрифуг нь авсаархан, хөдөлгөөнгүй бүтэцтэй бөгөөд цахилгаан мотор, гол ба хурд, цаг тохируулах удирдлага, олон төрлийн толгой солих боломжтой ротор зэргээс бүрдэнэ. Роторын толгой нь хуруу шил, аяга, колбо, микроплейт, тест хуруу шил ба бусад дээж баригчуудыг хийх боломжтой нүхнүүдтэй. Ротор нь бэхэлгээтэй ба дүүжин (хөндлөн гэдгээр нь сайн мэддэг) хоёр төрлийн ротор хамгийн их хэрэглэгддэг загвартай. Ширээн дээр суурилагддаг центрифуг нь бага хурд (10,000

ed centrifuges working at low speed (usually up to 10,000 rpm) and high speed (typically from 12,000 to 25,000 rpm) and ultracentrifuges with a speed usually between 30,000 and 120,000 rpm are available; some models have refrigerating capabilities to keep the rotor chamber cool. Tabletop centrifuges are used mainly in the clinical laboratory for a variety of procedures such as centrifugation of body fluids, reagents, or mixtures of both in preparation for analysis using other equipment.

эрг/мин хүртэл), өндөр хурд (12,000-25,000 эрг/мин хүртэл), хэт өндөр хурд (30,000-120,000 эрг/мин хүртэл) гэсэн хязгааруудад ажилладаг. Зарим загварууд нь роторын тасалгааг хөргөх боломжтой байдаг. Ширээний центрифуг нь биеийн шингэн, урвалж болон эдгээрийн холимгийг хурилдуулж анализ хийх бусад төхөөрөмжид бэлтгэж өгөх зэрэг олон зорилгоор голдуу клиник лабораториудад ашиглагддаг



CHAIRS, EXAMINATION/TREATMENT, DENTISTRY

САНДАЛ, ҮЗЛЭГ/ЭМЧИЛГЭЭНИЙ, ШҮДНИЙ

UMDNS CODE 10792

Examination/treatment chairs designed to facilitate dental examination, treatment, and/or minor surgical procedures. These chairs are typically adjustable up to a height that allows the healthcare staff to perform procedures while standing; the chairs usually include head- and armrests, a reclining back that may be tilted from a vertical to a horizontal or near-horizontal position, and rotating capabilities to facilitate examination and/or treatment. The chairs may be mechanically operated or hydraulic or electrically powered; some chairs can be programmed for several standard positions. Dental examination and/or treatment devices (e.g., lights, irrigation) may be partially or completely attached as integral components of the chair or may stand separately as self-supported, wall-mounted, or ceiling-suspended units (i.e.,

Үзлэг/эмчилгээний сандал нь шүдний эмчийн үзлэг, эмчилгээ, жижиг мэс ажилбарын үйл явцыг хөнгөвчлөх зориулалттай юм. Эдгээр сандал нь эмнэлгийн ажилтан зогсоо байрлалд ажилбар явуулах нөхцөлийг хангах зорилгоор өндөр тохируулагчтай байдаг. Сандал нь ихэвчлэн толгой, гарын түшлэгтэй байх ба нурууны түшлэгийг босоо, хэвтээ, эсвэл хагас хэвтээ байрлалд шилжүүлэх боломжтой байдаг. Түүнчлэн үзлэг болон эмчилгээний ажилбарыг хөнгөвчлөх үүднээс эргэлддэг суурьтай байна. Сандал нь механик ажиллагаатай эсвэл гидравлик болон цахилгаанаар ажилладаг байж болно. Зарим төрлийн сандал нь хэд хэдэн стандарт байрлалыг шууд сонгохоор програмчлагдсан ба шүдний үзлэг болон эмчилгээний төхөөрөмж (тухайлбал, гэрэл, усан хангамж) нь сандлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж хэсэгчилсэн эсвэл бүтэн байдлаар

dental delivery units); dental delivery systems including a suspended patient chair are also available.

суурилагдсан байна. Мөн бие даасан, хананд болон таазанд бэхлэгддэг төхөөрөмж (жишээ нь, шүдний эмчилгээний үндсэн төхөөрөмж) зэрэг салангид хэлбэрээр суурилагдсан байдаг. Шүдний эмчилгээний системд өвчтөний сандалыг багтаасан байхыг шаарддаг.



CHOLEDOCHOSCOPES

ХОЛЕДОЧОСКОП /НОЙР БУЛЧИРХАЙН ДУРАН

UMDNS CODE 10831

Endoscopes designed for insertion into the biliary tract for visual examination, biopsy, removal or crushing of stones, and treatment of lesions of the interior of the pancreaticobiliary tree, especially of the common bile duct. Choledochoscopes usually include a lighting system and a working channel for catheters and operative devices. These endoscopes are typically flexible, and they may be inserted percutaneously, during laparoscopic procedures, or through the duodenum (transduodenal). Therapeutic choledochoscopes (with operating channels) may be used to perform biopsies, electrosurgery, and other procedures, such as fragmenting and removing stones.

Чоледочоскоп нь нойр булчирхайн салаануудын дотор үүссэн эмгэгийг эмчлэх, ялангуяа цөс дамжуулах сувгийн үзлэг, биопси шинжилгээ авах, цөсний хүүдийн чулууг зайлуулах, бутлах зэрэг цөсний хүүдийн сувгийн эмгэгийг эмчлэх зорилготой дуран юм. Чоледочоскоп нь ихэвчлэн гэрэлтүүлгийн систем, катетер болон ажилбарын төхөөрөмжүүдэд зориулагдсан ажлын суваг зэргээс бүрддэг. Эдгээр нь ихэвчлэн уян дуран байдаг бөгөөд тэдгээрийг дурангийн ажилбараар эсвэл 12 нугалаа гэдсээр дамжуулан (нарийн гэдсээр дамжуулах) нэвтрүүлэх боломжтой байдаг. Эмчилгээний Чоледочоскоп дуран нь (ажилбарын суваг бүхий) биопси шинжилгээ авах, цахилгаан мэс засал, чулууг зайлуулах бутлах зэрэг бусад ажилбарыг гүйцэтгэдэг.



COLONOSCOPES

КОЛОНОСКОП/БҮДҮҮН ГЭДЭСНИЙ ДУРАН

UMDNS CODE 10950

Flexible endoscopes designed for direct insertion through the rectum in the lower gastrointestinal tract for visual examination, biopsy, and treatment of lesions of the interior of the colon; some of these devices can be used for the entire large intestine. Colonoscopes usually consist of a flexible outer sheath, a lighting system, and a working channel for catheters and operative devices.

Бүдүүн гэдэсний уян дуран Колоноскоп нь шулуун гэдсээр дамжуулан хоол боловсруулах доод замыг харж шинжлэх, эдийн шинжилгээ авах, гэдэс доторх эмгэг үүсгэгчийг авахад зориулагдсан. Колоноскоп нь гадна уян бүрхүүл, гэрэлтүүлэх систем, катетер болон эмчилгээний багажнуудад зориулсан ажлын сувагтай байдаг.



COLPOSCOPES

КОЛЬПОСКОП

UMDNS CODE 10960

Specula designed for the examination of the vagina that permit a direct view of the tissues of the vagina and cervix. Colposcopes usually include an illumination system and magnifying lenses, which allow better examination of the vagina than a common vaginal specula.

Кольпоскоп нь үтрээний болон умайн хүзүүний эд эсийг шууд шалган үзэхэд тохиромжтой үтрээний үзлэгт зориулсан толь юм. Кольпоскоп нь ихэвчлэн гэрэлтүүлгийн систем болон томруулагч линзээс бүрддэг бөгөөд энэ нь энгийн үтрээний үзлэгийн тольноос илүү сайн шинжлэх шалгах боломжийг олгодог.



COMPRESSORS

КОМПРЕССОР/ ШАХАГЧ

UMDNS CODE 10971

Instruments or accessories designed for pressing a body part, closing a gap, and/or diminishing its volume and augmenting its density. Some compressors are used to flatten body parts in order to improve the resolution of radiographic procedures; other are instruments used to compress organs or other anatomic structures (e.g., veins).

Компрессор нь биеийн хэсгүүдийг шахах, зайгаах, эзлэхүүнийг багасгах, нягтыг ихэсгэх зориулалттай. Зарим компрессор нь рентген зургийн нарийвчлалыг сайжруулахын тулд биеийн хэсгүүдийг тэгшлэхэд хэрэглэгддэг. Харин зарим багаж нь эд болон зарим анатомийн бүтэц(жишээ нь: вен)-ийг шахахад хэрэглэгдэнэ.



COMPRESSORS, MEDICAL-AIR

КОМПРЕССОР, ЭМНЭЛГИЙН ХИЙН

UMDNS CODE 10972

Compressed air system components that are used to mechanically compress atmospheric air.

Атмосферын агаарыг механикаар шахахад ашигладаг агаарыг шахах системийн бүрэлдэхүүн хэсгүүд.



POSITIVE AIRWAY PRESSURE UNITS,
CONTINUOUS

ЭЭРЭГ АГААРЫН ДАРАЛТААР ХАНГАХ
ТӨХӨӨРӨМЖ, ТАСРАЛТГҮЙ

UMDNS CODE 11001

Devices designed to apply continuous positive airway pressure during both inspiration and expiration while the patient is performing spontaneous breathing. Continuous positive airway pressure (CPAP) units typically consist of a pressurized circuit including a threshold resistor, such as an underwater seal, a weighted ball, or a spring-loaded valve. A threshold resistor is a device that exerts a predictable, quantifiable, and constant force at the expiratory limb, cre-

Тасралтгүй эерэг агаарын даралтын (CPAP) төхөөрөмж нь өөрийн амьсгалыг удирдах үеийн амьсгал авалт гаралтын аль ч үед тасралтгүй эерэг агаарын даралтаар хангах зориулалттай. Ихэвчлэн уснаас хамгаалсан битүүмж, хүндрүүлэгч бөмбөлөг буюу пүрштэй хавхлаг зэрэг даралтын хязгаар тохируулагч бүхий даралтат хэлхээнээс бүрдэнэ. Даралтын хязгаар тохируулагч гэдэг нь хийн гарах хэсэгт урьдчилан тодорхойлж болох, тоо хэмжээтэй, тогтмол даралт үүсгэх зориулалттай.

ating a threshold pressure that must be exceeded to allow flow through the valve. The units also include a high-flow gas source and a mask to deliver the pressurized air to the patient; many devices include a manometer. CPAP units usually maintain a baseline airway pressure of 5 to 20 cm of H₂O throughout the whole respiratory cycle; the devices require a gas flow greater than the patient inspiratory flow to maintain the desired positive airway pressure. These units are intended to provide noninvasive positive pressure breathing assistance therapy through a mask (either nasal or oronasal), a mouthpiece, or lip-seal; they are frequently used to treat central sleep or obstructive apnea disorders. They are not intended for continuous breathing support.

Үүссэн хязгаарлагдмал даралт нь хавхлагаар дамжин зөвшөөрөгдсөн хэмжээнээс ихгүй урсгалыг бий болгоно. Эдгээр төхөөрөмж нь өндөр урсгалт хийн эх үүсвэр, даралттай агаарыг өвчтөнд хүргэх маск болон манометртэй байдаг. CPAP төхөөрөмж нь амьсгалын бүх мөчлөгийн туршид 5 - 20 см H₂O агаарын үндсэн даралтаар дэмжлэг үзүүлнэ. Төхөөрөмж нь амьсгалын замын урсгалын хүссэн эерэг даралтыг хадгалахын тулд өвчтөний амьсгал авалтын урсгалын хэмжээнээс илүү хийн урсгалыг шаарддаг. Төхөөрөмжийг нойрны эсвэл амьсгал зогсох эмгэгүүдийн үед ихэвчлэн маск (хамрын болон ам хамрын хөндийн хамарсан), амны хаалт, эсвэл жийргэвчээр дамжуулан эерэг даралтаар амьсгал дэмжих инвазив бүс эмчилгээнд ашиглана. Эдгээр нь тасралтгүй амьсгалаар дэмжлэг үзүүлэх зориулалтгүй болно.



CRYOSURGICAL UNITS,
GENERAL-PURPOSE

КРИО МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ,
ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН

UMDNS CODE 11067

Cryosurgical units designed for use in general surgical procedures, such as in dermatology, oral surgery, gynecology, urology, otolaryngology, and proctology.

Криомэс заслын аппарат нь арьс судлал, амны хөндийн мэс засал, эмэгтэйчүүд, бөөр судлал, чих хамар хоолой, проктологи зэрэг ерөнхий мэс заслын процедурт ашиглах зориулалттай төхөөрөмж.



CRYOSURGICAL UNITS, OPHTHALMIC

КРИОМЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ, НҮД СУДЛАЛЫН

UMDNS CODE 11068

Cryosurgical units designed for applying extreme cold to eye tissues to destroy abnormal cells. These units usually consist of a hollow probe (cryoprobe) that circulates a cryogenic substance (e.g. liquid nitrogen) to form an ice crystal ball around the cells, which freezes the cells of the tissues with which it comes into contact. Ophthalmic cryosurgical units are used mainly to treat eye tumors (e.g., retinoblastoma), to relieve ingrown eyelashes (trachiasis), for cryoextraction of intracapsular cataracts, and/or to repair retinal detachment.

Крио мэс заслын төхөөрөмж нь нүдний эдийг хэт хүйтэн болгож хэвийн бус эсийг устгах зорилготой. Ерөнхийдөө эдийн хөлдсөн эсүүдтэй холбогдсон эсүүдийн эргэн тойронд байх мөсөн талст бөмбөлөг хэлбэрт креогент бодис (жишээ нь, шингэн азот)-ыг эргэлдүүлдэг хөндий сувгаас бүрддэг. Нүдний крио мэс заслын төхөөрөмж нь нүдний хавдар (ж.нь, retinoblastoma)-ыг эмчлэх, нүд рүү дотогш ургасан сормуус (trachiasis)-ыг авах, дотоод бүрхэвчний катарактыг крио аргаар сугалан авах, болон/эсвэл торлог бүрхэвчийг тусгаарлалтыг засах зорилгоор ашигладаг.



CULDOSCOPIES

КУЛДОСКОП/ САВНЫ АМСРЫН ДУРАН

UMDNS CODE 11079

Endoscopes designed for direct insertion through the fundus of vagina (i.e., posterior vaginal fornix) into the peritoneal cavity for visual examination, biopsy, and treatment of lesions of the cavity and organs located in it, especially those in the rectovaginal pouch and the pelvic viscera. Culdoscopes usually consist of an outer sheath, a lighting system, and a working channel for catheters and operative devices; these endoscopes may be rigid or flexible.

Кулдоскоп нь умайн дээд ёроолоор дамжуулан хэвлийн гялтанд хүрч цааш бүдүүн шулуун гэдэсний наалдац, аарцагийн хөндийн шинжилгээг дэлгэцээр харуулах, сорьц авах, хөндийт хэсгээр дамжуулан гэмтлийг эмчлэх мэс заслын үед хэрэглэгддэг дуран юм. Гадаад хэсэг, оптик систем, катетер оруулах ба бусад мэс заслын хэрэгсэл оруулах ажлын сувгаас тогттог.



CYSTOSCOPES

ЦИСТОСКОП/ ДАВСАГНЫ ДУРАН

UMDNS CODE 11112

Urinary tract endoscopes designed for visual examination, biopsy, removal or crushing of stones, and treatment of lesions of the urethra and urinary bladder. They usually consist of an outer sheath, an optical system, and a working channel for catheters and operative devices. Flexible and rigid

Цистоскоп нь давсаг, шээсний суваг болон давсагны эмчилгээ, давсагны чулуу авах, сорьц авах, дурандаж харахад зориулсан дуран бол Цистоскоп юм. Гадаад хэсэг, оптик систем, катетер оруулах ба бусад мэс заслын хэрэгсэл оруулах ажлын сувгаас тогттог.



CYSTOURETHROSCOPES

ЦИСТОУРЕТЗОСКОП/ДАВСАГ СУВНИЙ ДУРАН

UMDNS CODE 11114

Urinary tract endoscopes for visual examination, biopsy, removal or crushing of stones, and treatment of lesions of the urinary bladder and posterior urethra. They usually consist of an outer sheath, an optical system, and a working channel for catheters and operative devices.

Цистоуретзоскоп нь давсаг, шээсний суваг болон давсагны эмчилгээ, давсагны чулуу авах, сорьц авах, дурандаж харахад зориулсан. Гадаад хэсэг, оптик систем, катетер оруулах ба бусад мэс заслын хэрэгсэл оруулах ажлын сувгаас тогтдог.



DEFIBRILLATORS

ДЕФИБРИЛЛЯТОР

UMDNS CODE 11132

Cardiac electrical stimulators that apply brief high-voltage electroshocks to the heart. These stimulators are used to restore normal rhythm and contractile function in patients who are experiencing ventricular fibrillation or ventricular tachycardia that is not accompanied by a palpable pulse. Some defibrillators may also be used to correct certain non-critical dysrhythmias (called synchronized defibrillation or cardioversion), using relatively low-level discharges synchronized to the patient's ECG waveform.

Зүрхний цахилгаан өдөөгч симулятор нь зүрхэнд богино хугацаанд өндөр чадлаар цахилгаан шок өгөх зориулалттай. Энэ өдөөгч төхөөрөмж бол Дефибриллятор. Зүрхний ховдлын фибриляци буюу ховдлын тахикардитай өвчтөний зүрхний булчингийн агшилтын үйл ажиллагаа алдагдсан, зүрхний хэм алдагдсан үед хэвийн хэмнэл, булчингийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор ашиглагддаг. Зарим Дефибрилляторыг тодорхой эрсдэл багатай хэм алдалтыг эмчлэхэд ашигладаг (синхрончлогдсон Дефибриллятор буюу цахилгаанаар зүрхний үйл ажиллагааг сэргээх гэж нэрлэдэг) бөгөөд харьцангуй бага түвшингийн цэнэгийн тусламжтайгаар өвчтөний ЭКГ бичлэгийн долгионыг синхрончилдог.



DEFIBRILLATORS, EXTERNAL, MANUAL

ДЕФИБРИЛЛЯТОР, ГАДНА ТАЛЫН, ГАР
АЖИЛЛАГААТАЙ

UMDNS CODE 11134

External defibrillators that require the operator to observe the ECG waveform, confirm ventricular fibrillation, and perform the necessary operations to charge the capacitors to the appropriate voltage and discharge the stored energy through the paddles into the patient. Manual external defibrillators are typically battery operated, but most devices may also be operated from line power. Most of these defibrillators include an electrocardiographic monitor as an integral part; those defibrillators that do not include a monitor should be used with an ECG monitor or electrocardiograph to assess whether the abnormal cardiac rhythm may be corrected with an electric shock (i.e., to identify a "shockable" rhythm).

Дефибриллятор /гадна талын/ нь ЭКГ бичлэгийн долгионы хэлбэрийг ажиглах, зүрхний ховдлын фибрилляцийг баталгаажуулах, конденсаторт зохих хүчдлийг цэнэглэж, электродоор дамжуулан нөөцөлсөн энергийг өвчтөнд шилжүүлж шаардлагатай ажиллагааг гүйцэтгэдэг. Гар ажиллагаатай Дефибриллятор нь ихэвчлэн батарейгаар ажилладаг боловч ихэнх төхөөрөмж нь цахилгаанаар ажиллах боломжтой байдаг. Эдгээр Дефибрилляторын дийлэнх нь зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын хяналтын дэлгэцийг бүрэлдэхүүн хэсэг болгон багтаасан байдаг. Хяналтын дэлгэцгүй ийм төрлийн Дефибрилляторыг нэмэлт ЭКГ хяналтын дэлгэц эсвэл ЭКГ бичлэгийн төхөөрөмжтэй хамтатган зүрхний цохилтын хэвийн бус хэмнэлийг засч хэвийн болгоход ашигладаг (жишээ нь "шокод орсон" хэмнэлийг тодорхойлох).



DERMABRASION UNITS

ДЕРМАБРАС/АРЬСНЫ ГАЖИГ ЗАСАХ АППАРАТ

UMDNS CODE 11177

Mechanical devices such as wire brushes or emery paper cylinders that are used to plane the skin (surgical removal of the epidermis and as much of the dermis as necessary) to remove scars, tattoos, pigmented nevi, fine wrinkles, or other irregularities of the skin.

Дермабрас нь шарх, шивээс, пигментжсэн неви, нарийн үрчлээс, арьсны бусад хэвийн бүс байдлыг арилгах аппарат. Мөн арьсыг цэвэрлэхэд хэрэглэдэг утас, сойз буюу емери цаасан цилиндр зэрэг механик төхөөрөмж (арьсны эпидерми болон мэс засалд шаардлагатай хэрэгсэл).



HEMODIALYSIS UNITS

ГЕМОДИАЛИЗИЙН АППАРАТ

UMDNS CODE 11218

Equipment designed to perform hemodialysis, a treatment intended to remove large amounts of water, toxins, and wastes from the blood. Typically blood is taken via an extracorporeal circuit, passed through an extracorporeal dialyzer to decrease biochemical abnormalities as well as fluid, electrolyte, and acid-base imbalances, and then returned to the patient. Hemodialysis units are used mainly for partial substitution of the kidney (i.e., renal) or liver (i.e., hepatic) function; they are also used to treat other acute diseases.

Гемодиализийн аппарат нь осмосын хуульд үндэслэсэн ба диализатор хэмээх шүүлтүүрийн түслэмжтайгаар хорт бодисуудыг ялган авч цусыг цэвэршүүлдэг, жишээ нь бөөрний үйл ажиллагааг орлуулж ажилладаг аппарат юм. Өвчтөний цусыг магистраль буюу цусны гуурсаар диализаторт өгч диализаторын шингэнээр шүүж эмчилгээг явуулдаг. Энэ аппарат нь цусны урсгалын хурд, цус шингэрүүлэгч, гепарины насосын ажиллагаа, цусны оролтын даралт, агаар мэдрэгч, уусмалын концентраци, урсгалын хурд, температур зэргийг хянаж ажилладаг мэдрэмтгий автомат төхөөрөмж юм. Гемодиализ аппарат нь бөөр орлуулах, элэгний үйл ажиллагааг орлох эмчилгээнд ихэвчлэн хэрэглэнэ.



PERITONEAL DIALYSIS UNITS

ХЭВЛИЙН ХӨНДИЙН ДИАЛИЗЫН ТӨХӨӨРӨМЖ

UMDNS CODE 11226

Devices designed to remove metabolic wastes through selective diffusion across the peritoneum by controlling the flow of a specially designed solution (i.e., a dialysate) into and out of the abdominal cavity (i.e., peritoneal dialysis). These devices consist of a machine that performs automated dialysis cycles, typically while the patient sleeps, by controlling the flow of dialysate. Peritoneal dialysis units infuse and remove dialysate by means of a catheter and a sterile disposable tubing system. A temporary catheter, or more frequently a permanently implanted abdominal catheter, provides access to the peritoneal cavity. Peritoneal dialysis is used less frequently than hemodialysis, it is especially indicated for patients who are unable to tolerate hemodialysis (e.g., the elderly, and patients with diabetes and/or other vascular cardiovascular conditions).

Хэвлийн хөндийгөөс (жишээ нь: хэвлийн диализ) гарах болон орох тусгай шингэний (жишээ нь, диализат) урсгалыг хянах, цоройгоор бодисын солилцооны хог хаягдлыг арилгах зориулалттай төхөөрөмж юм. Эдгээр төхөөрөмж нь диализын урсгалыг хянах замаар үйлчлүүлэгчийг унтаж байх үед диализийн эргэлтийг автоматаар хийх төхөөрөмжөөс бүрднэ. Хэвлийн диализын төхөөрөмж нь катетер болон ариутгасан нэг удаагийн гуурсаар дамжуулан диализатын шингэнийг оруулах ба буцаан гаргана. Процедурын явцад түр зуурын болон байнгын хэвлийн хөндийд байлгах зориулалтын катетеруудыг ашиглан хэвлийн хөндийг цэвэрлэнэ. Хэвлийн диализ нь гемодиализаас хавьгүй бага ашиглагддаг бөгөөд энэ нь ялангуяа гемодиализыг тэсвэрлэх чадваргүй үйлчлүүлэгчийн эмчилгээнд зориулагдсан (жишээ нь, ахмад настан, чихрийн шижинтэй өвчтөн болон бусад зүрх судасны эмгэгтэй өвчтөнүүдэд).



DISINFECTORS

ДИСИНФЕСТОР/ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭГЧ

UMDNS CODE 11278

Equipment designed to kill or inactivate many microorganisms (e.g., fungi, viruses, bacteria) from instruments, containers, and other clinical devices and utensils, automatically or semiautomatically. These disinfectors typically kill many microorganisms including mycobacterium, all fungi, and small nonlipid viruses (providing low-level and medium-level disinfection); some disinfectors can also kill spore-forming bacteria (except when there is a large number) but not the spores, providing a high-disinfection level (near-sterile disinfection). This equipment typically uses temperature cycles of less than 100°C or immersion in sterilants for periods of time not sufficient to completely sterilize the devices. Disinfectors are used to inactivate microorganisms in medical devices when complete sterilization is not needed or justified. Dedicated disinfectors using vaporized germicidal (i.e., formalin, oxygen peroxide) solutions to disinfect closed containers are also available.

Дисинфестор нь эмнэлгийн багаж, төхөөрөмж, сав суулга болон бусад клиник төхөөрөмж, багаж хэрэгслээс олон төрлийн идэвхит бичил биетнийг (жишээ нь, мөөгөнцөр, вирус, бактери) устгах, идэвхгүй болгоход зориулагдсан автомат болон хагас автомат халдваргүйжүүлэгч байдаг. Эдгээр халдваргүйжүүлэгч нь ихэвчлэн микробактери, бүх төрлийн мөөгөнцөр, жижиг уурагт-бус нян (олон түвшинд, дунд түвшинд ариутгахад хангалттай) зэрэг олон төрлийн бичил биетнийг устгадаг. Түүнчлэн толбо үүсгэгч бактерийг (олон тоогоор байдгаараа ялгаатай) устгах боловч өндөр түвшиний ариутгал шаарддаг толбо үүсгэдэггүй нянг устгахгүй (ойролцоо түвшний ариутгал халдваргүйжүүлэлт). Энэ төхөөрөмж нь ихэвчлэн 100-аас бага цельсийн температурт цикл халдваргүйжүүлэлтийг хийх ба энэ нь төхөөрөмжүүдийг бүрэн ариутгах хугацаанд хангалтгүй байдаг. Халдваргүйжүүлэгчүүдийг бүрэн халдваргүйжүүлэлт шаардлагагүй эсвэл шаардлагатай үед эмнэлгийн багаж хэрэгсэл дэхь идэвхит бичил биетнийг идэвхгүйжүүлэхэд ашигладаг. Тусгайлсан халдваргүйжүүлэгч нь битүү сав суулгыг халдваргүйжүүлэхэд ууршдаг гематив (жишээ нь, формалин, хүчилтөрөгчийн хэт ислийг) уусмалуудыг ашигладаг.



HAND DRILLS, SURGICAL, BONE

ГАР ӨРӨМ, МЭС ЗАСЛЫН, ЯСНЫ

UMDNS CODE 11331

Hand drills used during orthopedic surgical procedures involving the bones. These devices consist of a manually propelled or powered (e.g., electric, pneumatic) instrument that typically includes a chuck and other detachable components such as drill bits and reamers; some bone drills are used with special guides and/or over a guide wire. Manual hand drills may include an integral drill bit for a particular use (e.g., intramedullary reaming); battery operated electric drills provide autonomous operation without connection to external power sources. Bone surgical hand drills frequently include special guides and/or work over a pin or guide wire (i.e., cannulated hand drills); they are used for a variety of purposes, including placement of implants and implantable prostheses and the fixation of bones using plates, bolts, pins, and other components.

Гар өрөм нь гэмтлийн мэс заслын үед ясыг нүхлэх зориулалттайгаар ашигладаг. Энэ төхөөрөмж нь солигдож болох патрон болон бусад төрөл бүрийн толгой, өргөсгөгч хэсгүүд, зарим өрөм нь тусгай чиглүүлэгчийг давхар ашиглагддаг зэрэг гар болон цахилгаан (жишээ нь цахилгаан, пневматик) багажнаас бүрдэнэ. Гар ажиллагаатай өрөм нь тусгай зориулалтын хошуутай байж болно (жишээ нь модуль дотор өргөсгөгч); батарейгаар ажиллах цахилгаан өрөм нь цахилгаан тэжээлд залгахгүйгээр ажиллана. Мэс заслын гар ажиллагаатай өрөм нь янз бүрийн чиглүүлэгч болон чиглүүлэгч дамжуулагчийг (жишээ нь гар ажиллагаатай сүвгийн өрөмтэй); тэдгээрийг имплант, протезийг суулгах, ясыг ялтас, болт, шаант болон бусад эд зүйлсийн тусламжтай бэхлэхэд зориулагдсан.



DUODENOSCOPES

ДУОДЕНОСКОП/ХОДООДНЫ
УЯН ДУРАН

UMDNS CODE 11359

Flexible endoscopes designed for direct insertion through the mouth in the upper gastrointestinal tract for visual examination, biopsy, and treating lesions of the interior of the proximal portion of the small intestine from pylorus to the jejunum (i.e., duodenum).

Дуоденоскоп нь шууд амаар дамжин биед нэвтэрч ходоод гэдэсний замын дээд хэсэгт үзлэг хийх, биопсийн шинжилгээ авах, ходоодны амсараас 12 нугалаа гэдэс хүртэлх ходоодны проксималь хэсэгт үүссэн эмгэгийг эмчлэх зориулалттай. Ходоодны уян дуран болох Дуоденоскоп нь

Duodenoscopes usually consist of a flexible outer sheath, a lighting system, and a working channel for catheters and operative devices.

ихэвчлэн уян хатан гадаргуу, гэрэлтүүлгийн систем болон ажилбарын төхөөрөмжүүд болон катетерт зориулсан ажлын сувгуудаас бүрдэнэ.



SIMULATORS, CARDIAC,
ELECTROCARDIOGRAPHY

СИМУЛЯТОР, ЗҮРХНИЙ, ЗҮРХНИЙ
ЦАХИЛГААН БИЧЛЭГИЙН АППАРАТ

UMDNS CODE 11381

Биологийн ямар нэг объектийн дотоод бүтэц эд эсийг нарийвчлан судалдаг аппаратыг микроскоп гэдэг. Микроскоп нь нүдэнд үл харагдах (цусны дүрст элемент, нян) объектийг линзийн тусламжтайгаар хэд дахин томруулж задлан шинжилгээ хийдэг. Ялангуяа оношилгоо, мэс заслын дараах үзлэг зэрэг фокусыг тохируулах эсвэл өндөр өсгөлттэйгөөр харах шаардлагатай шинжилгээнд хэрэглэхэд тохиромжтой. Микроскоп нь хоёр үндсэн хэсэг болох Оптик болон механик хэсгээс бүрддэг. Арьсны үзлэгийн микроскоп нь ихэвчлэн эмчийн өрөөнд арьсны өвчнийг оношлох, шарханд үзлэг хийх зэрэгт хэрэглэгдэх ба цөөн тохиолдолд жижиг мэс ажилбарт хэрэглэгдэх боломжтой.

ELECTROSURGICAL UNITS, MONOPOLAR,
ARGON-ENHANCED COAGULATION

ЦАХИЛГААН МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ, НЭГ
ТҮЙЛТ, АРГОН- ЭРЧИМЖҮҮЛСЭН, КОАГУЛЯЦ

UMDNS CODE 17739

Monopolar electrosurgical units (ESU's) that are equipped with a system (typically either housed in a separate mobile cart or incorporated into the ESU generator housing) for delivery of argon gas. The electrosurgical current forms an ionized channel, or arc, within an argon gas stream that flows between the active electrode and the tissue surface. The argon-enhanced ESU can provide rapid, uniform coagulation over large bleeding surfaces such as capillary beds.



Мэс заслын өндөр давтамжийн аппарат (Electrosurgical Unit-ESU)-ын зориулалт нь хэвийн нөхцөлд мэс заслын үед өндөр давтамжийн гүйдлээр зөөлөн эд эсэд зүсэлт хийх венийн жижиг судсуудыг коагуляцлах үйлдлүүдийгнэгэн зэрэг гүйцэтгэдэг. Цахилгаан мэс заслын аппарат нь хүний биеийн зөөлөн эдийн мэс заслын үе дэх хүндрэл гэмтлийг (цус алдалт) багасгаж түргэн шуурхай авах боломжийг олгосон. Энэ нь зөвхөн мэс заслын үед хэрэглэгдэнэ. Нэг түйлт мэс заслын цахилгаан төхөөрөмж (ESU) нь аргон хийг дамжуулах системээр тоноглогдсон байна. Уг систем нь ихэвчлэн зөөврийн тэргэнцэрт эсвэл төхөөрөмжийн генераторт байрлана. Аргоноор баяжуулсан цахилгаан мэс заслын төхөөрөмж (ESU)-ийг хялгасан судаснууд мэт томоохон хэмжээний гадаргуугаас цус алдах үед цус тогтоох зэрэгт түгээмэл ашигладаг.

ANALYZERS, LABORATORY, HEMATOLOGY

АНАЛИЗАТОР, ЛАБОРАТОРИЙН,
ГЕМОТОЛОГИ

UMDNS CODE 17740

Laboratory analyzers designed to determine the morphology of the blood and blood-forming cells. These analyzers are used to perform complete blood counts, determine hemoglobin concentration, evaluate the adhesion of cells to one another (aggregation), detect abnormalities in the process to complete normal blood clotting (coagulation), and/or perform ABO grouping and subgrouping, Rh and other red cell phenotyping, and antibody detection.

Анализатор нь цусны морфологи болон цусны дүрст эсүүдийг тодорхойлох зориулалттай. Энэ анализаторыг цусны ерөнхий шинжилгээ хийх, гемоглобины агууламжийг тодорхойлох, эсийн нэг нэгэндээ наалдах шинж чанарыг тогтоох (хуримтлал), цусны хэвийн нөжрөлт үүсэх үйл явц дахь эмгэгийг бүртгэх (цусны бүлэгнэлт) ба/буюу цусны бүлэг болон дэд бүлгийг тодорхойлох, Rh болон бусад улаан эсийг ялгах болон эсрэг биеийн ирлүүлэлт зэрэгт ашигладаг.



ANALYZERS, LABORATORY, HEMATOLOGY, CELL COUNTING, AUTOMATED

АНАЛИЗАТОР, ГЕМАТОЛОГИ, ЭС
ТООЛОГЧ, БҮРЭН АВТОМАТ

UMDNS CODE 17741

Hematology analyzers that require minimal involvement of technicians, with complete automation of sampling and dilution, cell counting, and red blood cell index determination; some include closed-tube sampling to automatically extract the blood sample from the phlebotomy tube. Most of these analyzers are based on fluorescence quantification and cytometry techniques or on electrical impedance (Coulter) techniques. Some automated hematology analyzers perform a three-part white blood cell differential count, while most provide a five-part count, differentiating all five types of normal white blood cells. Automated cell-counting hematology analyzers may include reticulocyte analysis capabilities.



Гематологийн анализатор нь дээжийг ялгах, шинжлэх, эсийг тоолох болон цусны улаан эсийн индексийг тодорхойлох үйл явцыг бүрэн автоматжуулсанаар лабораторийн техникчийн оролцоог эрс багасгасан байдаг. Зарим нь венийн судаснаас цусны дээжийг автоматаар гарган авч дээжилдэг хаалттай хуруу шилнүүдтэй байдаг. Ихэнх анализатор нь флюоресцент тоон хэмжилт, цитометрийн арга болон цахилгааны эсэргүүцэл (Култер) арга дээр үндэслэгддэг. Зарим бүрэн автомат гематологийн анализатор нь цагаан эсийг гурван-бүлэгт ангилах дифференциал тоололт, түүнчлэн цусны энгийн цагаан эсүүдийн бүх таван төрлийг ангилах таван-бүлэгт тоололтыг хийдэг. Бүрэн автомат эс тоологч гематологийн анализатор нь ретикулоцит шинжилгээг хийх боломжтой байдаг.

ANALYZERS, LABORATORY, HEMATOLOGY, CELL COUNTING, SEMIAUTOMATED

АНАЛИЗАТОР, ГЕМАТОЛОГИ, ЭС
ТООЛОГЧ, ХАГАС АВТОМАТ

UMDNS CODE 17742

Hematology analyzers that require the reduced involvement of a technician, using automation in some discrete steps of test procedures, such as sampling and dilution, cell counting, and red blood cell index determination. Most semiautomated hematology analyzers also perform a three-part white blood cell differential count.

Гематологийн анализатор нь дээжийг ялгах, шинжлэх, эсийг тоолох болон цусны улаан эсийн индексийг тодорхойлох зэрэг сорилын үйл явцын зарим салангид алхамыг автоматжуулсанаар лабораторийн техникчийн оролцоог багасгадаг. Ихэнх гематологийн хагас автоматжуулсан анализатор нь цагаан эсийг гурван-бүлэгт ангилах дифференциал тоололтыг хийдэг.



SCANNING SYSTEMS, ULTRASONIC,
INTRAVASCULAR

СКАН СИСТЕМ, ХЭТ АВИАН,
ИНТГАВАСКУЛЯР

UMDNS CODE 17746

Scanning systems that include an ultrasonic scanner, high-frequency (typically 20 and 30 MHz) miniature transducers mounted on the tip of a catheter, intravascular analysis package software, an image recorder (e.g., videocassette), and a printer. Some systems include color-flow mapping capabilities. Intravascular ultrasonic scanning systems produce 360-degree (cross-sectional) images of blood vessels for diagnostic and therapeutic applications, including the identification of arterial plaque and vessel lesions, the measurement of vessel dimensions and stenosis, the monitoring of balloon angioplasty and atherectomy procedures, and the deployment of intravascular stents.

Скан систем нь катетерын үзүүрт байрлуулсан өндөр давтамжтай (ихэвчлэн 20 ба 30 МГц) жижиг хэмжээний трансдюсер хувиргагч, судасны дотоод оношилгоонд зориулагдсан програмын багц, дүрс бичлэгийн төхөөрөмж (жишээ нь, видеокассет), болон принтер зэргийг багтаасан хэт авиан скан төхөөрөмж юм. Зарим систем нь цусны урсгалыг өнгөөр ялган харуулах боломжтой байдаг. Судасны дотоод оношилгооны хэт авиан сканерт систем нь артерын судасны бөглөрөл зэрэг судасны эмгэгүүдийн тодорхойлолт, судасны чиглэл, нарийсалтын хэмжилт, бөмбөлөгт аргаар судас солих, судасны хана тэлэх болон судсанд стент байрлуулах ажилбаруудад хяналт хийх зэрэг оношилгоо, эмчилгээний зориулалтаар судасны 360 хэмт дүрслэлийг (хөндлөн огтлол) бий болгох систем юм.



DEFIBRILLATOR/PACEMAKERS, EXTER-
NAL

ДЕФИБРИЛЛЯТОР/ПЕЙСМЕЙКЕР,
ГАДНА ТАЛЫН

UMDNS CODE 17882

Defibrillator-pacemakers that generate electric impulses outside the body and deliver them to the heart through the chest wall using paddles (or electrodes). These devices typically include an electrocardiographic monitor and two large-surface, conductive, disposable adhesive electrodes that conduct the electrical stimuli through the skin and skeletal muscle to the heart. External defibrillator-pacemakers allow defibrillators to be used in the emergency temporary treatment of asystole, severe bradycardia, implantable pacemaker failure, certain types of tachycardia, and sick sinus syndrome.



Пейсмакер нь зүрхний үйл ажиллагааг хэвийн түвшинд барих төхөөрөмж бөгөөд генератор, цахилгаан холбогч гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Генератор нь маш бага овортойгоос гадна өөртөө бичил компьютерийг агуулсан байдаг. Дефибриллятор-Пейсмакер бол цахилгаан импульсыг үүсгэх наалт (эсвэл электрод)-ийн тусламжтайгаар цээж болон биеийн гадаргуугаар дамжуулан зүрхэнд хүргэдэг төхөөрөмж юм. Энэ төхөөрөмж нь ихэвчлэн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын дэлгэц, хоёр том электрод, дамжуулагч, арьсанд болон булчингаар дамжуулан зүрхэнд цахилгаан өдөөлт хийдэг нэг удаагийн наалдамхай электродуудаас бүрдэнэ. Гадна талын дефибриллятор-пейсмейкерийг зүрхний шигдээс, хүнд хэлбэрийн брадикарди, суулгасан пейсмейкерын үйл ажиллагааны алдагдал, зарим тахикарди, синусын хам шинж өвчлөлийн тодорхой хэлбэрүүдийн үед түр зуурын эмчилгээнд Дефибриллятор болгон ашиглах боломжтой.

ARTHROSCOPIC SHAVER SYSTEMS

АРТРОСКОП, ҮЕ ДУРАНГААР ТАЙРАХ
СИСТЕМ

UMDNS CODE 17918

Powered systems designed for bone and soft tissue resection during arthroscopic joint (e.g., knee, shoulder) surgery procedures. These systems typically consist of a power supply unit (electric or pneumatic), a display of operational characteristics, and dedicated software that provides optimal parameters for a procedure and/or stores previous settings; one or more rotary handpieces with several speeds that can operate different sizes of a variety of burs and blades (either straight or curved) and other rotary instruments such as a sagittal saw. Smaller and lighter handpieces are usually intended for surgery in small joints (e.g., wrist, ankle). Arthroscopic shavers are used in combination with fiberoptic video

Мэс заслын үед үет холбоосын / өвдөг, мөр г.м/ яс болон зөөлөн эдийг тайрах үйл ажиллагааг хийх төхөөрөмжийг Артроскоп гэнэ.. Ихэвчлэн энэ төрлийн систем нь цахилгаан тэжээлийн төхөөрөмж /цахилгаан ба хийн/, мэс заслын явцыг харуулах дэлгэц, ажилбарт зориулсан нэмэлт параметруудын програм хангамж, өмнөх тохиргоо болон ажилбарыг харах санах ой, янз бүрийн хэмжээтэй хугаралд мэс заслыг тодорхой хурдтайгаар хийх боломжтой нэг эсвэл түүнээс олон гар удирдлага, бусад эргэлдэгч багаж жишээ нь хөрөөний хошуу зэргээс бүрддэг. Жижиг болон хөнгөн гар удирдлага нь жижиг холбоост /бугуйн үе ба шагайн үе/ мэс засал хийхэд зориулагдсан байдаг. Үений тайрагч нь үений дуран, үс, мэс заслын талбайг усаар цэвэрлэгч,

arthroscopes, irrigation systems, and other manual instruments. They are most commonly used to debride defective cartilage (e.g., meniscus repair or meniscectomy) and remove the inflamed inner lining of the joint (synovectomy).

бусад багажуудтай хослон ажилладаг. Эдгээр нь гол төлөв үхжил болсон хэсгийг тайрах /өвдөгний жийргэвч мөгөөрс тайрах/, үений үрэвслийг авахад хэрэглэгддэг.(синтовектоми).



INJECTORS, CONTRAST MEDIA, COM- PUTED TOMOGRAPHY

ШАХУУРГА, ТОДОСГОГЧ, МЕДИА, КОМПЬЮТЕРТ ТОМОГРАФИ

UMDNS CODE 17969

Contrast media injectors designed to inject the contrast media through a small catheter into the vascular system for computed tomography (CT) procedures. These devices typically consist of automated electro-mechanical injectors with syringes that may be either reusable, disposable, or both; pneumatic mechanisms and peristaltic pumps are less frequently used. CT contrast media injectors are capable of delivering contrast media with the pressure, flow range, and volume required for CT studies, some injectors can synchronize the delivery with the x-ray generator. They are used for a wide variety of diagnostic procedures (e.g., spine, head, vascular, gastrointestinal) using CT scanning.

Компьютерт томографийн шинжилгээнд зориулан тодосгогч бодисыг нарийн гуурсаар судсанд шахах зориулалттай шахуурга. Энэ нь нэг удаагийн эсвэл олон дахин хэрэглэх тариур ашиглагддаг цахилгаан-механик шахуурга. Харин хийн болон эргэлдэгч шахуургын механизмыг хэрэглэх нь багассан. Компьютерт томографийн тодосгогчийн шахуурга нь компьютерт томографын шинжилгээнд зориулан даралт, урсгал, тунгаар тохируулан тодосгогчийг шахах ба зарим нь шахалтыг рентген генераторын ажиллагаатай уялдуулах боломжтой байдаг. Энэ шахуургыг олон төрлийн (нурууны, толгойн, судасны, хоол боловсруулах системийн г.м.) шинжилгээнд ашигладаг.



ULTRASOUND SURGICAL UNITS

ХЭТ АВИАН, МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ

UMDNS CODE 18049

Devices designed for the performance of surgery using ultrasound frequency energy; the heating effect that causes tissue cutting and coagulation is provided by friction when tissue comes into contact with a vibrating blade. These units typically include a high-frequency generator (frequencies of 23.5 and 55.5 kHz are typical), a handpiece in which electrical energy is transformed into mechanical ultrasonic vibration, and blades (e.g., shears) to apply the ultrasound energy to the target tissue. Ultrasound surgical units are used mostly in laparoscopic surgery procedures (e.g., splenectomy) to coagulate and cut tissue, providing proper hemostasis in vessels up to 3 mm in diameter without significant desiccation or charring. Dedicated units intended for dental treatments are also available.

Хэт авианы давтамжийн энерги ашиглан мэс засал хийхэд ашигладаг зориулалттай төхөөрөмж. Эд эсийг чичирхийлэлтэй хутгатай хүрэлцүүлэх үед үрэлтээр үүссэн халалтын нөлөөллөөр эдийн зүсэх түлэх үйл явц үүснэ. Уг төхөөрөмж нь ихэвчлэн өндөр давтамжийн генератор (23.5 ба 55.5 кГц давтамжтай), цахилгаан энергийг хэт авианы чичирхийлэл болгон хувиргадаг гар, мөн хэт авианы энергийг зорилтот эд рүү хэрэглэх ир бүхий хутгатай байна. Хэт авиан мэс заслын төхөөрөмж нь ихэвчлэн лапароскоп мэс заслын үед эдийг зүсэх, түлэх (жишээ нь, дэлүү), их хэмжээгээр хатааж, шатаахгүйгээр 3 мм диаметртай судас шөрмөсөнд цусыг зөвөөр тогтоодог. Шүдний эмчилгээнд зориулсан тусгай зориулалтын аппарат ч бас байдаг.



DRYERS, MEDICAL-AIR

ХАТААГЧ, ЭМНЭЛЭГ-АГААР

UMDNS CODE 18050

Dryers designed to remove moisture from central healthcare facility medical-air systems; these dryers use technologies such as refrigeration, desiccant adsorption, and membrane filtration to remove water from the air. Water is usually introduced in the med-

Хатаагч нь эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн агаарын системээс чийгийг арилгах зориулалттай төхөөрөмж. Хатаагч нь агаараас усыг зайлуулахын тулд хөргөлт, чийг шингээгч, болон мембрант шүүлтүүр зэрэг технологийг ашигладаг. Ус нь ихэвчлэн хүрээлэн буй орчны агаарын шахалтын тусламжтайгаар үүссэн

ical-air system during the manufacturing process by the compression of ambient air, which may be rich in humidity. Medical-air dryers may be equipped with filters for removing liquid oil aerosols and mists and with purifiers for removing solid and liquid particles and gaseous impurities such as carbon monoxide; these devices are frequently included as an integral part of medical-air supply systems.

үйлдвэрлэлийн процессын үед эмнэлгийн агаарын системд нэвтэрдэг. Эмнэлгийн агаар хатаагч нь шингэн, тосон аэрозол, цанг арилгах зориулалттай шүүлтүүрээр тоноглогдсон, хатуу ба шингэн бөөм, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг хийн хольцыг зайлуулах зориулалт бүхий цэвэрлэгчтэй байна. Эдгээр төхөөрөмж нь эмнэлгийн агаарын хангамжийн системийн салшгүй хэсэг болж байдаг.



CRYOSURGICAL UNITS

КРИОМЭС ЗАСЛЫН АППАРАТ. ХӨЛДӨӨЖ МЭДЭЭ АЛДУУЛАХ МЭС ЗАСЛЫН АППАРАТ

UMDNS CODE 18051

Equipment designed to regulate the flow and application of a gaseous or liquid coolant (cryogen) to destroy or remove tissue by freezing (i.e., perform cryosurgery or cryoablation). Cryosurgical units induce freezing in target tissue either through direct application of liquid cryogen or indirectly through contact with a cryogen-cooled probe. Some units use liquid nitrogen, while others use nitric oxide (NO₂) or carbon dioxide (CO₂) as a refrigerating medium.

Криомэс заслын аппарат нь хий ба шингэн хөргөгч бодис /бага хэмийн криоген/-г ашигладаг, түүний урсгалыг тохируулж эдийг хөлдөөж авдаг/ эд эрхтэнг хөлдөөж авах мэс засал, эдийг тайрах мэс засал/ төхөөрөмж. Эд эрхтэнг хөлдөөж авах мэс заслын төхөөрөмж нь бай эдийг хөлдөөхдөө шүүд шингэн криоген ашиглах эсвэл шүүд бусаар криоген хийтэй хатгуурыг ашиглаж мэс заслыг хийдэг. Зарим ижил төрлийн төхөөрөмж нь дунд хэмжээгээр хөлдөөдөг азотын исэл, нүүрсхүчлийн хийн оронд шингэн азотыг ашигладаг.



RADIOGRAPHIC SYSTEMS, DIGITAL,
DENTAL

РЕНТГЕН ЗУРГИЙН, ДИЖИТАЛ,
ШҮДНИЙ

UMDNS CODE 18056

Digital radiographic systems usually designed for intraoral radiography. These systems include a conventional dental x-ray subsystem, either an imaging plate (computed radiography) or an intraoral detector (direct digital radiography), and a digital imaging system with a workstation and a monitor. The x-ray tube is usually located in a cylindrical tubehead mounted on an articulating arm positioned according to the view desired. Most dental radiographic system x-ray tubes have a voltage ranging from 50 to 100 kV and a current ranging from 1 to 20 mA. These systems perform image processing (e.g., zooming, multi-image viewing) and also save and retrieve images. Intraoral digital radiographic systems are used for imaging crowns and the upper third of the roots of the upper and lower teeth (bite-wing image), the full tooth structure (periapical image), or the masticating surface of premolars and molars (occlusal image).

Дижитал рентген зургийн энэ систем нь амны хөндийн рентген зураг авахад зориулагдсан юм. Эдгээр систем нь дүрс буулгах хавтан ба амны хөндийд зориулсан детектор (дижитал рентген зураг авах) бүхий уламжлалт шүдний рентген дэд систем, ажлын байр, дэлгэц бүхий дижитал дүрсний систем зэргээс бүрдэнэ. Рентген хоолой нь хүссэн харалтын нөхцөлийг бүрдүүлэх хөдөлгөөнт гар дээр суурилуулсан цилиндр хэлбэртэй хоолой байна. Ихэнх шүдний рентген зураг авах системийн рентген хоолой нь 50-100 кВ хүртэлх хүчдэл болон 1-20 мА гүйдлийн хязгаартай. Дижитал систем нь дүрс боловсруулалт (жишээ нь, томруулах, олон зураг үзэх) хийж, мөн зураг хадгалах, сэргээх ажлыг гүйцэтгэдэг. Амны хөндийн дижитал рентген зураг авах систем нь дээд доод шүдний ёзоорын гуравны нэгээс дээгүүрх хэсгүүд (хазалт-зуултын зураг) болон титэм, дээд шүдний бүтэц (periapical зураг) эсвэл бага араа болон арааны бүрээсийн гадаргуугийн зургийг (occlusal зураг) авах зориулалттай.



SIMULATORS, ELECTROENCEPHALO-
GRAPHIC

СИМУЛЯТОР,
ЭЛЕКТРОЭНЦЕФАЛОГРАФ

UMDNS CODE 18057

Simulators designed to mimic the waveforms of the electrical activity of the brain; they usually include an electronic analog circuit generator or digitally recorded signals in their memory. When activated these simulators produce typical electroencephalographic signals. They may also generate low- and high-frequency sine and multifrequency waves. Some simulators can also simulate evoked potential signals.

Симулятор нь тархины цахилгаан дохиог хиймлээр гаргадаг төхөөрөмж юм. Аналог хэлхээний генератор ба санах ойд нь бичигдсэн дижитал сигналуудаас бүрддэг. Төхөөрөмжийг ажиллуулж эхлэхэд ерөнхий тархины цахилгаан бичлэгийн аппаратаас дохиог гаргана. Мөн бага ба өндөр давтамжийн синус болон олон давтамжийн долгионыг үүсгэж чадна. Зарим симулятор нь дурсамжийн потенциалын сигналыг үүсгэдэг.



MICROSCOPES, ELECTRON, SCANNING

МИКРОСКОП, ЭЛЕКТРОН, СКАН ХИЙХ

UMDNS CODE 18089

Electron microscopes designed to provide a topographical image of the surface of a specimen, useful for understanding its surface structure. Scanning electron microscopes (SEMs) consist of an electron gun and vacuum chamber, an electromagnetic imaging (lens) system, a scanning system, a specimen chamber, secondary and backscatter detectors, a viewing chamber and fluorescent screen, and photographic and vacuum systems. The imaging system provides an electron beam with a fine focal spot that is deflected horizontally and vertically (i.e., scanning system); the energy exchange between the electron beam and the sample yields electromagnetic radiation that is detected to produce an image. Before observation, tissue samples must be fixed (including cryofixation for some dedicated instruments), processed, embedded, sectioned, mounted on a support stub, and usually coated (e.g., using a sputter coater)

"Электрон микроскоп нь сорьцын гадаргуугийн топографийн дүрсийг гаргадаг бөгөөд гадаргуугийн бүтцийг ойлгоход илүү хэрэглэгддэг. Судалгааны электрон микроскоп (SEM) нь электрон буу болон вакуум камер, цахилгаан соронзон линзийн систем, скан систем, сорьцын камер, хоёрдогч болон арын хэсгийн мэдрэгч, харах камер, флюоресцент дэлгэц, гэрэл зургийн болон вакуум системээс бүрддэг. Дүрслэлийн систем нь хэвтээ ба босоо чиглэлд нарийн фокусын цэгээр электрон цацрагыг нийлүүлдэг. Электрон цацраг ба дээжээс гарсан цахилгаан соронзон цацрагийн хоорондох энергийн солилцоогоор дүрс үүсдэг. Ажиглалт хийхийн өмнө эдийн сорьцийг тусгай төхөөрөмжөөр бэхжүүлэх, мөн боловсруулах, тулгуурт бэхлэнэ. Тулгуур нь хүнд металлын нимгэн хальсаар бүрсэн байдаг. Судалгааны электрон микроскопын (SEM) эмнэлзүйн хэрэглээ нь нарийн гэдэс, хэвлийн хөндийн ийлдэсний гематологийн эмгэг,

with a thin film of a heavy metal (e.g., gold). The clinical use of SEMs has yielded information on hematologic disorders and biological surfaces, such as those of the small intestines and serous cavities.

биологийн гадаргуугийн мэдээллээр хангана. "



MICROSCOPES, ELECTRON, SCANNING/
TRANSMISSION

МИКРОСКОП, ЭЛЕКТРОН, СКАН ХИЙХ /
ДАМЖУУЛАЛТ

UMDNS CODE 18091

Electron microscopes designed to combine the characteristics of transmission electron microscopes (TEMs) and scanning electron microscopes (SEMs) in one instrument. These microscopes include an electron gun and vacuum chamber, an electromagnetic condenser and electromagnetic imaging (lens) systems, a specimen chamber, a viewing chamber and fluorescent screen, photographic and vacuum systems, and a scanning system. Before observation, tissue samples must be prepared according to the technique to be performed (i.e., transmission or scanning), including fixation, embedding, and sectioning; additional preparation for scanning microscopy may be needed (e.g., gold coating of samples). The clinical uses of combined electron microscopes include visualization of tissue, individual cells, and cell structure; identification of cancer cells; diagnosing and differentiating types of renal diseases; and gathering information on hematologic disorders and biological surfaces (e.g., small intestines, serous cavities).

"Электрон микроскоп (TEMs) болон судалгааны электрон микроскоп (SEMs) -ын үүргийг нэг аппаратад хослуулсан электрон микроскоп. Энэ электрон микроскоп нь электрон буу болон вакуум камер, цахилгаан соронзон конденсатор, цахилгаан соронзон линзийн систем, скан систем, сорьцын камер, харах камер, флюоресцент дэлгэц, гэрэл зургийн болон вакуум систем, скан системээс бүрддэг. Ажиглалт хийхийн өмнө тусгай аргын дагуу сорьцыг (дамжуулалт болон судалгааны) бэхлэх, хуваах, зэргээр бэлтгэх хэрэгтэй. Судалгааны микроскопт нэмэлт бэлтгэл шаардлагатай байж болно (сорьцыг алтаар бүрэх гэх мэт). Хосолсон электрон микроскопын эмнэлзүйн хэрэглээ нь эд, эсийг харах ажиглах, эс болон эсийн бүтцийг харуулах, хорт хавдрын эсийг тодорхойлох, бөөрний өвчний оношилгоо, төрлийг ялгах, нарийн гэдэс, хэвлийн хөндийн ийлдэсний гематологийн эмгэг, биологийн гадаргуугийн мэдээллийг судлана."



VENTILATORS, TRANSPORT

АМЬСГАЛЫН АППАРАТ, ЗӨӨВРИЙН

UMDNS CODE 18098

Ventilators designed to provide automated ventilatory support to patients during interhospital or intra-hospital transport and in emergency situations. The operation and control of these ventilators are intentionally simplified; they are compact, lightweight (i.e., less than 5 kg), rugged devices. Most transport ventilators provide mandatory breaths at preset intervals (control mode), not allowing the patients to breathe spontaneously; operation in assist/control and/or synchronized intermittent mandatory ventilation (SIMV) modes is available in some models. These ventilators usually include an airway pressure monitor and low- and high-pressure alarms. Transport ventilators may be used in vehicles, ambulances, and in field hospitals for medium-term.

Амьсгалын аппарат нь яаралтай болон түргэн тусламж, эрчимт эмчилгээнд үйлчлүүлэгчийг эмнэлгүүдийн хооронд тээвэрлэх үед амьсгалын үйл ажиллагааг автоматаар дэмжих төхөөрөмж юм. Эдгээр төхөөрөмж нь хялбар, энгийн үйл ажиллагаа, удирдлагатай, иж бүрэн, жин багатай (5 кг-аас бага) байдаг. Ихэнх зөөврийн амьсгалын аппарат нь давтамжтай (хяналтын горим) байдлаар хангадаг бөгөөд өөрөө амьсгалах горимд боломжгүй юм. Зарим загварт SIMV горим болон туслах удирдлагын үйл ажиллагаатай. Эдгээр төхөөрөмжүүд нь ихэвчлэн агаарын даралтын монитор, өндөр болон нам даралтын дохиололтой байна. Зөөврийн амьсгалын аппарат нь тээврийн хэрэгсэл, түргэний машинд, дунд түвшний эмнэлгүүдэд ашигладаг.



SIMULATORS, INVASIVE BLOOD PRES-
SURE

СИМУЛЯТОР, ИНВАЗИВ ЦУСНЫ
ДАРЛТЫН

UMDNS CODE 18106

Simulators designed to mimic the the characteristics of the blood pressure in the interior of the blood vessels (e.g., central venous pressure, intra-arterial pressure). These simulators usually include an internal mechanism to generate the static and/or time-varying testing pressures, electronic circuitry, controls, and/or manometers; some of these simulators may be used to test the invasive blood pressure monitors as a complete set, including the frequency response of the transducer.

Симулятор нь цусны судас (жишээ нь: төвийн венийн даралт, дотоод артерийн даралт)-ын дотоод даралтын характеристикийг хиймлээр үүсгэдэг төхөөрөмж юм. Эдгээр симулятор нь ихэвчлэн статик даралт үүсгэх дотоод механизм болон цагаар өөрчлөгдөх тестийн даралт, электрон хэлхээ, удирдлага ба манометр зэргээс бүрдэнэ. Зарим симулятор нь давтамжинд хариу өгдөг датчикийн тусламжтайгаар инвазив цусны даралтын аппаратын ажиллагааг шалгадаг.



SIMULATORS, NONINVASIVE BLOOD
PRESSURE

СИМУЛЯТОР, ИНВАЗИВ БУС ЦУСНЫ
ДАРЛТЫН

UMDNS CODE 18107

Simulators designed to mimic the pressure variations acting on the cuff of noninvasive arterial blood pressure monitoring or measuring devices when the cuff is placed on a patient's arm. Typically, these devices can simulate normal adult, infant, and neonatal blood pressure (e.g., systolic, diastolic, mean) and abnormal (e.g., hypertensive, hypotensive) values. Most simulators can perform static accuracy, leak, and overpressure tests. These simulators usually consist of an internal pump to generate the testing pressures, manometers, electronic circuitry, and a display. Noninvasive blood pressure simulators are used to test oscillometric noninvasive blood pressure monitors and electronic sphygmomanometers as a

Симулятор нь өвчтөний гарт хийлэгч монжатыг байрлуулсан байхад инвазив бус артерийн даралтын өөрчлөлтийг зохиомлоор явуулж, түүнийг хэмжих хянах төхөөрөмж юм. Ихэвчлэн энэ төхөөрөмж нь насанд хүрэгч, хүүхэд, нярайн цусны хэвийн даралт / систол, диастол, дундаж даралт/ болон хэвийн бус даралтыг /цусны даралт ихдэх, багадаа/ загварчлан гаргадаг. Ихэнх симулятор нь статик нарийвчлал, даралтын алдагдал, өндөр даралтын тестүүдийг гүйцэтгэдэг. Симулятор нь даралт үүсгэгч дотоод насос, манометр-даралт хэмжигч, цахилгаан хэлхээ, дэлгэцнээс тогтоно. Инвазив бус цусны даралтын симулятор нь осцилометрийн инвазив бус даралтыг үзүүлэх, цахилгаан даралтын аппаратын үзүүлэлтүүдийг

complete set, including the transducer. Some are also capable of simulations appropriate for testing auscultatory sphygmomanometers.

тусгай бүртгэгчээр бүртгэн авахад зориулагдсан байдаг. Зарим төрлийн симулятор нь чагнуур, даралтын аппаратыг нарийвчлан шалгах боломжтой байдаг.



SCANNING SYSTEMS, ULTRASONIC,
PORTABLE

СКАН СИСТЕМ, ХЭТ АВИАН,
ЗӨӨВРИЙН

UMDNS CODE 18143

Ultrasonic scanning systems that are designed to be small and lightweight, typically less than 23 kg (50 lb), to allow them to be carried by hand from location to location. Most of these systems support basic diagnostic techniques only and do not offer the optional advanced scanning capabilities that are found in larger general-purpose systems (e.g., Doppler and color flow mapping). These systems are used in physician's offices, outpatient imaging centers, and small radiology departments and in hospitals for bedside scanning (e.g., abdominal small parts, obstetric/gynecologic) of patients who cannot be transported to the radiology department.

Скан систем нь зөөврийн байдлаар хэрэглэхэд зориулагдсан хөнгөн, авсаархан буюу 23кг аас бага жинтэй, нэг байршлаар нөгөө рүү эмч өөрөө зөөж явах боломжтой аппарат юм. Ихэнх загвар нь ерөнхий оношилгоонд зориулагдсан байдаг бөгөөд өнгөт доплер зэрэг нэмэлт нарийн оношилгооны програмгүй байдаг. Зөөврийн хэт авиан оношилгооны аппаратыг ихэвчлэн эмчийн үзлэгийн өрөө, амбулатори болон эмнэлгийн дүрслэлийн оношилгооны тасаг рүү зөөвөрлөх боломжгүй өвчтөнүүдэд (хэвлий, жижиг хэсгүүд, эмэгтэйчүүд төрөх) үзлэг хийхэд хэрэглэдэг.



STERILIZING UNITS, GERMICIDAL GAS,
GASEOUS PLASMA

АРИУТГАЛЫН ТӨХӨӨРӨМЖ, ГЕРМИЦИДИЙН
ХИЙ, ХИЙН ПЛАЗМААР АРИУТГАХ

UMDNS CODE 18146

Sterilizing units designed for total inactivation of microorganisms that are or may be present on medical devices using germicidal vapors or gases in a plasma state (a form of matter that includes electrons and positive ions usually resulting from the application of a strong electromagnetic [e.g., radio frequency] field). These units usually include a treatment (frequently vacuum) chamber with shelves on which the devices to be sterilized are placed, usually after being cleaned of gross debris and then packed; means to introduce the vapor (e.g., hydrogen peroxide, H2O2) into the chamber; electrodes that are activated to convert the vapor to plasma; a radio-frequency generator; and controls to start/stop automated cycles of the procedure. After the sterilization cycle is complete, an integral evacuation system to eliminate the residues (water and oxygen when using H2O2) is usually activated. Plasma sterilizing units are available in a variety of shapes and sizes in both stand-alone (bulk) and tabletop models; they are used for devices and supplies that are sensitive to high temperature and humidity (e.g., devices and supplies that include plastic and/or rubber components).

Ариутгалын төхөөрөмж нь плазм төлөвт (хүчтэй соронзон орны (жишээ нь радио давтамжит) үр дүнд бий болсон электрон болон эерэг ионыг багтаадаг) буй гермицидийн уур болон хийг ашиглан эмнэлгийн төхөөрөмж дээрх бичил организмыг бүхэлд нь идэвхгүйжүүлэх зориулалттай. Эдгээр төхөөрөмж нь ариутгах зүйлсэд зориулсан тавиур бүхий камераас бүрддэг, ихэвчлэн багаж төхөөрөмжөөс хог хаягдлыг цэвэрлэсний дараа савлаж зориулалтын тавиурт байрлуулан ариутгалын камер руу хийг (жишээ нь, үстөрөгчийн хэт исэл, H2O2) нэвтрүүлж ариутгалыг хийж гүйцэтгэнэ. Түүнчлэн уурыг плазм төлөвт хувиргах идэвхтэй электрод, радио-давтамжийн генератор болон процедурын циклийг автоматаар эхлүүлэх/дуусгах удирдлага зэргээс бүрдэнэ. Ариутгах цикл дууссаны дараа үлдэгдэлийг (H2O2 ашиглах үед ялгарах ус ба хүчилтөрөгч) арилгах зориулалттай дотоод устгалын системтэй байдаг. Плазмт ариутгах төхөөрөмж нь дангаараа болон ширээний дээр байрлуулан ашиглах боломжтой төрөл бүрийн хэлбэр, хэмжээтэй байдаг. Эдгээр төхөөрөмж нь өндөр температур, чийгшилд мэдрэмтгий төхөөрөмжийг ариутгахад зориулагдсан байдаг (хуванцар болон резинэн бүрэлдэхүүн хэсэг бүхий багаж төхөөрөмж).



INJECTORS, CONTRAST MEDIA, MAG-
NETIC RESONANCE IMAGING

ШАХУУРГА, ТОДОСГОГЧ БОДИС, МЕДИА,
СОРОНЗОН РЕЗОНАНСТ ТОМОГРАФИ

UMDNS CODE 18158

Contrast media injectors designed to inject the contrast media through a small catheter into the vascular system for selectively alter the image of an anatomic region of interest in magnetic resonance imaging (MRI) procedures. These devices typically consist of automated electromechanical injectors with syringes that may be either reusable, disposable, or both; pneumatic mechanisms and peristaltic pumps are less frequently used. MRI contrast media injectors are capable of delivering contrast media with the pressure, flow range, and volume required for MRI studies. They are intended for some particular MRI procedures, such as those for enhancing lesions and vascular abnormalities.

Шахуурга нь Соронзон резонанст томографийн (MRI) шинжилгээнд биеийн тухайн хэсгийн дүрслэлийг сонгон өөрчлөх зорилгоор тодосгогч бодисыг нарийн гуурсаар судсанд шахах зориулалттай. Энэ төхөөрөмж нь нэг удаагийн эсвэл олон дахин хэрэглэх тариур ашигладаг цахилгаан-механик шахуурга ба хийн болон эргэлдэгч шахуургын механизмыг хэрэглэх нь багассан. Соронзон резонанст томографийн тодосгогчийн шахуурга нь шинжилгээнд зориулагдан даралт, урсгал, тунгаар тохируулан тодосгогчийг шахна. Энэ шахуургыг соронзон резонанст томографийн зарим (гэмтэл, судасны гажиг/согог) шинжилгээнд ашигладаг.



URETEROSCOPES, FLEXIBLE

УРЕТРОСКОП, УМАЙН УЯН ДУРАН

UMDNS CODE 18188

Ureteroscopes designed with a nonrigid (i.e., flexible) structure, capable of being manipulated through the lumen of the curved path of the upper urinary tract. The sheath is usually made of plastic.

Уретроскоп/Умайн дуран нь уян бүтэцтэй ба шээс дамжуулах дээд замыг гэрэлтүүлэн харах боломжтой байдаг. Гадуур бүрээс нь хуванцар.



OPHTHALMOSCOPES, SCANNING LASER

ОФТАЛЬМОСКОП, СКАН ЛАЗЕР

UMDNS CODE 18190

Ophthalmoscopes that use a low-power laser beam for scanning horizontally and vertically across the retina, producing an electronic image with depth resolution, which is particularly valuable in creating three-dimensional (topographic) images of the optic disc. Retinal conditions such as edemas, scars, and macular holes are assessed using this technique.

Офтальмоскоп нь нүдний торлог бүрхэвчийн эргэн тойронд хэвтээ болон босоо тэнхлэгийн дагуу скан хийхэд зориулагдсан, бага чадлын лазер цацрагийн тусламжтайгаар нүдний дискийн гурван хэмжээст дүрслэлийг бий болгоход шаардлагатай хэсгүүдийн өндөр нягтрал бүхий цахим дүрсийг гаргадаг. Хаван, сорви, нүдний эвэрлэг бүрхэвчинд толбо үүсэх зэрэг нүдний эвэрлэг бүрхэвчийн эмгэгүүдийг энэ аргын тусламжтайгаар үнэлдэг.



SCANNING SYSTEMS, LASER, OPTICAL
COHERENCE TOMOGRAPHY, OPHTHALMIC

СКАН СИСТЕМ, ЛАЗЕРТ, НҮДНИЙ
КОГЕРЕНТ ТОМОГРАФИ

UMDNS CODE 18191

Optical coherence tomography (OCT) scanning systems designed to obtain cross-sectional images of eye (i.e., ophthalmic) tissues. These systems typically consist of a computerized unit that includes a light source, a photodetector, and a display. The light beam (usually in the infrared range) is divided into two beams, one directed towards the sample and the other towards a moving reference mirror. Tomographic images are then obtained by detecting the interference between the light reflected by both beams. The images obtained can show tissue about two or three mm (0.08 to 0.12 inch) in depth and provide axial and lateral resolution in the order of micrometers. The systems reveal the underlying

Оптик когеренс томографи (ОКТ) нь багахан хэмжээний гэрэл биеээр нэвтрэн гарах үе дэх эсээс үзэгдэх гэрлийн мэдээллийг бүртгэн авах энгийн үзэгдэл дээр тулгуурласан скан техник юм. Жишээ нь оптик дохиог олж авах технологийн арга юм. Компьютерт микрометрийн хэмжээнд дүрсэлж, гурван хэмжээст зургаар оптик сарнилыг үзүүлнэ. Оптик оношилгооны аппарат нь гэрлийн долгионы уртын техник, хэт улаан гэрлээр ердийн үед ажилладаг. Гэрлээс хамаарсан шинж чанартай (гэрэл цацруулж буй диод, хэт богино лазерийн чичиргээнд ба лазерийн тасралтгүй үргэлжлэх ажил), ба хамгийн бага хэмжлийн төвшинд тодорхойлж гаргадаг (хамгийн өргөн спектрээр гаргахдаа хамгийн урт долгион нь

structure not directly observable (tomographic images) in an analogous way, but with higher image resolution than conventional B-mode ultrasound and magnetic resonance imaging. Systems that use light sources at different frequencies simultaneously (spectral domain systems), rather than a mechanical movement of a mirror, are also available. OCT ophthalmic scanning systems are used for a variety of clinical applications involving accurate retinal and intraretinal thickness measurements.



100 нм). Гэрлийн цацраг (ихэвчлэн хэт улаан туяаны муж дахь) хоёр хэсэгт хуваагддаг бөгөөд нэг нь дээж рүү нөгөө нь толин ойлтын хэсэг рүү чиглэсэн байдаг. Томографийн дүрсүүд нь түсч буй хоёр цацрагуудийн хоорондох интерференцийг бүртгэсний үр дүнд бий болдог. Дүрс нь ойролцоогоор хоёр эсвэл гурван мм (0.08-1.22 инч) -ийн гүнд байгаа эдийг харуулж чадах бөгөөд, хэвтээ тэнхлэгийн дагуу нягтралыг хэмжээг микрометрийн дарааллаар харуулна. Эдгээр систем нь шууд дүрслэл (Томографийн зүслэг зураг) -ийг аналог байдлаар биш харин уламжлалт В-горимын хэт авиан болон соронзон резонансын дүрслэлээс илүү өндөр нарийвчлалтай дүрсийг бий болгодог. Систем нь тольны механик тусгалын оронд нэгэн зэрэг өөр өөр давтамж бүхий гэрлийн эх үүсвэрийг (спектрийн домэйн системүүд) ашиглах боломжтой байдаг. OCT нүдний сканерын системийг нүдний торлог бүрхэвчийн болон торлог бүрхэвчийн доторхи зузааныг хэмжилтүүдийг нарийвчлан судлах эмнэл зүйн олон төрлийн оношилгоонд ашигладаг.

DERMOSCOPIES

ДЕРМОСКОП/АРЬСНЫ ДУРАН

UMDNS CODE 18193

Endoscopes designed for direct insertion under the dermis for visual examination and treatment, especially to perform plastic surgery. Dermoscopes may include a lighting system and a working channel for operative devices.

Арьсны эндоскоп буюу Дермоскоп нь шууд арьсан дор оруулж эмчилгээ, оношилгоог хийх, ялангуяа пластик мэс заслын зориулалттай бүтээгдсэн. Дермоскоп нь гэрэлтүүлгийн систем болон үйл ажиллагааны төхөөрөмжид зориулсан сувгийн системтэй, гэрэлтүүлгийн систем болон үйл ажиллагааны хэсэг бүхий юм. холбогдож нүдээр харах боломжтой сувгийн системийг багтааж болно



ELECTROSURGICAL UNITS, MONOPOLAR

ЦАХИЛГААН МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ, НЭГ ТҮЙЛТ

UMDNS CODE 18229

Electrosurgical units in which the high-frequency electric current is delivered to the patient by an active cable and electrode and returns to unit through a return (dispersive) electrode.

Цахилгаан мэс заслын төхөөрөмж нь өндөр давтамжтай цахилгаан гүйдлийг өвчтөнд идэвхтэй дамжуулагч утас ба электродоор дамжуулж, үүнийгээ идэвхгүй электродоор буцаан авдаг.



ELECTROSURGICAL UNITS, BIPOLAR

ЦАХИЛГААН МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ, ХОЁР ТҮЙЛТ

UMDNS CODE 18230

Electrosurgical units in which two electrodes (generally the two tips of a pair of forceps or scissors) serve as the equivalent of the active and dispersive leads in the monopolar mode. Bipolar electrosurgery is primarily used to coagulate fine tissue (e.g., in neurosurgical, gynecologic, and ophthalmic procedures).

Цахилгаан мэс заслын төхөөрөмж нь хэт өндөр давтамжийн цахилгаан гүйдлээр бие махбодийн эдийг зүсэх, түлэх ажиллагаатай хоёр электродтой /хос хямсаа, хос хайчтай/. Цахилгаан мэс заслын төхөөрөмж нь нэг туйлт горимдоо ижил идэвхтэй ба идэвхгүй хавтанг/электрод/ хэрэглэдэг. хоёр туйлт цахилгаан мэс заслын төхөөрөмж нь эдийн цус тогтооход / мэдрэлийн мэс засал, эмэгтэйчүүдийн мэс засал, нүдний мэс засал/ хэрэглэдэг.



ELECTROSURGICAL UNITS, MONOPOLAR/BIPOLAR

ЦАХИЛГААН МЭС ЗАСЛЫН
ТӨХӨӨРӨМЖ, 1 ТУЙЛТ/2 ТУЙЛТ

UMDNS CODE 18231

Electrosurgical units capable of both monopolar and bipolar functionality.

Цахилгаан мэс заслын төхөөрөмж нь нэг туйлт ба хоёр туйлт горимоор ажиллах боломжтой. Мэс заслын үед өндөр давтамжийн гүйдлээр зөөлөн эдэд зүсэлт хийх, венийн жижиг судсуудыг түлэх үйлдлүүдийг нэгэн зэрэг гүйцэтгэдэг.



ELECTROSURGICAL UNITS, MONOPOLAR/BIPOLAR, ARGON-ENHANCED COAGULATION

ЦАХИЛГААН МЭС ЗАСЛЫН ТӨХӨӨРӨМЖ, 1
ТУЙЛТ/2 ТУЙЛТ, АРГОН-ЭРЧИМЖҮҮЛСЭН,
БҮЛЭГНЭЛТ

UMDNS CODE 18232

Electrosurgical units capable of both bipolar and argon-enhanced monopolar functionality.

Цахилгаан мэс заслын төхөөрөмж нь аргон нэг туйлт ба хоёр туйлт горимоор ажиллах боломжтой. Мэс заслын үед өндөр давтамжийн гүйдлээр зөөлөн эдэд зүсэлт хийх, венийн жижиг судсуудыг түлэх үйлдлүүдийг нэгэн зэрэг гүйцэтгэдэг.



CENTRIFUGES, FLOOR, HIGH-SPEED

ЦЕНТРИФУГ, СУУРИН, ӨНДӨР ХУРДНЫ

UMDNS CODE 18263

Floor centrifuges which usually operate at maximum speeds of 10,000 to 25,000 rpm and are refrigerated to cool the rotor chamber. These centrifuges are mostly used to collect microorganisms, cells, cellular debris, and precipitates, and can also effectively sediment viruses and cellular organelles.

Центрифуг нь 10000-25000 эрг/мин хүртэлх хамгийн дээд хурдаар ажиллах ба эргэлдэх камерын хөргөлтөнд зориулсан хөргөх системтэй байдаг. Эдгээр центрифуг нь ихэвчлэн эсийн жижиг хэсэг, эс, бичил организмыг цуглуулах зорилгоор ашиглагддаг ба вирусын болон эсийн жижиг хэсгүүдийн тунадасыг үр дүнтэйгээр тунгааж авч чаддаг.



CHROMATOGRAPHY SYSTEMS, LIQUID

ХРОМАТОГРАФ СИСТЕМ, ШИНГЭНИЙ

UMDNS CODE 18274

Chromatography systems in which the separation process of the mixture of compounds is accomplished by pumping a liquid, usually water or an organic solvent (i.e., the mobile phase) through a column of stationary phase. Separation is based on the relative solubility of the solutes in the two phases and their interaction with the stationary phase. A mass spectrometer can be connected to these devices instead of a detector.

Хроматографийн систем нь шингэний нэгдлүүдийн холимгийг салгах үйл явцыг хийх ихэвчлэн суурин фазын баганаар дамжуулан ус эсвэл органик уусгагч (жишээ нь, хөдөлгөөнт фаз) зэрэг шингэнийг шахах замаар ажилладаг. Салгах үйл явц нь хоёр фаз дахь уусмалын харьцангуй хангалттай байдал болон тэдгээрийн хөдөлгөөнгүй фазтай харьцах харьцаанд үндэслэнэ. Масс спектрометр нь эдгээр төхөөрөмжид детекторын оронд холбогдсон байж болно.



MICROSCOPES, LIGHT, OPERATING,
OPHTHALMOLOGY

МИКРОСКОП, ГЭРЛИЙН, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ, НҮДНИЙ

UMDNS CODE 18288

Operating microscopes designed using combinations of couplers, objectives, lenses, and body tubes for specific use in eye surgery. The illumination system of these microscopes usually includes special illuminators (e.g., slit, oblique).

Микроскоп нь нүдний мэс заслын үед тусгай зориулалтаар ашигладаг, холбогч, Объект ив, линз, биеийн гуурс зэргээс бүрдэнэ. Энэ микроскопийн гэрэлтүүлгийн систем нь ихэвчлэн тусгай гэрэлтүүлэгч (завсарын, хөндлөн) байдаг.



MICROSCOPES, LIGHT, OPERATING,
NEUROSURGERY

МИКРОСКОП, ГЭРЛИЙН, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ, МЭДРЭЛИЙН МЭС
ЗАСЛЫН

UMDNS CODE 18289

Operating microscopes with high mobility and flexibility, designed using combinations of couplers, objectives, lenses, and body tubes for specific use in neurosurgery.

Микроскоп нь мэдрэлийн мэс заслын үед тусгай зориулалтаар ашигладаг холбогч, Объект ив, линз, биеийн гуурс зэргийг хослуулан ашигладаг, хөдөлгөөнт, уян микроскоп.



MICROSCOPES, LIGHT, OPERATING,
GYNECOLOGY

МИКРОСКОП, ГЭРЛИЙН, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН

UMDNS CODE 18290

Operating microscopes with slim bodies designed using combinations of couplers, objectives, lenses, and body tubes for specific use in gynecologic (e.g., fallopian tubes) surgery. Gynecologic microscopes may have an independent mount or may be attached to a gynecologic/obstetric table or chair.

Микроскоп нь эмэгтэйчүүдийн мэс заслын үед тусгай зориулалтаар ашигладаг холбогч, объектив, линз, биеийн гүүрс зэргийн хослолыг ашигладаг, хөдөлгөөнт, уян микроскоп юм. Эмэгтэйчүүдийн микроскоп нь эмэгтэйчүүдийн/эх барихын үзлэгийн ортой холбогддог эсвэл бие даан суурилагдсан байж болдог.



MICROSCOPES, LIGHT, OPERATING,
HAND/PLASTIC SURGERY

МИКРОСКОП, ГЭРЛИЙН, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ, ГАР/ГОО САЙХНЫ
МЭС ЗАСЛЫН

UMDNS CODE 18291

Operating microscopes with high mobility and flexibility, designed using combinations of couplers, objectives, lenses, and body tubes for specific use in hand and plastic surgery.

Гарын болон гоо сайхны мэс заслын үед тусгай зориулалтаар ашигладаг холбогч, Объектив, линз, биеийн гүүрс зэргийг хослуулан ашигладаг, хөдөлгөөнт, уян микроскоп.




CARDIOGRAPHS

ЗҮРХНИЙ БИЧЛЭГИЙН АППАРАТ

UMDNS CODE 18328

Physiologic recorders designed to measure and record data and graphics of the physical and/or functional characteristics of the heart. Cardiographs are usually intended to record one or several of the following data and graphics: (1) electrical potential caused by the electrical activity of the heart muscle (e.g., electrocardiographs and vectorcardiographs); (2) biomagnetic field caused by the electrical activity of the heart muscle detected externally to the body; (3) changes in the thoracic impedance due to heart activity (i.e., impedance cardiographs); (4) movements and forces exerted by the heart (e.g., ballistocardiographs); (5) ultrasonic signals reflected by the heart (i.e. echocardiographs); and (6) sounds produced by the heart movement (i.e., phonocardiographs). Cardiographs are intended for evaluation of recorded information of the heart conditions, they are not intended for real-time assessment of those conditions. Cardiography monitors and image scanning systems (e.g., MRI, PET) are also used to evaluate heart conditions.

Зүрхний бичлэгийн аппаратын физиологийн үзүүлэлтийн бичлэг нь зүрхний физик болон функциональ шинж чанаруудын өгөгдөл болон графикийг бүртгэх болон хэмжих зорилготой юм. Зүрхний бичлэг нь ихэвчлэн дараах өгөгдлүүд болон графикуудын зөвхөн нэгийг эсвэл хэд хэдэн хэлбэрийг бүртгэх зорилготой байдаг. Үүнд: (1) зүрхний булчингийн цахилгаан идэвхижлийн улмаас үүсэх цахилгаан потенциал (ж.нь, электрокардиограф ба векторкардиограф); (2) зүрхний булчингийн цахилгаан идэвхижлийн улмаас биеийн гадаргуу дээр бий болох био соронзон талбай; (3) зүрхний үйл ажиллагааны турш бий болох цээжний эсэргүүцлийн өөрчлөлт (жишээ нь, эсэргүүцлийн кардиограф); (4) зүрхээр үүсгэгдсэн хөдөлгөөнүүд болон даралт (жишээ нь, балистокардиограф); (5) зүрхнээс гарах хэт авиан дохио (жишээ нь, эхокардиограф); болон (6) зүрхний хөдөлгөөнөөр үүсэх дуу авиа (дуу хоолой, дуу авиа) зэргийг тэмдэглэнэ. Зүрхний бичлэг нь зүрхний нөхцөл байдлын талаархи мэдээлэлд үнэлгээ өгөх зорилготой бөгөөд тэдгээр нь тухайн нөхцөл байдлын бодит цаг хугацааны үнэлгээнд зориулагдаагүй болно. Зүрхний бичлэгийн монитор ба дүрслэл скан хийх систем (жишээ нь, MRI, PET) нь зүрхний нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэглэгддэг.



ELECTROGASTROGRAPHS

ЭЛЕКТРОГАСТРОГРАФ/ХОДООДНЫ
ЦАХИЛГААН БИЧЛЭГИЙН АППАРАТ

UMDNS CODE 18333

Graphic recorders of the electrical activity from the smooth muscle of the stomach. These recorders include electrodes placed internally through invasive procedures or externally on the skin and appropriate amplifiers. Electrogastrographs can be used in the investigation of the physiology of the gastrointestinal tract and gastric disorders.

Ходоодны цахилгаан бичлэгийн аппарат нь гэдэсний гөлгөр булчингаас гарах цахилгаан идэвхижлийн график бичигч төхөөрөмж. Эдгээр бичигч төхөөрөмж нь инвазив процедурар дамжин биеийн дотор эсвэл арьсны гадаргуу дээр байрлуулах шаардлагатай өсгүүр бүхий электродуудаас бүрдэнэ. Ходоодны цахилгаан бичлэгийн аппарат нь ходоод гэдэсний замын болон ходоодны эмгэгийн физиологийн шинжилгээ хийхэд хэрэглэгддэг.



MONITORS, PHYSIOLOGIC, FETAL,
ANTEPARTUM, BEDSIDE

МОНИТОР, ФИЗИОЛОГИЙН, УРГИЙН,
УМАЙН БАЗАЛТЫН, ХЯНАЛТЫН

UMDNS CODE 18339

Microbiology laboratory analyzers designed to test, process, and interpret data from microbiological blood cultures. Blood culture analyzers are available that use a variety of techniques, including detection of carbon dioxide by radiometric or infrared spectrophotometry and detection of microbial activity using photometric or fluorometric measurements; other analyzers use microcalorimetry, pH, electrical impedance, or flow cytometry techniques. Manual analyzers are used in small hospital laboratories; automatic blood culture analyzers are used mainly in laboratories that perform large numbers of tests. Some analyzers can detect microbial growth in body fluids.

Анализатор нь микробиологийн цусны өсгөвөрүүдийг шинжлэх, шинжилгээний өгөгдлийг шинжлэх, боловсруулах зорилготой. Цусны өсгөврийн анализатор нь радиометрийн эсвэл хэт улаан спектрофотометр ашиглан нүүрстөрөгчийн диоксидыг илрүүлэх, фотометрийн эсвэл флюорометрийн хэмжилтийг ашиглан бичил биетийн үйл ажиллагааг илрүүлэх гэх мэт янз бүрийн арга техникийг ашиглах боломжтой; Бусад анализатор нь бичил калориметр, хүчил шүлтийн тэнцвэр, цахилгааны эсэргүүцэл, урсгалын цитометрийн аргыг ашигладаг. Гар аргаар ажилладаг анализаторыг жижиг эмнэлгийн лабораторид хэрэглэдэг. Цусны өсгөвөрийн автомат анализаторыг ихэвчлэн олон тооны туршилтуудыг хийдэг лабораториудад ашигладаг. Зарим анализатор биеийн шингэний бичил биетийн өсөлтийг илрүүлж чаддаг.



CYTOMETERS

ЦИТОМЕТР

UMDNS CODE 18631

Laboratory chemical analyzers that measure and characterize cells and cellular constituents.

Цитометр нь эс болон эсийн тогтоцыг тодорхойлох болон хэмжихэд зориулсан лабораторийн химийн анализатор юм



VENTILATORS, INTENSIVE CARE, ADULT

АМЬСГАЛЫН АППАРАТ, ЭРЧИМТ
ЭМЧИЛГЭЭНИЙ, НАСАНД ХҮРЭГСДИЙН

UMDNS CODE 18792

Intensive care ventilators designed for adult ventilation and/or respiratory support. These ventilators typically consist of a breathing system that applies pressure and volume and that includes a flexible tubing adequate for adult patients; they may also include continuous positive airway pressure (CPAP) and positive end-expiratory pressure (PEEP) controls. Adult intensive care ventilators are used in critically ill patients with respiratory failure.



Амьсгалын аппарат нь насанд хүрэгчдийн амьсгал болон амьсгалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зориулалттай эрчимт эмчилгээний төхөөрөмж юм. Эдгээр амьсгалын аппарат нь ихэвчлэн насанд хүрэгчдэд зориулсан, уян хоолойгоор дамжуулан даралт, эзлэхүүнийг нэмэгдүүлдэг амьсгалын системээс тогтоно. Мөн түүнчлэн тасралтгүй эерэг даралтаар амьсгалуулах (CPAP) болон амьсгал гаргалтын төгсгөлийн эерэг даралтын (PEEP) хяналтуудтай байдаг. Насанд хүрэгчдийн эрчимт эмчилгээний амьсгалын аппарат нь амьсгалын дутагдал бүхий хүнд өвчтэй хүмүүст ашиглагддаг.

RADIOFREQUENCY THERAPY SYSTEMS

РАДИОДАВТАМЖИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ
СИСТЕМ

UMDNS CODE 18800

Systems designed for the minimally invasive treatment of diseases by applying electromagnetic energy, usually in the frequency range from 10 kHz to several megahertz. These systems typically consist of a radio-frequency generator and a delivery system that may include applicators, cables, electrodes, and/or catheters; the power and frequency of the generator and the configuration of the delivery system depend on the intended use.

Радиодавтамжийн эмчилгээний систем нь 10 кГц-ээс хэдэн МГц хүртлэх давтамжтай цахилгаан соронзон долгионыг ашиглан өвчний инвазив эмчилгээ хийх зориулалттай систем. Эдгээр систем нь ихэвчлэн радио давтамжийн генератор, дамжуулагч систем, эмчилгээг дамжуулагч багаж, кабель, электрод зэргээс бүрдэнэ. Генераторын чадал, давтамж, дамжуулах системийн төрөл нь төхөөрөмжийн ашиглалтын зорилгоос хамаарна.



MICROWAVE THERAPY SYSTEMS

БОГИНО ДОЛГИОНЫ ЭМЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ

UMDNS CODE 18812

Systems designed for minimum access treatment of diseases by applying electromagnetic energy, usually in the frequency range from 300 MHz to 300 GHz. These systems typically consist of a microwave generator and an appropriate delivery system that usually includes cables, antennas, applicators, and/or catheters, according to the intended use.

Богино долгионы эмчилгээний систем нь 300МГц-ээс 300ГГц-ийн хүрээний давтамжтай цахилгаан соронзон долгионыг ашиглан эмчилгээ хийдэг систем. Энэ систем нь богино долгионы үүсгүүр болон зориулалтын кабель, антен, катетер зэргийн багтаасан дамжуулах системээс бүрдэнэ.




ULTRASOUND THERAPY SYSTEMS

ХЭТ АВИАН ЭМЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ

UMDNS CODE 18823

Systems designed for minimum-access treatment of diseases by applying energy at frequencies over the human upper audible limit (about 20 kHz) and up to several megahertz. These systems typically consist of a radio-frequency generator and an appropriate delivery system that includes cables and/or catheters and electrical to ultrasonic transducers; the power and frequency of the generator and the configuration of the delivery system and transducers depend on the intended use.

Хүний сонсголын түвшингээс дээш болон (ойролцоогоор 20 кГц орчим), хэдэн мегагерц хүртэл давтамж бүхий энергийг ашиглан өвчний хамгийн энгийн эмчилгээнд зориулсан систем. Эдгээр систем нь радио давтамжийн генератор, хэт авианы хувиргагч трансдюсерт холбогдох кабел эсвэл катетер бүхий зориулалтын дамжуулах систем, генераторын чадал ба давтамж, дамжуулах системийн тохиргоо, хэрэглээнээс шалтгаалсан трансдюсер зэргээс бүрдэнэ.



COOLING UNITS

ХӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖ

UMDNS CODE 18849

Devices that use a refrigerating or other cooling mechanism (e.g., ice, solid state thermoelectric systems, heat exchangers) to remove heat from a substance, material, fluid, or another device that dissipates heat. Cooling units contain a cooling device, pumps to circulate air or other fluids, and programmable controls and displays for temperature, pressure, or flow rate; some feature alarms to sounds alerts when system functions do not meet set parameters. Some cooling units are portable, and some may be specifically configured to cool certain pieces of equipment (e.g., laser coolers). Also available are cooling units that help lower a patient's body temperature or cool operating room personnel by coupling them with cooling blankets or garments.

Шингэн, материал, дээжээс халууныг арилгах төхөөрөмж болон хөргөх механизм (ж.нь. мөс, хатуу төлөвт термо-цахилгаан систем, дулаан солилцогчууд)-ыг ашигладаг төхөөрөмж юм. Хөргөлтийн хэсэг нь хөргөх төхөөрөмж, агаар эсвэл бусад шингэнийг эргэлдүүлэх шахуурга, температур, даралт, урсгалын хэмжээг харуулах дэлгэц ба програмчлагдсан удирдлагаас бүрддэг, зарим системийн үйл ажиллагааг тохируулсан параметруудтэй таарахгүй үед сэрэмжлүүлэх дуут дохио өгдөг. Зарим хөргөх төхөөрөмж нь суурин, зарим нь тодорхой хэсэг тоног төхөөрөмжийг (жишээ нь, лазер хөргөгч) хөргөхөд зориулж тусгайлан тохируулсан байж болно. Түүнчлэн үйлчлүүлэгчийн биеийн температурыг бууруулах, хөргөх хөнжил, хувцас зэргийг хослуулан хагалгааны өрөөг хөргөх боломжтой.



INCUBATOR/RADIANT WARMING UNITS, INFANT, MOBILE

ИНКУБАТОР/ ДУЛААЦУУЛАХ ШИРЭЭ, НЯРАЙН, ЗӨӨВРИЙН

UMDNS CODE 18857

Devices that combine the thermal capabilities of mobile infant incubators with the access advantages of infant radiant warming units. These devices provide a centralized control and monitoring system for both the incubator and the warming unit; typically, they can be automatically converted from a closed incu-

Дулаацуулах төхөөрөмж бол зөөврийн инкубатортой хослол төхөөрөмж юм. Энэхүү төхөөрөмж нь инкубатор ба дулаацуулагчийн аль алийг нь удирдах төв удирдлага болон дэлгэцтэй; Ихэвчлэн тэд хаалттай инкубатороос нээлттэй дулаацуулагчийн төхөөрөмж рүү автоматаар өөрчлөх боломжтой. Энэ нь хэдхэн секундын дотор хялбархан гүйцэтгэгддэг. Инкубатор/

bator to an open-bed radiant warming unit and vice versa with little effort in a few seconds. Incubator/radiant warming units are used to maintain a stable environment for infants, avoiding the need for transfer between incubators and radiant warming units.

дулаацуулагч нь шинэ төрсөн нярайг инкубатор болон дулаацуулагчийн хооронд шилжүүлэхээс зайлсхийж, нярайг тогтвортой орчинд байлгахад хэрэглэгддэг.



LASERS, DIODE, DERMATOLOGIC

ЛАЗЕР, ДИОДОН, АРСНЫ

UMDNS CODE 18858

Diode lasers used in the treatment of a variety of skin diseases, including vascular and pigmented lesions such as telangiectasia, angiomas, spider veins, and port wine stains. These lasers typically consist of a portable diode laser generator and a set of specialized handpieces appropriate for laser delivery to the skin lesion.

Арьсны янз бүрийн өвчин, түүний дотор судасны болон телангейст, нөсөөжилтийн өөрчлөлт, цусан судал, толбо үүсгэх эмгэгийн үед хэрэглэнэ. Энэ лазер нь зөөврийн диодон лазерийн үүсгүүрээс бүрддэг ба арьсанд лазерийг хүргэх зориулалтын гартай байна.



AIRWAY CLEARANCE UNITS

АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦЭВЭРЛЭХ АППАРАТ

UMDNS CODE 18863

Devices designed for non-invasive, automated assist in removing secretions from the lower respiratory tract (i.e., enhancing secretion clearance from the airways); some units are also intended for treating incomplete expansion of the lungs (i.e., atelectasis). These units may use one or more of different techniques, including the application of positive pressure to the airways opening, high-frequency oscillation (HFO) of the air column in the conducting airways, and external high-frequency compression to the chest wall. Airway clearance units are frequently used in acute or chronically ill patients for replacing and/or in addition to traditional procedures, such as postural drainage, manual percussion, or mechanical aspiration of the airways.

Амьсгалын доод замаас шүүрлийг автоматаар соруулах инвазив бус төхөөрөмж юм. (үүсэх шүүрэлтийг багасгах) Зарим төхөөрөмж нь уушгины (жишээ нь атлектаз) бүрэн бус эмчилгээнд хэрэглэгдэнэ. Төхөөрөмж нь хэд хэдэн хэсгээс бүрдэнэ. Үүнд амьсгалын замд эерэг даралтаар нөлөөлөх хэсэг, өндөр давтамжаар доргиож амьсгалын замын дамжуулалт сайжруулах хэсэг, цээжний гадна талаас өндөр давтамжаар дарж доргиох хэсгүүд байна. Цочмог болон архаг өвчтэй хүмүүст хэрэглэж болох ба уламжлалт ажилбаруудыг орлуулах эсвэл нэмэлт үйл ажиллагааны үед хэрэглэж болно. Жишээ нь бөглрөл гаргах, гар аргаар доргиох, амьсгалын замын механик аспираци гэх мэт.



AUDITORY FUNCTION SCREENING DEVICES, NEWBORN

СОНСГОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ ТӨХӨӨРӨМЖ, НЯРАЙН

UMDNS CODE 20167

Auditory function screening devices designed to detect hearing loss in new borns. Tests are based on the assess (either manual or automated) of the response

Сонсголын хэвийн үйл ажиллагааг илрүүлэх төхөөрөмж нь шинээр төрсөн нярайн сонсголын алдагдлыг илрүүлэхэд зориулагдсан. Шинжилгээ нь дуу цацаргалтыг (OAE) бүртгэх замаар чихнээс чихний дун хүртэлх сонсголын замын хариу

of the hearing pathway from the ear to the cochlea by detecting the otoacoustic emissions (OAE); from the ear to the brainstem by detecting the auditory brainstem response (ABR); or both. These devices typically consist of an audio frequency generator, earphones, sensors, cables, a computerized processing unit, and a display and/or printer.



MONITORS, PHYSIOLOGIC, MULTIPURPOSE, BEDSIDE

үйлдлийн үнэлгээ, чихнээс тархины судал хүртэлх сонсголын тархины судлын хариу үйлдлийг бүртгэх арга эсвэл 2-ууланг нь зэрэг явуулсан үнэлгээнүүд дээр тус тус үндэслэнэ. Илрүүлэх замаар хариу арга хэмжээний (гарын авлага эсвэл автоматаар). Эдгээр төхөөрөмж нь ихэвчлэн аудио давтамжийн генератор, чихэвч, мэдрэгч, кабель, компьютержсэн боловсруулах төхөөрөмж, дэлгэц ба / эсвэл принтерээс бүрддэг.

МОНИТОР, ФИЗИОЛОГИЙН, ОЛОН
ҮЙЛДЭЛТ, ХЯНАЛТЫН

UMDNS CODE 20170

Bedside monitors designed to acquire, measure, display, monitor, record/store, and in some cases analyze information related to one or more physiologic parameters reflecting a patient's clinical condition. These monitors contain electronic circuits or other technology designed to acquire and/or process the signal from one or more physiologic sensors (e.g., electrodes, catheters, probes, pressure transducer sets). Physiologic bedside monitors are designed to be externally connected via cables/leads to the appropriate sensors (e.g., electrodes, catheters, probes, transducer sets) attached to or inserted in the patient. Physiologic bedside monitors, when used as part of a patient monitoring system, allow users to change or add monitored parameters for an individual patient without having to employ other monitors or interrupt the monitoring of other parameters.

Монитор нь өвчтөний эмнэлзүйн нөхцлийг илэрхийлэх нэг буюу хэд хэдэн физиологийн параметртэй холбоотой мэдээллийг илрүүлэх, хэмжих, дэлгэцэд харуулах, хянах, бичих/хадгалах, зарим тохиолдолд шинжлэх зориулалттай. Эдгээр монитор нь нэг буюу хэд хэдэн физиологийн мэдрэгч элементээс (жишээ нь электрод, катетер, проб, даралтын датчкын багц) ирэх дохиог илрүүлэх ба боловсруулах зориулалттай цахилгаан хэлхээ болон бусад технологиос бүрддэг. Өвчтөний биед нэвтрүүлсэн эсвэл холбосон зориулалтын мэдрэгч элементийг (ө.х электрод, катетер, проб, даралтын датчкын багц) кабелиар буюу холбогчоор дамжуулан хяналтын мониторт холбоно. Өвчтөний хяналтын мониторгыг өвчтөний хяналтын системийн хэсэг болгон ашигладаг бөгөөд хэрэглэгчийн шаардлагаас хамааран бусад хяналтын мониторийн үйл ажиллагаа эсвэл параметрын хяналтыг тасалдуулахгүйгээр нэг өвчтөний хяналтын параметрыг өөрчлөх болон нэмэх боломжтой байдаг.



MONITORS, CENTRAL STATION

UMDNS CODE 20179

Monitors designed to be positioned in a central location, usually at a nurses' station; they typically consolidate information (e.g., audible and visual alarms) from individual bedsides and/or telemetry monitors. These monitors usually display an electrocardiogram for each patient being monitored; they include computing capabilities and additional displays to observe trend information; some also include full-disclosure capabilities. Central station monitors are used for full remote monitoring of patients in one or more areas of a healthcare facility; however, they do not replace bedside monitors.

МОНИТОР, ТӨВИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Нэгдсэн хяналтын төвийн монитормыг нь тасгийн төвд байрлуулах зориулалттай бөгөөд ихэвчлэн сувилагчийн байршилд байрлуулдаг. Энэхүү монитор нь өвчтөн тус бүрийн болон телеметрийн монитормын ерөнхий мэдээллийг дүүт болон харагдах байдлаар сувилагчдад нэгтгэн хүргэх зориулалттай. Эдгээр монитор нь ихэвчлэн хяналтад байгаа өвчтөн тус бүрийн зүрхний цахилгаан бичлэгийг үзүүлдэг. Нэмэлтээр зарим мэдээллийг үзүүлэх, үзүүлэлтийг тооцооллийг гаргадаг, зарим нь бүрэн мэдээллийг гаргах боломжтой байна. Төвийн нэгдсэн хяналтын монитор нь эмнэлгийн нэг болон нэлээд хэдэн тасгийн өвчтөнүүдийг алсаас бүрэн хянахад зориулагдсан бөгөөд хэдий тийм боловч өвчтөний хажуугийн хяналтын монитормыг орлохгүй болно.



MONITORS, ТЕЛЕМЕТР, UTERINE
ACTIVITY

МОНИТОР, ТЕЛЕМЕТР, УМАЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ

UMDNS CODE 20181

Monitors designed for continuous measurement and display of the frequency and intensity of uterus contractions (i.e., uterine activity) from a distant location through a point-to-point radio or other appropriate communication link (i.e., telemetric). These monitors typically consist of a main unit clipped to the patient's gown (or carried in a pouch) which includes electronic circuits that can process signals from external sensors, a transducer, a display, and audible and/or visual alarms that are triggered when the uterine contractions are below (or exceed) preset limits. The monitor also includes a receiver that is integral or associated to the central station where the information is displayed. Telemetric uterine activity monitors are used at home, in physician's offices and sometimes in hospitals. Fetal monitors that can evaluate the fetus status and the uterine activity of the mother are also available.



Монитор нь умайн агшилтын хүч ба давтамжийг дэлгэцэд харуулж, удаан хугацаагаар хянах зориулалттай (Умайн үйл ажиллагааг). Монитор нь алслагдсан байршилтай радио эсвэл бусад холбогдох холбооны хэрэгслэлээр дамжуулан цэгээс цэгт хүрнэ. (жишээ нь, телеметрийн). Телеметрийн монитор нь умайн агшилтаар хэвлийд гарах өөрчлөлтийг бүртгэх, мэдрэгч дээр суурилагдсан гадаад мэдрүүр, хувиргагч, дэлгэц, дуут дохиолол болон умайн агшилт нь урьдчилан тогтоосон хязгаарын хязгаараас хэтэрсэн үед дохиолол үүсгэдэг электрон хэлхээг багтаадаг. Мөн мэдээллийг харуулах төв (нэгдсэн хяналтын төв)-тэйгээ салшгүй холбоотой байх бөгөөд хүлээн авагчтай байна. Эдгээр төхөөрөмжийг умайн агшилтыг хянах зорилгоор гэрт, эмчийн өрөөнд, заримдаа эмнэлэгт төрөхийн өмнө хэрэглэнэ. Ургийн монитор нь ургийн төлөв байдлыг үнэлдэг ба эхийн умайн хүзүүний үйл ажиллагааг мөн хянадаг.

BRACHYTHERAPY SYSTEMS

БАКУ/ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭНИЙ
СИСТЕМ

UMDNS CODE 20352

Systems designed to perform radiotherapy by administering a radioisotope directly into tissue (e.g., tumor, intravascular) to prevent or reduce tissue proliferation. These systems typically include a radiation delivery unit, a source safe, applicators, and controls. Brachytherapy systems (e.g., remote afterloading systems) are used to treat cancer and other types of abnormal proliferative tissue (e.g., intravascular restenosis), minimizing the radiation dose to surrounding

Баки/Хавдрын эмчилгээний систем нь эдийн тархалтыг бууруулах эсвэл саатуулахын тулд эд рүү шууд радиоизотопийг холбох замаар цацраг туяа эмчилгээг хийхэд зориулагдсан юм. Эдгээр систем нь ихэвчлэн цацаргалтыг дамжуулах хэсэг, эх үүсвэрийн аюулгүй байдал, эмчилгээний зүйлсийг дотогш оруулах дамжлага багаж болон хяналт хийх хэсгүүдээс бүрддэг. Бакиэмчилгээний систем (ж.нь. алсаас ачаалагдах систем) нь хорт хавдар болон бусад хэвийн бус тархалт ихтэй

tissue and avoiding hospital staff exposure to radiation.



SCANNING SYSTEMS, ULTRASONIC,
ENDOSCOPIC

эдийг (жишээ нь, судасны нөхөн сэргээлт) эмчлэх, эдийн эргэн тойронд байгаа эрүүл эдэд очих цацрагийн түнгийн хэмжээг бууруулах, цацраг идэвхт бодисын хордлогод эмчийг өртөхөөс сэргийлэхэд ашиглагддаг.

СКАН, СИСТЕМ, ХЭТ АВИАН,
ЭНДОСКОП

UMDNS CODE 20378

Ultrasonic scanning systems designed for endoscopic imaging. Some systems include a processor attached to a dedicated ultrasonic endoscope, while other systems attach the processor either to an ultrasonic probe that can be passed through the working channel of standard endoscopes (e.g., gastroscopes, colonoscopes) or to rigid probes (e.g., rectal probes). The ultrasonic system probes include ultrasonic transducers up to 20 MHz frequency to obtain high-resolution images that can be monitored, recorded, post-processed, and/or used for further studies. Endoscopic ultrasonic scanning systems are used to obtain additional information to endoscopic imaging, especially in colon, rectal, and upper gastrointestinal tract studies; they are also used in some special ultrasonic procedures (e.g., ultrasonic-guided needle biopsy).

Уян дуранд зориулсан хэт авиа оношилгооны систем. Энгийн стандарт дурангийн ажлын сувагаар тусгай хэт авиа бүхий хатуу датчик ашиглан өөр өөр дурангийн систем дээр дурантай ЭХО хийх боломжтой. Энэ үед тусгай, ЭХО нд зориулсан тусгай процессор ашигладаг. (Жишээ нь ходоодны дуран, бүдүүн гэдэсний дуран, ректал датчик). Хэт авиа систем бүхий проб нь 20MHz хүртэл давтамж бүхий өндөр нягтралтай зураг гаргадаг, бөгөөд дүрсийг хянах, бичих, зураг боловсруулалт зэргийг хийх боломжтой. Дурантай ЭХО системийг дээд гэдэсний замын үзлэг шинжилгээ болон бүдүүн гэдэс, ректал зэрэг дурангийн оношилгооны үед нэмэлт мэдээлэл олож авах зорилгоор ашигладаг. Эдгээрээс гадна мөн эдээс дээж авах процедурийн үед ашиглаж болно. /Жишээ нь дурантай хэт авиаан аргаар биопси авах/



ANALYZERS, POINT-OF-CARE, WHOLE
BLOOD, GLYCATED HEMOGLOBIN

АНАЛИЗАТОР, ТУСЛАМЖИЙН,
ЦУСАНД, ГЛЮКОЗ, ГЕМОГЛОБИН

UMDNS CODE 20385

Point-of-care whole blood analyzers dedicated to measuring the concentration of glycated hemoglobin (HbA_{1c}), also known as glycohemoglobin, in a sample of capillary blood. These analyzers may use several measuring techniques, including photometry and immunoassay. The amount of HbA_{1c} in blood represents the integrated values for glucose in the previous three month period. HbA_{1c} point-of-care analyzers are mostly used in physician's offices for assessing glucose control.

Анализатор нь хялгасан судасны дээжинд глицетийн гемоглобин (HbA_{1c})-ны агууламжийг хэмжихэд зориулагдсан байдаг. Эдгээр анализатор нь фотометрийн болон дархлаа судлалын хэд хэдэн хэмжих аргыг ашиглаж болно. Цусан дахь глюкозын хэмжээг өмнөх 3 сарын хугацаанд хэмжсэн глюкозын нийт утгад харьцуулан харуулдаг. HbA_{1c} point-of-care анализаторыг ихэвчлэн эмчийн өрөөнд цусан дахь глюкозын хэмжээнд хяналт хийхэд зориулан ашигладаг.



LAPAROSCOPES, DIAGNOSTIC

ЛАПАРОСКОП, ОНОШИЛГООНЫ

UMDNS CODE 20484

Laparoscopes designed for viewing the organs of the abdominal cavity; their diameter typically ranges from 5 to 10 mm, although some small-diameter laparoscopes about 2 mm in diameter (microlaparoscopes) are frequently used in diagnostic procedures. These instruments may be rigid or flexible; they do not have instrument channels. Diagnostic laparoscopes are used to visualize gynecologic conditions, determine the causes of infertility and chronic abdominal pain, and assess the condition of diseased livers, including the performance of biopsies.

Хэвлийн хөндийн эрхтэнг дурангаар оношлоход зориулагдсан төхөөрөмж бол Лапароскоп. Ихэвчлэн 5-10 мм-ийн диаметртай байдаг хэдий ч голдуу 2мм-ийн диаметртай лапароскопыг (микролапароскоп) оношилгоонд ашигладаг. Эдгээр дуран нь хатуу болон уян байдаг бөгөөд багажийн суваггүй байна. Оношилгооны лапароскопийг эмэгтэйчүүдийн өвчлөл, үргүйдлийн шалтгааныг тодорхойлоход ашигладаг ба архаг хэвлийн өвдөлт болон элэгний өвчлөлийн нөхцөл байдлыг үнэлэхэд үед биопсийн шинжилгээтэй хослуулан оношилгоог хийх боломжтой.



LAPAROSCOPES, SURGICAL

ЛАПАРОСКОП, МЭС ЗАСЛЫН

UMDNS CODE 20485

Laparoscopes designed to perform surgery, including laser and electrosurgery procedures, through their working channels; their diameter typically ranges from 8 to 12 mm. These instruments incorporate prisms or mirrors that transmit reflected light to and from the tissue through one or two bends to the eyepiece, which is offset from the laparoscope shaft so that a surgical instrument can be inserted through a separate instrument channel in the shaft and manipulated freely. Surgical laparoscopes are used with other specialized surgical instruments to perform minimally invasive surgical procedures such as cholecystectomy (removal of the gallbladder), appendectomy, and hysterectomy.

Лапароскоп нь ажлын сувгаар дамжуулан хэвлийн хөндийн эрхтэнд лазер болон цахилгаан коагуляц зэрэг мэс ажилбар хийх зориулалттай 8-12 мм-ийн диаметр бүхий лапароскоп. Энэхүү төхөөрөмж нь призм болон толин тусгалын тусламжтай гэрлийг нэг буюу хоёр дурангаар дамжуулан эд эрхтэнд тусгаж, мэс заслын багажийг ажлын сувгаар оруулж, чөлөөтэй удирдан мэс ажилбарыг хийдэг. Хэвлийн хөндийн мэс заслын дуранг тусгай мэс заслын багаж хэрэгслийн хамт цөс, мухар олгой, сав тайрах зэрэг мэс заслын үед ашиглана.



ENCEPHALOSCOPES, FLEXIBLE

ЭНЦЕФАЛОСКОП/ ТАРХИНЫ УЯН ДУРАН/

UMDNS CODE 20487

Encephaloscopes with a nonrigid (i.e., flexible) structure that are capable of being manipulated in curved paths into the cranium; they are used for the removal of tumors and cysts and the performance of other endosurgical procedures such as treatment of bleeding and catheter implantation. Flexible encephaloscopes may include an attached video camera to allow the performance of procedures under direct video observation.

Энцефалоскоп нь гавлын хөндийд нуман байдлаар орж, дурангийн аргаар цус тогтоох, катетер суулгах замаар хорт хавдар, үйланхайг авдаг. Уг уян дуран нь видео камер холбогдож ажилбарыг шууд дэлгэцээр харан хийх боломжтой.



CABINETS, STORAGE, ENDOSCOPE

КАБИНЕТ/ШҮҮГЭЭ, ХАДГАЛАХ,
ЭНДОСКОП

UMDNS CODE 20597

Cabinets designed for organized storage and display of cleaned endoscopes (e.g., bronchoscopes, gastroscopes, colonoscopes). These cabinets are typically manufactured using materials (e.g., stainless steel, polypropylene, acrylic) that permit ease of cleaning; they include endoscope holders and may also include special soft-plastic brackets to secure the endoscope heads. Endoscope cabinets should have proper vents to keep the devices dry. Some cabinets circulate clean air using a high-efficiency particulate-air filter, exhausting the air back into the room through an activated carbon filter. Endoscope storage cabinets are used to keep endoscopes clean for the next procedure after they are decontaminated and all removable parts are detached. Endoscopes should not be stored in their carrying cases.

Угааж цэвэрлэсэн дуранг /уушгины, ходоодны, бүдүүн гэдэсний г.м/ хадгалах, харахад зориулан хийсэн шүүгээ юм. Уг шүүгээ нь зэвэрдэггүй ган, полипропилен, акрилан материалаар хийгддэг нь цэвэрлэхэд хялбар байдаг. Кабинет дотор нь дуран баригч, дурангийн толгой хадгалах тусгай зөөлөн хуванцараар хийсэн сагс зэрэг байна. Дурангийн кабинет-шүүгээг хуурай байлгах нарийн агааржуулалтын системтэй байна. Зарим кабинет нь HEPA /өндөр ашигтай агаарын хий/ шүүлтүүрийг ашиглан өрөөний агаарыг буцаан гаргадаг. Дурангийн хадгалах кабинет нь дуранг халдваргүйжүүлж, бүх хөдөлгөөнт хэсгүүдийг салгасны дараа дараагийн шинжилгээнд зориулж цэвэр байлгах зориулалттайгаар ашиглана. Дуранг түүнийг тээвэрлэх тэргэнцэр дээр хадгалдаггүй.



CABINETS, STORAGE, LABORATORY

КАБИНЕТ/ШҮҮГЭЭ, ХАДГАЛАХ,
ЛАБОРАТОРИЙН

UMDNS CODE 20616

Cabinets designed to store, display, and provide ready access to small equipment, instruments, labware, and/or chemicals; they may also include a working surface (e.g., the top of the cabinet) for laboratory procedures. They are usually made of wood, laminate, metal (including stainless steel), or a combination of these, permitting ease of cleaning and sterilization. These cabinets typically consist of

Лабораторийн шүүгээ нь жижиг багаж хэрэгсэл, лабораторийн өмсгөл, химийн бодисууд зэргийг хадгалах, авч хэрэглэхэд хялбар байхаар бүтээгдсэн. Лабораторийн шинжилгээ хийх ажлын талбайтай байна. Ихэвчлэн мод, ламинат, метал (зэвэрдэггүй ган) болон эдгээрийн холимогтой хийгдэх ба цэвэрлэж, ариутгахад хялбар байх шаардлагатай байдаг. Ерөнхийдөө олон тавиур, шүүгээ эсвэл эдгээрийн холимогтой байна.

multiple drawers, shelves, or a drawer/shelf combination. Some include special compartments for corrosive chemicals. Laboratory cabinets are available in multiple configurations (e.g., stand-alone, wall-mounted) and usually include sliding or hinged glass or solid doors; some also include security locks. Laboratory cabinets are used mainly in clinical laboratories, but they may be used to store and/or manipulate chemical products in physician's offices and in dental and ophthalmologic clinics.

Зарим шүүгээ нь идэмхий шинж чанартай химийн бодисуудыг хадгалах тусгай тасалгаатай байна. Хэлбэр хэмжээний хувьд олон төрөл (суурьтай, хананд бэхэлдэг гэх мэт) байх ба ихэвчлэн нугастай эсвэл гүйж онгойдог шилэн хаалгатай, мөн цоожтой байдаг. Лабораторийн шүүгээ нь ихэвчлэн клиник лабораториудад хэрэглэгддэг. Зарим тохиолдолд эмчийн ажлын өрөө болон нүдний эмнэлгүүдэд химийн бүтээгдэхүүн хадгалахад хэрэглэгдэж болно.



CABINETS, BIOLOGICAL
SAFETY, CLASS II

КАБИНЕТ, БИОЛОГИЙН АЮУЛГҮЙН,
ЗЭРЭГЛЭЛ II

UMDNS CODE 20653

Biological safety cabinets designed to protect the operator, the environment, and the samples inside the cabinet from low- and moderate-risk biological agents (e.g., human pathogens). These cabinets typically consist of an enclosure with an open front for handling of products. They include blowers to produce an inward vertical laminar flow of room air into the hood and an exhaust system; both the inward vertical laminar airflow system and the exhaust-air system include high-efficiency particulate-air (HEPA) filters (for product and environmental protection, respectively). Class II cabinets are, by far, preferred for most clinical laboratories for handling of cell cultures and human pathogens (e.g., bacteria, viruses, parasites), for tissue culture and tumor virus work, and for handling extremely toxic agents (e.g., chemotherapy drugs). Class II microbiological safety cabinets are further classified in types A (exhaust of air to the room environment through HEPA filter) and B

Биологийн аюулгүйн кабинет нь лабораторийн ажилтан, байгал орчин, кабинетын дотор байгаа дээжийг бага-дунд зэргийн эрсдэлт биологийн үүсгэгчээс хамгаалах зорилгоор бүтээсэн. Энэ кабинет нь ихэвчлэн нүүрэн талаас онгойх хаалтнаас тогтдог. Түүнчлэн энэ кабинет нь өрөөний агаараас гадагшлуулагч систем рүү чиглэсэн дотоод ламинар урсгал үүсгэх салхивчтай байна. Дотоод ба гадаад ламинар урсгалын систем нь HEPA /өндөр ашигтай агаарын хий/ шүүлтүүртэй байна. II зэрэглэлийн кабинетууд нь клиник лабораториудад эс, хүний биед өвчин үүсгэгч бактери, вирус, шимэгчүүдтэй ажиллахад, эдийн шинжилгээ, хорт хавдар вирус, маш аюултай хорт бодистой /химийн эмчилгээний эм/ ажиллахад ашиглагдана. Уг кабинетыг дотор нь А төрлийн буюу HEPA шүүлтүүрээр өрөөнд агаар сэлгэх, В төрлийн буюу HEPA шүүлтүүрээр гадаад орчинд агаар сэлгэх гэж 2 ангилна. А төрлийн кабинетын бүтэц ба агаарын урсгалын хүрд нь бичил биологийн хэрэглээнд тохиромжтой

(hard-ducted to the outdoor environment, exhaust of air through HEPA filter). The construction and the air-flow velocities and patterns of type A cabinets make them suitable for microbiological use but not for handling volatile or toxic chemicals and radionuclides, while the characteristics of class B cabinets permit their use with toxic chemicals and radionuclides.

ч ууршимтгай, химийн бодис, цацраг идэвхт бодистой ажиллахад тохиромжгүй. В төрлийн кабинет нь ууршимтгай, химийн бодис, цацраг идэвхт бодистой ажиллахад тохиромжтой.



ANALYZERS, LABORATORY, MOLECULAR ASSAY

АНАЛИЗАТОР, ЛАБОРАТОРИЙН, МОЛЕКУЛЫН ШИНЖИЛГЭЭ

UMDNS CODE 20668

Laboratory analyzers designed for automated performing, processing, displaying, and reporting the results of molecular assays. These analyzers integrate all the steps of the analysis, including sample (i.e., nucleic acid) preparation, amplification, and detection. The analyzers may use one or more of several technologies, such as polymerase chain reaction (PCR), reverse transcriptase PCR (RT-PCR), fluorescent in situ hybridization (FISH), and nucleic acid sequence based amplification (NASBA) or branched DNA signal amplification (bDNA). They perform the detection either directly (e.g., using a fluorimeter or luminometer, melting curve analysis) from a sample that was previously replicated in a separate instrument or include a nucleic acid replication processor (e.g., a thermal cycler) that amplifies a previously purified nucleic acid sample. Molecular assay analyzers are used clinically to detect, identify, and/or quantify molecules of microorganisms (e.g., bacteria, virus, fungus) and/or genetic abnormalities based in the characteristics of the patient's nucleic acids (e.g., DNA, RNA, mRNA).

Анализатор нь молекулын шинжилгээний үр дүнг автоматаар гүйцэтгэх, боловсруулах, үзүүлэх, тайлагнах зориулалттай лабораторийн анализатор юм. Эдгээр анализатор нь дээж (жишээ нь: нуклейн хүчил) бэлтгэх, олшруулах, илрүүлэх зэргийг багтаасан шинжилгээний бүхий л алхмуудыг нэгтгэн хийдэг. Анализатор нь полимеразын гинжин урвал (ПГУ), урвуу транскриптазийн ПГУ (РТ-ПГУ), флюоресцент дахь гибридизаци (FISH), нуклейн хүчил дарааллын тулгуурласан олшруулалт (NASBA), эсвэл салаалсан ДНХ, олшролт (bDNA) дохиог өсгөх зэрэг нэг эсвэл хэд хэдэн технологийг ашиглаж болно. Эдгээр төхөөрөмжүүд нь урьдчилан цэвэршүүлсэн нуклеан хүчлийн дээжийг өргөжүүлсэн нуклеан хүчлийн олшруулагч (жишээ нь, дулааны циклер)-ыг агуулсан эсвэл салангид төхөөрөмжид урьдчилан дахин олшруулсан дээжээс шууд шинжилгээг (жишээ нь, флуориметр эсвэл гэрэлтүүлэгч, хайлах муруйн шинжилгээ) хийж илрүүлэлтийг гүйцэтгэдэг. Молекулын шинжилгээний анализатор үйлчлүүлэгчийн нуклейн хүчлүүдийн шинж чанар (ДНХ, РНХ, мРНХ) дээр үндэслэсэн генетикийн гажиг илрүүлэх,



бичил биетний молекул (жишээ нь, бактери, вирус, мөөгөнцөр)-ын тоог гаргах, тодорхойлох, илрүүлэхэд ашиглагддаг.

WATER PURIFICATION SYSTEMS,
REVERSE OSMOSIS, HEMODIALYSIS

УС ЦЭВЭРШҮҮЛЭХ СИСТЕМ,
УРВУУ ОСМОС, ГЕМОДИАЛИЗ

UMDNS CODE 20682

Reverse osmosis (RO) water purification systems designed to deliver water pure enough for hemodialysis procedures. These systems typically consist of a container with a central semi-permeable membrane separating the contaminated water from the purified water. Hydrostatic pressure high enough to exceed the osmotic pressure is then applied to the contaminated water section. The membrane is permeable to water but impermeable to the solutes thus providing purified water on the other side of the membrane. RO systems used in hemodialysis remove salts, metal ions, and particulates to a greater degree than standard RO systems. Water obtained after the procedure should be tested periodically due to the high volume of water that patients are exposed to during hemodialysis in which even trace quantities of contaminants (e.g., aluminum) may be dangerous. The elimination of chloramines (e.g., using a carbon bed) present in tap water is also essential. Hemodialysis reverse osmosis is usually performed after filtration to eliminate particulates from the incoming water. Deionization, ultrafiltration, and/or disinfection with ultraviolet radiation may be needed after reverse osmosis if the presence of contaminants is high due to the fact that RO removes percentages (e.g., 95 to 99 percent) rather than fixed quantities of contaminants. Portable hemodialysis RO systems are also available.

Гемодиализын эмчилгээнд зориулсан цэвэр ус дамжуулах зориулалттай урвуу осмос (RO) ус цэвэршүүлэх систем. Эдгээр систем нь ихэвчлэн цэвэршүүлсэн уснаас бохирдсон усыг ялгах үндсэн хагас дамжуулагч мембран бүхий савтай байдаг. Осмос даралтын хэмжээнээс давсан гидростатик даралтаар бохирдсон усыг саванд юүлнэ. Мембран нь усыг нэвчүүлэх боломжтой боловч мембраны нөгөө талд цэвэршүүлсэн усаар агуулдаг үл нэвчүүлэх хатуу бодисуудтай байдаг. Гемодиализид ашигладаг RO систем нь давс, металлын ион, бусад жижиг хэсгүүдийг стандарт RO системээс илүү их хэмжээгээр ялгаж цэвэршүүлнэ. Өвчтөнд гемодиализын процедур хийсний дараа их хэмжээний бохирдол (жишээ нь хөнгөн цагаан) агуулснаас хамаарч үйлчлүүлэгчдэд аюултай байж болзошгүй учир хуримтлагдсан усыг хугацаатайгаар шалгаж байх шаардлагатай. Усны цоргод байгаа хлораминыг (жишээ нь, нүүрстөрөгчийг ашиглан) устгах нь зайлшгүй чухал юм. Гемодиализийн урвуу осмосыг ихэвчлэн орж ирж байгаа уснаас жижиг хэсгүүдийг арилгахын тулд шүүлтүүр хийхээс өмнө ашигладаг. Бохирдлын нийт тоо хэмжээнээс илүү хувийг RO устгадаг бөгөөд (жишээ нь 95-аас 99 хувь) бохирдол ихтэй байх тохиолдолд RO-с өмнө ионгүйжүүлэх эсвэл хэт ягаан цацаргаар ариутгаж болно. Зөөврийн гемодиализид RO системийг ашиглаж болно.



POSITIVE AIRWAY PRESSURE UNITS,
BI-LEVEL

ЭЭРЭГ АГААРЫН ДАРАЛТААР ХАНГАХ
ТӨХӨӨРӨМЖ, ВИ-ТҮВШНИЙ

UMDNS CODE 20743

Devices designed to apply positive airway pressure at two different separately adjustable levels (i.e., bi-level PAP) during each breathing cycle, providing independent pressures during inhalation and exhalation while the patient is performing spontaneous breathing. These units are used to assist spontaneous respiratory efforts and supplement the volume of air a patient inspires into the lungs. Some bi-level units additionally include a time back-up feature (known as spontaneous timing or S/T) to ensure that the appropriate amount of air is provided when it detects that a patient has stopped or delayed breathing. Bi-level PAP units are intended to provide noninvasive (i.e., through a nasal or oronasal mask, mouthpiece, or lipseal) positive pressure breathing assistance therapy; they are frequently used in patients suffering from restrictive thoracic disorders (e.g., muscular dystrophy, amyotrophic lateral sclerosis), severe chronic obstructive pulmonary disease (COPD), central sleep apnea, or obstructive sleep apnea (OSA). They are not intended for continuous breathing support.

Эерэг агаарын даралтаар хангах төхөөрөмж, өөрийн амьсгалтай үед амьсгалын авалт гаргалтад бие даасан даралтаар дэмжлэг үзүүлэх, амьсгалын эргэлт бүрд 2 төрлийн тусдаа тохирох түвшний (эерэг түвшний PAP) агаарын эерэг даралтыг бий болгох зориулалттай төхөөрөмж. Эдгээр төхөөрөмж нь үйлчлүүлэгчийн уушги руу нэвтрэн орж буй агаарын эзлэхүүнийг тохируулах болон нэмэгдүүлж өөрийн амьсгалыг дэмжихэд ашиглагдана. Зарим Ви-түвшинт төхөөрөмж нь нэмэлтээр, амьсгал зогссон, эсвэл удааширсан нөхцөл байдал илрэхэд шаардлагатай агаараар хангах, тодорхой хугацааны агаарыг нөөцлөх боломжтой байдаг (өөрийн амьсгалын хугацаа буюу S/T гэж нэрлэдэг). Ви- түвшинт PAP төхөөрөмж нь шууд бус (жишээ нь: хамрын болон ам хамрын хөндий хамарсан маск, амны хаалт, амны хөндийгөөр дамжуулах) эерэг даралтат амьсгалаар дэмжих эмчилгээг хийх боломжтой. Тэдгээр нь хязгаарлагдмал цээжний эмгэг (жишээ нь: булчингийн дистрофи, амуотропик хажуугийн склероз), хурц хэлбэрийн архаг уушгины сааталт өвчин (COPD), төвийн нойрны зогсолтын байдал буюу нойрны саатал (OSA) зэрэг өвчний эмчилгээнд ихэвчлэн ашигладаг. Эдгээр



нь тасралтгүй амьсгалаар дэмжих зориулалтгүй болно.

VENTILATORS, NONINVASIVE POSITIVE PRESSURE

АМЬСАЛЫН АППАРАТ, ИНВАЗИВ БУС ЭЭРЭГ ДАРАЛТААР ДЭМЖИХ

UMDNS CODE 20746

Ventilators designed for noninvasive support ventilation (e.g., through a mask or mouthpiece) in spontaneously but insufficiently breathing patients, typically in the home care environment. Noninvasive positive pressure breathing (NPPB) ventilators may use one or more of several positive pressure techniques, including continuous positive airway pressure (CPAP), bi-level continuous positive airway pressure (Bi-level PAP), or volume- or pressure-targeted ventilation. These support ventilators typically consist of a unit that delivers the positive pressure and a breathing circuit including a mask (either nasal or oronasal) or a mouthpiece for external delivery of the pressurized gas to the patient; they may also include a high-flow gas source and a manometer. NPPB ventilators are intended for patients suffering from restrictive thoracic disorders (e.g., muscular dystrophy, amyotrophic lateral sclerosis), severe chronic obstructive pulmonary disease (COPD), central sleep apnea, or obstructive sleep apnea (OSA); they are frequently used only during the night. Some intensive care ventilators include capabilities that allow their use also for noninvasive ventilation.



Амьсгалын аппарат нь гэрийн асаргаанд ашиглах боломжтой бие даан амьсгалахад хүндрэлтэй үйлчлүүлэгчийн амьсгалыг дэмжих (маск, амны хаалтаар) инвазив бус эмчилгээнд зориулагдсан амьсгалын аппарат. Инвазив бус эерэг даралтаар амьсгалуулах (NPPB) амьсгалын аппарат нь тасралтгүй эерэг агаарын даралт (CPAP), хоёр түвшинт тасралтгүй эерэг агаарын даралт (Bi-level PAP), эсвэл эзлэхүүн- буюу даралт-аар удирдсан амьсгалуулалт зэрэг хэд хэдэн эерэг даралтат технологиуд эсвэл тэдгээрийн аль нэгийг ашигладаг. Эдгээр амьсгал дэмжих амьсгалын аппарат нь эерэг даралтыг үйлчлүүлэгчдэд өгөх хэсэг, хийг дамжуулах маск болон амны хаалт бүхий амьсгалын хүрээ, эерэг даралтыг дамжуулах хэсгээс бүрдэнэ. Мөн түүнчлэн өндөр урсгалт хий үүсгэгч ба манометртай байдаг. NPPB амьсгалын аппарат нь уушгины хүндэрсэн цээжний эмгэг (жишээ нь, булчингийн дистрофи, амиотрофын хажуугийн склероз), архаг бөглөрөлт уушгины өвчин (COPD), төвийн нойрны зогсонгишил, эсвэл зүүн ховдлын нойрны зогсонгишил (OSA) зэрэг өвчнөөр өвчилсөн хүмүүст зориулагдсан; Эдгээр нь зөвхөн шөнийн цагаар хэрэглэгддэг ба зарим эрчимт эмчилгээний амьсгалын аппарат нь инвазив бус амьсгалуулалтад хэрэглэх боломжтой байдаг.

RADIOGRAPHIC SYSTEMS, DIGITAL,
TABLE

РЕНТГЕН ЗУРГИЙН СИСТЕМ,
ДИЖИТАЛ, ОР

UMDNS CODE 20793

Digital radiography systems designed with an incorporated table component to support imaging of patients while they are lying in horizontal position. These systems typically consist of an x-ray generator; a table with either an image plate for computed systems or an electronic detector for direct digital systems and attached accessories (e.g., handgrips, head clamps); an operator console; a plate reader (for computed systems); and a workstation with a monitor and digital storage devices to process the digital data and image. Table digital radiography systems are typically used for general purpose examinations, as well as specific examinations of the skull, respiratory organs, and the skeletal system.

Дижитал рентген зургийн систем нь хэвтээ байрлалд байгаа үйлчлүүлэгчийн зургийг авахад зориулсан ор бүхий рентген зураг авах дижитал систем. Эдгээр төхөөрөмж нь ихэвчлэн х-цацрагийн генератор, тооцоолох системд зориулсан дүрс буулгах хавтан, нэмэлт хэрэгслийг (гарын бэхэлгээ, толгойн хаалтууд) холбох эсвэл шууд дижитал зургийн системүүдэд зориулагдсан электроник детектор, удирдлагын хэсэг, хавтанг уншигч (тооцоолсон системд зориулсан), болон дижитал өгөгдөл, дүрсийг боловсруулах, хадгалах төхөөрөмж, дэлгэц бүхий ажлын байр зэргээс бүрдэнэ. Рентген зураг авах дижитал системийн ор нь ерөнхий үзлэгийн зориулалттай бөгөөд ялангуяа гавлын яс, амьсгалын эрхтэн болон араг ясны системийн тусгай үзлэгүүдэд ашиглагдана.



ANALYZERS, LABORATORY, MOLECULAR
ASSAY, GENETIC TESTING

АНАЛИЗАТОР, ЛАБОРАТОРИЙН, МОЛЕКУЛ
СУДЛАЛ, ГЕНЕТИК ШИНЖИЛГЭЭ

UMDNS CODE 20803

Molecular assay laboratory analyzers designed to identify mutations within a gene or chromosome alterations. These analyzers typically perform some or all of the processes of separation, hybridization genetic diseases (e.g., liquid or solid phase), replica-

Анализатор нь ген буюу хромосомын хувирлын доторх мутацийг тодорхойлох зорилготой. Эдгээр анализатор нь ихэвчлэн ангилан ялгах, гибридизаци генетикийн өвчин (ж.нь, шингэн эсвэл хатуу фаз), хувилах (жишээ нь: полимеразын гинжин урвал), илрүүлэх үйл явцын зарим буюу

tion (e.g., polymerase chain reaction), and detection; they use a fragment of nucleic acid labeled with one of a variety of reporter groups (i.e., a nucleic acid probe) and appropriate reagents. Genetic analyzers are used in the diagnosis of inherited genetic diseases (e.g., cystic fibrosis, hemophilia) or acquired genetic diseases (e.g., neoplasm) and chromosomal disorders (e.g., Down syndrome) and for detection of single nucleotide polymorphisms; some are also used for human leukocyte antigen typing to test histocompatibility before transplants and for forensic and paternity analysis.

бүх үйл ажиллагааг бие даан гүйцэтгэдэг. Тэдгээр нь янз бүрийн сурвалжлагч бүлгүүдийн (жишээ нь: нуклейн хүчлийн илрүүлэгч) нэгээр нэрлэгдэх нуклейн хүчлийн фрагментийг хэрэглэдэг. Генетик анализатор нь удамшлын өвчин (ж.нь., цистик фиброз, гемофили), эсвэл генетикийн өөрчлөлт (ж.нь, непласм), хромосомын эмгэг (ж.нь, Down syndrome) болон нэг нуклеотидын полиморфизмыг илрүүлэхэд хэрэглэгддэг. Зарим нь хүний лейкоцитын антигенийг бичиж, шилжүүлэн суулгахаас өмнөх шинжилгээ, шүүх болон эцэг, эх тогтоох шинжилгээнд ашигладаг.



ANALYZERS, LABORATORY, CLINICAL
CHEMISTRY/IMMUNOASSAY

АНАЛИЗАТОР, ЛАБОРАТОРИЙН,
КЛИНИКИЙН ХИМИ/ДАРХЛАА СУДЛАЛ

UMDNS CODE 20821

Laboratory analyzers designed to perform tests using clinical chemistry or immunoassay techniques. These analyzers can examine samples of either compounds or mixtures to determine the nature or the proportion of their constituents and/or separate them in their constituent substances by means of chemical reagents (e.g., clinical chemistry analysis) or identify and quantify specific substances using an antibody (e.g., immunoglobulin) as a reagent to detect the substance (e.g., antigen, hapten) of interest (i.e., immunoassay). Combined clinical chemistry/immunoassay analyzers are used mainly for determination of the concentration of metabolites, electrolytes, proteins, and drugs in body fluids (e.g., plasma, serum, urine, cerebrospinal fluid); they are also used for endocrine hormone testing and protein, viral, or bacterial toxin determinations.

Анализатор нь клиник биохимийн эсвэл дархлаа судлалын шинжилгээний техникийг ашиглан шинжилгээг хийж гүйцэтгэдэг төхөөрөмж юм. Эдгээр анализатор нь шинжилгээ (жишээ нь, дархлаа судлал)-ний сорьцыг бүртгэх урвалж (эсрэг төрөгч, hapten гэх мэт) болгон эсрэг бодис (жишээ нь, иммуноглобулин)-ыг ашиглан тусгай сорьцын тоо хэмжээг тогтоох болон тодорхойлох эсвэл биохимийн урвалжуудын (жишээ нь, клиникийн биохимийн шинжилгээ) тусламжтайгаар сорьцуудын бүрэлдэхүүн хэсгүүдийг ялгах буюу бүрэлдэхүүн хэсгүүдийн мөн чанар, хувь хэмжээг тодорхойлдог. Клиник биохими/ дархлаажуулалтын анализатор нь ихэвчлэн биеийн шингэн дэхь (жишээ нь: плазм, ийлдэс, шээс, тархи, нугасны шингэн) метаболит, электролит, уураг, эмийн агууламжийг тодорхойлоход ашиглагддаг. Мөн эдгээр нь дотоод

шүүрлийн дааврын шинжилгээ, уураг, вирус, эсвэл бактерийн хоруу чанарын тодорхойлолтонд ашиглагддаг.



OVENS, LABORATORY

ХАТААХ ЗУУХ, ЛАБОРАТОРИЙН

UMDNS CODE 21086

Ovens designed for clinical laboratory procedures (e.g., baking, drying, desiccating, sterilizing of glassware, instruments, cultures, or samples); they operate at temperatures typically from ambient to a maximum of between 200 and 325 degrees Celsius (392 to 620 degrees Fahrenheit) with the chamber temperature accuracy, resolution, and uniformity required in clinical laboratory work. These ovens usually consist of a thermal isolated chamber made of corrosion-proof materials and, frequently, a large glass window; they also include time-and-temperature sensors and controls (either manual or automated), temperature protection, and alarms. Laboratory ovens are available in many different capacities (typically from 27 to 135 cubic dm [1 to 5 cubic feet]) and configurations (e.g., tabletop, upright, undercounter). Dedicated laboratory ovens provide gravity and/or forced-air capabilities; some can provide a vacuum environment in the working chamber.

Хатаах зуух нь эмнэлзүйн лабораторийн шинжилгээнд (жишээ нь: жигнэх, хатаах, эврээх, шилэн сав, багаж хэрэгсэл, бактери өсгөвөр, дээжийг ариутгах гэх мэт) зориулагдсан төхөөрөмж; клиникийн лабораторийн шаардлагад нийцэх энэхүү төхөөрөмжийн температурын нарийвчлал, зохицуулалт нь орчны температурын хэмжээнээс эхлээд хамгийн их нь цельсийн 200-332 градусын (Фарангейтийн 392-620 градус) хооронд байна. Зэврэлтээс хамгаалагдсан материалаар хийгдсэн дулаан тусгаарлагч бүхий камер, доторх зүйл нь харагдах том шилэн цонхтой байдаг. Мөн хугацаа-температурын мэдрэгч ба удирдлага (гар эсвэл автоматаар), хэт өндөр температурын хамгаалалт болон дохиололыг багтаасан байдаг. Лабораторийн төхөөрөмж нь олон янзын багтаамж (ихэвчлэн 27-аас 135 метр куб [1-ээс 5 фут куб]) ба хийц загвартай (жишээ нь: ширээний дээр байрлуулах, босоогоор нь байрлуулах, тавцангийн доор байрлуулах) байдаг. Тусгай зориулалтын төхөөрөмж нь нягттай / эсвэл зохиомол агаарыг бий болгох, ажиллагааны камерийн дотор вакуум орчин бий болгох боломжтой байна.



OVENS, LABORATORY, VACUUM

ХАТААХ ЗУУХ, ЛАБОРАТОРИЙН, ВАКУУМ

UMDNS CODE 21088

Laboratory ovens designed to provide the relatively low-vacuum environment in the working chamber necessary in some laboratory procedures. They usually operate (frequently using a computer program) at temperatures ranging from ambient to a maximum of between 200 and 300 degrees Celsius (392 to 572 degrees Fahrenheit). These ovens usually consist of a thermal isolated chamber made of corrosion-proof materials and, frequently, thick walls and a glass window; opening and closing purge and vacuum valves and ports; time-and-temperature sensors and controls (either manual or automated); temperature protection, and alarms. Some vacuum ovens permit operation with an inert gas environment in the working chamber. Vacuum laboratory ovens are used mainly in procedures such as desiccating, moisture testing, annealing, and vacuum embedding. They are available in many different capacities (typically from 14 to 54 cubic dm/0.5 to 2 cubic feet) and configurations (e.g., tabletop, upright, undercounter).

Хатаах зуух нь зарим лабораторийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай ажиллах камерт харьцангуй бага вакуум орчинг бий болгох зориулалттай. Энэхүү хатаах зуухны температур нь орчны температурын хэмжээнээс эхлээд хамгийн их нь цельсийн 200-300 градусын (Фарангейтийн 392-572 градус) хооронд байна. Зэврэлтээс хамгаалагдсан материалаар хийгдсэн дулаан тусгаарлагч бүхий камер, доторх зүйл нь харагдах нимгэн шилэн цонхтой байдаг. Мөн цэвэрлэгээ, вакуумыг нээх хаах хавхлага, портууд, хугацаа-температурын мэдрэгч ба удирдлага (гар эсвэл автоматаар), хэт өндөр температурын хамгаалалт болон дохиололыг багтаасан байдаг. Зарим вакуум хатаах төхөөрөмж нь ажлын камер дахь инертийн хийн орчинд ажиллах боломжтой байдаг. Вакуум лабораторийн хатаах төхөөрөмжийг голдуу хатаах, чийгшлийн туршилт хийх, эврээх, вакуум орчинг бүрдүүлэх зэргээр хэрэглэдэг. Олон янзын багтаамж (ихэвчлэн 14-54 дм.куб / 0.5-аас 2 метр. куб) ба хийц загвартай (жишээ нь: ширээний дээр байрлуулах, босоогоор нь байрлуулах, тавцангийн доор байрлуулах) байдаг.



LAUNDRY PRESSES

УГААЛГЫН ИНДҮҮ

UMDNS CODE 21090

Equipment designed for automated pressing (i.e., ironing) and smoothing cloth and other fabrics. This equipment typically includes a set of moving bands intended to press the laundry, a heating system (e.g., steam, electrical), and controls to adjust the temperature and the band speed according with the material and the humidity content of the fabric. Laundry presses are available in many sizes and using several configurations.

Хувцас болон бусад зөөлөн эдлэлийг толийлгож автоматаар дарах (индүүдэх) загвар бүхий төхөөрөмж юм. Энэхүү төхөөрөмж хөдөлгөөнтэй даралтат гартай бөгөөд угаалгын зүйлийг дарах, халаах системтэй мөн хэмийг тохируулах болон гарны хурдыг тохируулах (индүүдэж буй материалын болон чийгшлийн хувьд тохируулан) систем бүхий тоног төхөөрөмж юм. Олон төрлийн хэмжээтэй байдаг бөгөөд угсралтын шийдэл нь ч хэд хэдэн янз байдаг.



WASHER/DECONTAMINATION UNITS,
SURGICAL INSTRUMENT

УГААГЧ/ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭГЧ
ТӨХӨӨРӨМЖ, МЭС ЗАСЛЫН БАГАЖ

UMDNS CODE 21171

Washer/decontamination units designed for automatic or semiautomatic washing (i.e., eliminating dirt and/or stains) and physical removal (i.e., physical decontamination) of organic debris such as blood, fat, bone from surgical instruments, reusable respiratory devices (e.g., anesthesia sets), and other critical devices. These units typically consist of a corrosion-resistant chamber containing baskets or trays for the soiled instruments; some can accommodate instrument trays and/or dedicated racks. The equipment performs a cycle of operations typically including water prewash, enzyme treatment, detergent wash, heated rinse, and drying; the process includes mechanical removal of contaminants by water jets and/or ultrasound energy and may include thermal disinfection (usually using water from 60 to 95 degrees Celsius [140 to 203 degrees Fahrenheit]). Surgical instrument washer/decontamination units are frequently used as an adjunct to manual cleaning of surgical instruments before sterilization; they provide some level of disinfection by killing or inactivating several types of microorganisms. They are available in stand-alone and wall-recessed configurations, typically for use in central supplies departments of healthcare facilities.

Угаагч/Халдваргүйжүүлэгч нь мэс заслын багаж хэрэгсэлээс цус, өөх тос, яс зэрэг органик бохирдлуудыг арилгах (жишээ нь материалын ариутгал) болон угаах (жишээ нь бохирдол болон толбыг арилгах) зориулалттай автомат болон хагас автомат угаагч/халдваргүйжүүлэгч төхөөрөмж. Ихэвчлэн бохирдсон багажийг хийх сагс эсвэл тавиуртай зэврэлтэд тэсвэртэй камертай байдаг. Зарим нь багажийн тавиур болон тусгай зориулалтын тавцанг угсарч суурилүүлсан байдаг. Энэхүү Угаагч/Халдваргүйжүүлэгч нь урьдчилан усаар угаах, фермент эмчилгээ, угаалгын нунтаг, халуунаар зайлах, хатаах гэх мэт үйл ажиллагааны дараалалтай. Мөн усаар зайлах, хэт авиан энергийг ашиглан халдварыг арилгах механик аргууд багтдаг, халуунаар халдваргүйжүүлэх (ихэвчлэн цельсийн 60-95 градус (Фаренгейтийн 140-203 градус) үйл ажиллагаа мөн орно. Мэс заслын багаж хэрэгсэл угаагч/халдваргүйжүүлэх төхөөрөмж нь тогтмол ашиглагддаг бөгөөд ариутгалын өмнө мэс заслын багажуудыг гараар сайтар цэвэрлэсэн байхыг шаарддаг. Тэдгээр нь хэд хэдэн төрлийн бичил организмын устгал, халдваргүйжүүлэлт, идэвхгүйжүүлэлтийг зарим түвшинд хийж гүйцэтгэдэг. Тэдгээр нь босоо шүүгээ болон хананд бэхлэгдэх загваруудтай байх ба эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг томоохон төвүүдэд ашиглах зориулалттай.



WASHER/STERILIZING UNITS, SURGI-
CAL INSTRUMENT

УГААГЧ/АРИУТГАГЧ ТӨХӨӨРӨМЖ,
МЭС ЗАСЛЫН БАГАЖ

UMDNS CODE 21179

Washer/sterilizing units designed for automatic or semiautomatic washing (i.e., eliminating dirt and/or stains), removal of organic debris (e.g., blood, fat, bone), and killing all microorganisms including spore-forming bacteria (unless they are present in very high numbers), providing a high level of disinfection that is nearly sterile for surgical instruments and other critical utensils. These units typically consist of one or two corrosion-resistant chambers containing baskets or trays for the soiled instruments; some can accommodate instrument trays and/or racks. Surgical instrument washers/sterilizing units perform a cycle of operations typically including water prewash, enzyme treatment, detergent wash, heated rinse, steam sterilization (usually using steam from 121 to 140 degrees Celsius [250 to 284 degrees Fahrenheit]), and drying; the process usually includes mechanical removal of contaminants by water jets or previous manual scrubbing. Washer/sterilization units are used in the central supply area of a health-care facility; their function is frequently replaced by the combined use of a washer/decontamination unit and a dedicated sterilizing unit.

Угаагч/ариутгагч нь мэс заслын багаж хэрэгсэл, эрсдэлтэй хэрэглэлд өндөр түвшний халдваргүйжилт хийх /ариутгалтай ойролцоо/, цус, өөх тос, яс зэрэг органик бохирдлуудыг арилгах, угаах (жишээ нь бохирдол болон толбыг арилгах), бүх бичил организмыг арилгах, бактери /маш их тоо хэмжээтэйгээс бусад/ устгах зориулалттай автомат болон хагас автомат төхөөрөмжүүд юм. Эдгээр төхөөрөмж нь ихэвчлэн бохирдсон багажийг хийх сагс эсвэл тавиуртай зэврэлтэд тэсвэртэй нэг эсвэл хоёр камертай байдаг. Зарим нь багажийн тавиур болон тусгай зориулалтын тавцанг угсарч суурилуулсан байдаг. Мэс заслын багажны угаагч/ариутгагч нь урьдчилан усаар угаах, фермент эмчилгээ, угаалгын нунтаг, халуунаар зайлах, уураар ариутгах (ихэвчлэн цельсийн 121-140 градус (Фаренгейтийн 250-284 градус) хатаах гэх үйл ажиллагааны дараалалтай. Мөн гараар сойздох болон усаар зайлж бохирдлыг механикаар арилгах үйл ажиллагааг багтаадаг. Энэхүү ариутгагч нь эмнэлгийн төв хэсэг, төв ариутгалын тасагт хэрэглэгддэг бөгөөд үйл ажиллагаа нь угаах/халдваргүйжүүлэх төхөөрөмжтэй хамтран ашиглана.



FREEZERS, BLOOD BANK

ХӨЛДӨӨГЧ, ЦУСНЫ БАНК

UMDNS CODE 22036

Freezers designed to store blood bank products and samples, such as plasma and red blood cells. These freezers are usually made with a corrosion-resistant (typically stainless steel) interior, minimizing the risk of adulteration, contamination, and/or corrosion of contents and internal shelving appropriate for storage and easy location of blood bank products (e.g., blood bags). Blood bank freezers include automatic defrost capability, keeping the temperature in freezing chambers within preestablished limits during the process; they also include sensors, controls, monitors, chart recorders, and alarms for dependable long-term storage according to blood storage standards. Typically, blood bank freezers are available in three different temperature ranges: standard, from 0 to -20 or -30 degrees Celsius (32 to -4 or -22 degrees Fahrenheit); ultralow, from -40 to -90 degrees Celsius (-40 to -130 degrees Fahrenheit); and cryogenic, from -130 degrees Celsius (-192 degrees Fahrenheit) or lower. Programmed (e.g., linear rate) or manual control of the freezing rate is possible in most blood bank freezers. A wide variety of capacities and freezer configurations, including upright, undercounter, and walk-in models, are available.

Хөлдөөгч нь плазма, цусны улаан эс зэрэг цусны бүтээгдэхүүн, дээжүүдийг хадгалах зориулалттай. Дотор талыг ихэвчлэн зэврэхээс хамгаалсан (ерөнхийдөө зэвэрдэггүй ган), урвалд орохгүй, амархан бохирдохгүй, идэмхий бус материалаар хийдэг ба цусны банк (жишээ нь: цустай уутууд)-ыг хялбархан байршуулах, хадгалах тавиуруудтай байдаг. Автоматаар цанталтыг арилгах, тохируулсан хязгаарт температурыг барих функцтэй бөгөөд мэдрэгч, удирдлага, монитор, графикан бичлэг ба дохиолол зэрэг хэр хугацаанд хадгалахаас хамаарах бүрдэл хэсгүүдтэй байна. Хөлдөөгч нь ерөнхийдөө 3 төрлийн температурын хүрээнд ажилладаг: стандарт буюу 0-(-200C) эсвэл (-300C), хэт бага буюу (-400C)-(-900C), бага хэмийн буюу (-1300C) ба түүнээс бага. Ихэнх цусны хөлдөөгчний хөлдөөх хэмжээг програмаар эсвэл гараар тохируулах боломжтой. Босоо, тасалгаатай, тавиур доор байрладаг зэрэг олон төрлийн багтаамж, хэлбэр хэмжээтэй байна.



FREEZERS, BLOOD BANK, ULTRALOW
TEMPERATURE

ХӨЛДӨӨГЧ, ЦУСНЫ БАНК, ХЭТ БАГА
ТЕМПЕРАТУР

UMDNS CODE 22039

Blood bank freezers designed for long-term storage of blood bank products and samples at temperatures below -65 degrees Celsius (-82 degrees Fahrenheit); the freezer temperature is frequently set at values lower than minimum requirements, typically between -80 and -100 degrees Celsius (-112 and -148 degrees Fahrenheit). These freezers are typically made with a corrosion-resistant (typically stainless steel) interior, minimizing the risk of adulteration, contamination, and/or corrosion of contents; they usually provide linear and/or controlled rate capabilities for a controlled rate of freezing, minimizing the effects of sudden cooling on the red blood cells (RBCs). Blood bank ultralow temperature freezers include automatic defrost capability, keeping the temperature in all the freezing chambers within preestablished limits; they also include sensors, controls, monitors, chart recorders, and alarms for dependable long-term storage following the requirements of blood storage standards. The freezers are available in several sizes and configurations (e.g., upright, chest) with internal shelving appropriate for blood bags. Programmed (e.g., linear rate) or manual control of the freezing rate is possible in most ultralow temperature blood bank freezers. Ultralow temperature blood bank freezers permit the storage of blood bank products for extended periods (typically several years); they are frequently used for preservation of products such as RBCs with cryoprotective agents such as glycerol at 40% or dimethyl sulfoxide and for long-term preservation of plasma.

Хөлдөөгч нь цус цусан бүтээгдэхүүний дээжийг -65 градусаас доош цельсийн температурт (-82 градус Фаренгейт) температурт урт хугацаанд хадгалахад зориулагдсан; хөлдөөх температурыг заагдсан шаардлагын хамгийн бага температураас бага, ихэвчлэн -80 -100 цельсийн градус (-112 ба -148 градус Фаренгейт) -ээс бага байхаар тохируулдаг. Эдгээр хөлдөөгч нь зэврэлтэд тэсвэртэй (ихэвчлэн зэвэрдэггүй ган), хольцыг муутгах, бохирдуулах, зэврэлтийн эрсдлийг багасгах дотортой; цусны улаан эсийг гэнэт хэт хөлдөхөөс сэргийлэх шугаман болон эргэлтийн хяналтын системтэй. Цусан бүтээгдэхүүнийг хэт бага температурт хөлдөөх хөлдөөгч нь бүх тасалгаанд урьдчилан тохируулсан температурт барьж байх автомат төхөөрөмжтэй. Мөн мэдрэгч, удирдлага, дэлгэц, бүртгэлийн систем, цусыг стандартын дагуу удаан хугацаанд хадгалахад зориулсан дохиоллын системтэй. Хөлдөөгч нь хэд хэдэн хэмжээ, төрөлтэй байдаг (жижиг, том оврын гэх мэт). Цусан бүтээгдэхүүнийг хадгалах тусгайлан зориулагдсан дотоод зохион байгуулалттай тавиуртай, хэт бага температурын цусны банкны хөлдөөгч нь хөлдөөх явцыг хянах гар ажиллагаатай болон програмчлагдсан хяналттай байдаг. Цусан бүтээгдэхүүнийг удаан хугацаанд хадгалах зориулалттай, эдгээр нь глицерин, 40% -ийн демитилийн сульфоксид, хөлдөхөөс сэргийлсэн хольц бүхий цусны улаан эсийг удаан хугацаагаар хадгалахад зориулагдсан байдаг.



FREEZERS, BLOOD BANK, CRYOGENIC

ХӨЛДӨӨГЧ, ЦУСНЫ БАНК, КРИОГЕН

UMDNS CODE 22045

Freezers designed to store blood bank products and samples at temperatures below the point at which most or all biological activity ceases (sometimes defined as the glass transition temperature of water) about -130 degrees Celsius (-202 degrees Fahrenheit). These freezers typically use liquid nitrogen as the cooling agent; some specially designed electromechanical systems are also capable of cooling at these temperatures. Products may be stored either directly in liquid nitrogen, which provides a temperature of -180 degrees Celsius (-292 degrees Fahrenheit) or colder with minimal temperature fluctuations; or they may be stored at the vapor phase above liquid nitrogen at a temperature of about -140 degrees Celsius (-220 degrees Fahrenheit). Storage in the vapor phase decreases the risk of cross-contamination between stored products. Red blood cells (RBCs) preserved with a low concentration of a cryoprotective agent such as glycerol at 20 percent or dimethyl sulfoxide may be stored for long periods, typically up to 10 years. Cryogenic blood bank freezers are used mainly to store rare types of RBCs.

Хөлдөөгч нь цусан бүтээгдэхүүн болон цусны банкны дээжийг биологийн идэвхи бүрэн зогсохоос доогуур температурт (заримдаа усны шилэн шилжилт гэдэг), -130 цельсийн хэм (-202 хэмийн Фаренгейт)-д хадгалах зориулалттай хөргөгч юм. Энэ төхөөрөмж нь хөргөх бодист шингэн нитрогенийг ашигладаг ба зарим төхөөрөмжүүд нь цахилгаан механик хөргөлтийн системийг ашиглан энэ температурт хөргөдөг. Хадгалах бүтээгдэхүүнүүд нь нэг бол шингэн нитрогенийг ашигласан -180 цельсийн хэм (-292 Фаренгейтийн хэм) хөргүүрт эсвэл бага зэргийн хэлбэлзэлтэй температурт, эсвэл шингэн азотын уурын фазаас доогуур ойролцоогоор -140 цельсийн хэм (-220 Фаренгейтийн хэм) хадгалагдаж болно. Фазын ууранд хадгалах нь тухайн бүтээгдэхүүнийг бохирдох, муудах эрсдлээс сэргийлдэг. Цусан дахь улаан эс (RBCs) хөлдөлтөөс хамгаалах хольц агуулсан, диметил сульфид эсвэл 20 хувь глицерол агуулсан концентрацтай бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар хадгалагдаж болно, бараг 10 хүртэл жил хадгалагдана. Криоген хөлдөөгчтэй цусны банкны хөлдөөгч нь ховор төрлийн улаан эсийг хадгалахад ашиглагддаг.



FREEZERS, LABORATORY, ULTRALOW
TEMPERATURE

ХӨЛДӨӨГЧ, ЛАБОРАТОРИЙН, ХЭТ
БАГА ТЕМПЕРАТУР

UMDNS CODE 22065

Freezers designed to store laboratory products and samples, such as in vitro diagnosis reagents and laboratory tissue and body fluid samples that require very low temperatures, usually from -40 to -90 degrees Celsius (-40 to -130 degrees Fahrenheit). These freezers are usually made with a corrosion-resistant (typically stainless steel) interior, minimizing the risk of adulteration, contamination, and/or corrosion of contents; the internal shelving is appropriate for storage and easy location of laboratory products and samples. Multiuse laboratory freezers include automatic defrost capability, maintaining the temperature in the entire freezing chamber within preestablished limits during the process; they also include sensors, controls, monitors, and alarms for dependable long-term storage following laboratory storage standards. Programmed (e.g., linear rate) or manual control of the freezing rate is possible in most laboratory freezers. A wide variety of ultralow temperature freezer capacities and configurations, including upright and chest models, is available.

Хөлдөөгч нь хэт бага температурын хөргөгч нь маш бага температурт, тухайлбал цельсийн -40-с 90 градуст (Фаренгейтийн -40-с -130 градус) хадгалах шаардлагатай инвитро оношилгооны урвалжууд болон биеийн шингэн дээж, лабораторийн эд эс зэрэг лабораторийн бүтээгдэхүүн, дээжийг хадгалах зориулалттай. Сорьцын чанар муудах эрсдлийг багасгах, бохирдол эсвэл зэврэлтээс хамгаалахын тулд хөргөгчүүдийн дотор талыг зэврэлтэд тэсвэртэй (ихэвчлэн зэвэрдэггүй ган) материалаар хийдэг ба лабораторийн бүтээгдэхүүн, дээжийг байрлуулах зориулалтын тавцангуудтай байдаг. Олон функцтай лабораторийн хөргөгч нь автоматаар цанталтыг арилгах, ашиглалтын явцад урьдчилан тогтоосон хязгааруудын хооронд хөргөгчийн камер доторхи температурыг зохицуулах чадвартай байна. Түүнчлэн лабораторийн хадгалалтын стандартын дагуу удаан хугацааны найдвартай хадгалалтыг хангах зорилгоор мэдрэгч, хяналтын хэсгүүд, хяналтын дэлгэц болон дохиоллуудтай байдаг. Ихэнх лабораторийн хөргөгчийн хөргөх температурыг гараар эсвэл програмаар (ө.х шууд хэмжээс) удирддаг. Хэт бага температурт хөргөгч нь багтаамж болон тохируулгуудын хувьд маш олон төрөл байх бөгөөд босоо болон хайрцаг хэлбэрийн загваруудтай байдаг.



FREEZERS, LABORATORY, CRYOGENIC

ХӨЛДӨӨГЧ, ЛАБОРАТОРИЙН,
КРИОГЕН

UMDNS CODE 22070

Laboratory freezers designed for tissue-sample storage (e.g., ovum, embryo) at temperatures below the point at which most or all biological activity ceases (sometimes defined as the glass transition temperature of water), about -130 degrees Celsius (-202 degrees Fahrenheit). These freezers typically use liquid nitrogen as the cooling agent; some specially designed electromechanical systems are also capable of cooling at these temperatures. The products may be stored directly in liquid nitrogen, which provides a temperature of -180 degrees Celsius (-292 degrees Fahrenheit) or colder with minimal temperature fluctuations; or they may be stored in the vapor phase above the liquid nitrogen at a temperature of about -140 degrees Celsius (-220 degrees Fahrenheit). Storage in the vapor phase decreases the risk of cross-contamination among the stored products. Tissue (e.g., ovum, embryo, bone, cornea) may be stored for extended periods, typically several years.

Хөлдөөгч нь ихэнхдээ эдийн сорьц (жишээ нь, өндгөвч, үр хөврөл) бүх биологийн үйл ажиллагаа зогсох цэгээс доогуур температурт хадгалахад зориулагдсан (заримдаа усан шилний шилжилтийн температур гэж тодорхойлсон) ойролцоогоор -130 градус (-202 градус Фаренгейт). Эдгээр хөргүүр нь ихэвчлэн шингэн азотыг хөргөх бодис болгон ашигладаг; Зарим тусгайлан боловсруулсан цахилгаан механик систем нь эдгээр температурт хөргөх чадвартай байдаг. Бүтээгдэхүүнийг шүүд -180 цельсийн градусын температур (-292 градус Фаренгейт), эсвэл илүү бага температурын хэлбэлзэлтэй хүйтэн нөхцөлд шингэн азотоор шүүд хадгалж болно; эсвэл тэдгээрийг -140 градусын цельсийн температурт (-220 градус Фаренгейт) температурт шингэн азотоор хөргөн хадгалж болно. Уурын фазад хадгалах нь хадгалагдсан бүтээгдэхүүний бохирдох эрсдлийг бууруулдаг. Эд (жишээ нь, өндгөвч, үр хөврөл, яс, эвэрлэг бүрхэвч) -ийг удаан хугацаагаар, хэдэн жил ч хадгалж болно.



FREEZERS, PHARMACY

UMDNS CODE 22075

Freezers designed to store drugs and other pharmaceutical products typically at temperatures from 0 to -20 or -30 degrees Celsius (32 to -4 or -22 degrees Fahrenheit). These freezers are usually made with a corrosion-resistant (typically stainless steel) interior, minimizing the risk of adulteration, contamination, and/or corrosion of contents; the internal shelving is of a size and configuration appropriate for storage and easy location of pharmaceutical product containers. Pharmacy freezers frequently include automatic defrost capability and sensors, controls, monitors, recorders, and alarms for dependable long-term storage. Pharmacy freezers are available in a variety of sizes, capacities, and configurations, including upright, undercounter, and walk-in models.

ХӨЛДӨӨГЧ, ЭМИЙН САНГИЙН

Хөлдөөгч нь эм болон эмийн төрлийн бусад бүтээгдэхүүнийг 0 -с -20, эсвэл -30 цельсийн температурт (32-4 эсвэл -22 градус Фаренгейт) температурт хадгалах зориулалттай. Эдгээр хөлдөөгч нь зэврэлтэд тэсвэртэй (ихэвчлэн зэвэрдэггүй ган) материалаар доторлуулсан бөгөөд хольцын бохирдлыг багасгах, зэврэлтийн эрсдлийг бууруулдаг; Дотор тавиур нь эмийг байрлуулахад хялбар, хадгалахад тохиромжтой хэмжээтэй, Эмийн хөлдөөгч нь цанг автоматаар хайлуулагчтай болон мэдрэгтэй, удирдлага, дэлгэц, удаан хугацааны хадгалалтад зориулсан дохиолол болон хэвлэх хэсгүүдтэй. Эмийн сангийн хөлдөөгч нь янз бүрийн хэмжээ, багтаамж, хүчин чадалтай байхаас гадна босоо, хэвтээ, дотор нь орж болох гэх мэт загваруудтай байна.



FREEZERS, POSTMORTEM

UMDNS CODE 22079

Freezers designed to store tissue and, less frequently, organs excised from cadavers during autopsy procedures at temperatures typically from 0 to -20 degrees Celsius (32 to -4 degrees Fahrenheit). These freezers are usually made with a corrosion-resistant (typically stainless steel) interior, minimizing the risk of adulteration, contamination, and/or corrosion of contents; the internal shelving is appropriate for storage and easy location of the tissue and/or or-

ХӨЛДӨӨГЧ, ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ

Хөлдөөгч нь хүний биеийн эд, зарим тохиолдолд цогцосноос задлан шинжилгээгээр авсан эд эрхтэнг 0/-20/ цельсийн хэмд /32/-4/ F/ хадгалах зориулалттай хөлдөөгч юм.Эдгээр хөлдөөгчүүд нь зэврэлт эсэргүүцэх материалаар дотоод хэсгийг хийж, халдварын эрсдэлийг багасгасан иж бүрдлүүдтэй байна. Дотоод тавиурууд нь хадгалалтанд тохиромжтой байж, эд болон эрхтэнг хялбар хадгалах боломжтой байна. Хөлдөөгчийг ихэвчлэн босоо, эгц шулуун хэлбэртэйгээр

gan containers; they are typically manufactured in a stand-alone, upright configuration, but some smaller units are available in an undercounter configuration. Postmortem freezers include automatic defrost capability, maintaining the temperature in the entire freezing chamber within preestablished limits during the process; they also include sensors, controls, monitors, and alarms for dependable long-term storage following laboratory storage standards. Freezers frequently meet security standards to keep forensic evidence valid for extended periods. They are used in autopsy rooms and in medical examiners' offices.

үйлдвэрлэдэг ч зарим жижиг хэсгүүдийг хэвтээ байрлалаар хийдэг. Хөлдөөгчийг автоматаар гэсгээх боломжтой байхаас гадна дотоод тасалгааны температурыг тохируулах горимтой байна. Үүнээс гадна хөлдөөгч нь мэдрэгч, удирдах хэсэг, дэлгэц, лабораторийн удаан хугацааны хадгалалтын стандартад нийцсэн дохиололтой байна. Хөлдөөгч нь шүүх эмнэлгийн нотолгоог ямар ч үед хэвээр хадгалах аюулгүй байдлын стандартад нийцсэн байна. Хөлдөөгчийг задлан шинжилгээний өрөө болон эмгэг судлаачийн өрөөнд ашиглана.



DERMATOMES, MANUAL

ДЕРМАТОМ, ГАР АЖИЛЛАГААТАЙ

UMDNS CODE 22122

Dermatomes designed to harvest large, uniform-thickness skin grafts using manual (mechanical) procedures. These dermatomes are manually operated, handheld frames with an attached cutting blade or, more frequently, a drum with an oscillating blade that is manually operated as the drum rolls over the skin. Several models of manual dermatomes are available, including Reese and Padgett-Hood drum dermatomes. Manual dermatomes are used mainly to obtain skin grafts from donor sites, but they are sometimes used in other procedures (e.g., to remove tattoos).

Дерматом нь гар аргаар (механик) арьсыг нөхөн суулгахад хэрэгтэй жигд зузаантай, том арьсыг салгаж авах зориулалттай төхөөрөмж юм. Эдгээр дерматом гараар ажилладаг, угсрагддаг зүсэх ирийг бэхэлсэн хүрээтэй мөн олон давтамжтайгаар эргэлддэг иртэй хүрдтэй. Гар дерматомын хэдэн загвар байдаг бөгөөд үүнд Реезе болон Паджетт-Хоод хүрдтэй дерматом багтдаг. Гар дерматом нь ихэвчлэн арьсны нөхөн суулгалтанд ашиглах арьсыг донор болох хэсгээс гарган авахад ашигладаг боловч зарим тохиолдолд бусад эмчилгээнд ашиглагддаг (жишээ нь, шивээсийг арилгах).



DERMATOMES, ELECTRIC

ДЕРМАТОМ, ЦАХИЛГААН

UMDNS CODE 22123

Dermatomes designed to harvest large, uniform-thickness skin grafts using electric power. These dermatomes are typically handheld instruments that include an electric powered rapidly oscillating cutting blade that is manually advanced over the skin. Several dedicated electric dermatomes using this operating principle are available (e.g., Castroviejo, Reese, Padgett-Hood, Brown, Davol-Simon, Zimmer). Electric dermatomes are mainly used to obtain skin grafts from donor sites, but are sometimes used in other procedures (e.g., to remove tattoos).



Дерматом нь цахилгаан ашиглан арьсыг нөхөн суулгахад хэрэгтэй жигд зузаантай, том арьсыг салгаж авах зориулалттай төхөөрөмж юм. Арьсны дерматом нь ихэвчлэн гараар барьж ажиллуулах төхөөрөмж бөгөөд арьсан дээгүүр гараар удирдаж цахилгаанаар маш хурдан эргэлдэж зүсэх ирийг агуулдаг. Энэхүү үйл ажиллагааны зарчмыг ашигладаг тусгай зориулалтын хэд хэдэн цахилгаан дерматомууд (жишээ нь, Кастровиежо, Зеезе, Reese, Паджетт-Хоод, Браун Давол-Симон, Зиммер) байдаг. Цахилгаан дерматом нь ихэвчлэн арьсны нөхөн суулгалтанд ашиглах арьсыг донор болох хэсгээс гарган авахад ашигладаг боловч зарим тохиолдолд бусад эмчилгээнд ашиглагддаг (жишээ нь, шивээсийг арилгах).

CENTRIFUGAL BLOOD CELL PROCESSORS

ЦЕНТРИФУГ, ЦУСНЫ ЭСИЙГ ЦЕНТРИФУГДЭХ ҮЙЛ ЯВЦУУД

UMDNS CODE 23082

Devices designed to separate blood into plasma and cell components by centrifugation. These devices typically consist of a dedicated portable centrifuge with electronic controls, a display, a separation chamber, and appropriate tubing. Donor blood is mixed with an anticoagulant and centrifuged to separate plasma from other blood components such as red blood cells, white blood cells, and platelets. Centrifugal blood cell processors are used in blood banks and clinical laboratories to obtain isolated blood components.

Центрифуг нь төвөөс зугатаах хүчний аргаар цусан дахь сийвэн болон эсийн бүрэлдэхүүн хэсгүүдийг ялгах зориулалттай тоног төхөөрөмж юм. Эдгээр төхөөрөмж нь электрон удирдлага, дэлгэц, тусгаарлах камер, тохиромжтой хоолой бүхий зөөврийн центрифуг зэргээс бүрддэг. Бүлэгнэлтийн эсрэг бодис хольсон донорын цусанд холих ба цусны улаан, цагаан эс, ялтас зэрэг цусны бусад бүрэлдэхүүн хэсгүүдээс цусны сийвэнг центрифугийн тусламжтайгаар ялган авдаг. Центрифугээр гарган авсан цусны эсийг боловсруулах нь цус цусан бүтээгдэхүүний хадгалалт болон эмнэлгийн лабораториудын

цусны бүрэлдэхүүнийг ялгах, тусгаарлах үйл ажиллагааг хангадаг.



APHERESIS UNITS, BLOOD DONOR

АФЕРЕЗИЙН АППАРАТ, ЦУСНЫ ДОНОР

UMDNS CODE 23134

Apheresis units primarily designed to automate the separation, collection, and reinfusion of blood components such as plasma, platelets, and leukocytes from a healthy blood donor. Typically, one or more components are separated and collected and the rest of the blood is automatically reinfused; with the use of automated methods, large quantities of specific components can be obtained from a single donor. Blood donor apheresis units usually consist of a disposable pheresis set (i.e., a tubing set that connects the patient to the apheresis unit), pumps (e.g., rotary peristaltic pumps), a centrifugation chamber, bowls, filters, clamps, controls (e.g., centrifuge and pump speed, volume of solution added), alarms, and bubble detectors. The blood products collected depend on the needs of the blood center and the weight, total blood volume, and hematocrit of the donor. Dedicated apheresis units are available to collect only plasma or platelets (i.e., perform only plasmapheresis or plateletpheresis, also called thrombocytophoresis).

Аферезийн аппарат нь эрүүл цусны донороос плазма, тромбоцит ба лейкоцит зэрэг цусны бүрэлдэхүүн хэсгүүдийг салгах, цуглуулах, эргэн тарих зориулалттай. Ерөнхийдөө их хэмжээний тодорхой бүрэлдэхүүнүүдийг нэг донороос автомат аргаар авч нэг болон түүнээс олон бүрэлдэхүүн хэсгүүдэд салгах, цуглуулах ба цусны үлдэгдлийг автоматаар эргэн тарихдаг. Цусны донорын аферезийн аппарат нь ихэвчлэн нэг удаагийн аферезийн иж бүрдэл(өвчтөнийг аферезийн аппараттай холбох гуурсны иж бүрдэл), шахуурга(эргэдэг перисталтик шахуурга), хурилдуулах хэсэг, аяга, фильтр, хавчаар, удирдлага(жишээ нь: центрифуг ба шахуурганы хурд, нэмсэн шингэний эзлэхүүн), дохиолол, хий мэдрэгч зэргээс бүрдэнэ. Цусны бүтээгдэхүүнийг цусны төвийн хэрэгцээ болон донорын гематокрит, нийт цусны эзлэхүүн, жин зэргээс хамааран цуглуулна.Тусгай зориулалтын аферезын аппарат нь зөвхөн плазм ба тромбоцитыг цуглуулах боломжтой. (жишээ нь, зөвхөн плазмаферез гүйцэтгэх эсвэл плателетферез, тромбоцит гэж нэрлэдэг).



APHERESIS UNITS, BLOOD DONOR,
PLATELET

АФЕРЕЗИЙН АППАРАТ, ЦУСНЫ
ДОНОР, ЯЛТСАН ЭС

UMDNS CODE 23135

Apheresis units designed to automate the separation and collection from and reinfusion of platelets to a healthy blood donor (i.e. perform plateletpheresis). Typically, platelets are collected and the rest of the blood is automatically reinfused; with the use of automated methods, large quantities of platelets can be obtained from a single donor. Blood donor platelet apheresis units usually consist of a disposable pheresis set (i.e., a tubing set that connects the patient to the apheresis unit), pumps (e.g., rotary peristaltic pumps), a centrifugation chamber, bowls, filters, clamps, controls (e.g., centrifuge and pump speed, volume of solution added), alarms, and bubble detectors.

Аферезийн аппарат нь эрүүл цусны донороос ялтсан эсийг ялгах болон цуглуулах үйл ажиллагааг автоматаар хийж гүйцэтгэдэг (ө.х цусны ялтсан эс ялгах). Ерөнхийдөө, ялтсан эсүүдийг цуглуулах болон үлдэгдэл цусыг автоматаар дахин хэрэглээнд оруулдаг. Автоматжуулсан аргуудыг хэрэглэснээр нэг донороос их хэмжээний ялтсан эсийг гарган авах боломжтой болдог. Цусны донороос ялтсан эс ялгах төхөөрөмжүүд нь ихэвчлэн нэг удаагийн ферезийн иж бүрдэл (ө.х өвчтөнийг аферезийн төхөөрөмж рүү холбох иж бүрдэл), шахуурга (ө.х перисталтик шахуурга), центрифугийн хэсэг, тосгуур аяга, шүүлтүүр, хавчаар, хяналтын хэсэг (центрифуг болон шахуургын хурд, нэмсэн уусмалын эзлэхүүнийг хянах), дохиолол, болон хөөс илрүүлэгч гэсэн хэсгүүдээс бүрддэг.



APHERESIS UNITS, BLOOD DONOR,
PLASMA

АФЕРЕЗИЙН АППАРАТ, ЦУСНЫ
ДОНОР, СИЙВЭН

UMDNS CODE 23136

Apheresis units primarily designed to automate the separation and collection of plasma from a healthy blood donor (i.e., perform plasmapheresis). Typically, plasma is collected and the rest of the blood is automatically reinfused; with the use of automated methods, large quantities of plasma can be obtained from a single donor. Blood donor plasmapheresis units usually consist of a disposable pheresis set (i.e., a tubing set that connects the patient to the apheresis unit), pumps (e.g., rotary peristaltic pumps), a centrifugation chamber, bowls, filters, clamps, controls (e.g., centrifuge and pump speed, volume of solution added), alarms, and bubble detectors. Blood donor plasmapheresis units may be used also for plasma exchange in some therapeutic procedures.



Аферезе аппарат нь эрүүл цусны донороос авсан цусны сийвэнг цуглуулах болон ялгах үйл ажиллагааг автоматаар хийж гүйцэтгэх зориулалттай(ө.х,цуснысийвэнгялгах).Ерөнхийдөө цусны сийвэнг цуглуулах ба цусны үлдсэн хэсэг нь автоматаар эргэлддэг. Автоматжуулсан аргуудыг хэрэглэснээр нэг донороос их хэмжээний плазмыг гарган авах боломжтой болдог. Цусны донорын плазмаферезийн аппарат нь ихэвчлэн нэг удаагийн пирезийн иж бүрдэл (ө.х өвчтөнийг Аферезе рүү холбох иж бүрдэл), шахуурга (ө.х перисталтик шахуурга), центрифугийн хэсэг, тосгуур аяганууд, шүүлтүүр, хавчаар, хяналтын хэсгүүд (центрифуг болон шахуургын хурд, нэмсэн уусмалын эзлэхүүнийг хянах), дохиолол, болон хөөс илрүүлэгч гэсэн хэсгүүдээс бүрддэг. Зарим эмчилгээний явцад цусны донорын плазмаферезийн аппаратыг плазм солилцоход зориулан хэрэглэж болно.

APHERESIS UNITS, THERAPEUTIC

АФЕРЕЗИЙН АППАРАТ,
ЭМЧИЛГЭЭНИЙ

UMDNS CODE 23137

Apheresis units primarily designed to automate the removal of a pathologic component or toxin from the blood of a patient and/or its exchange with a replacement fluid. Typically, one or more pathologic components (e.g., antibodies, sickle cells) and/or toxins are removed and the rest of the blood is automatically reinfused. These units usually consist of a disposable pheresis set (i.e., a tubing set that connects the patient to the apheresis unit); pumps (e.g., rotary peristaltic pumps); a centrifugation chamber; bowls; filters; clamps; controls (e.g., centrifuge and pump speed, volume of solution added); alarms; and bubble detectors. Some therapeutic apheresis units use special affinity columns which contain adsorbents. These adsorbents selectively remove a pathogenic substance by chemical or antigen-antibody reactions as the plasma is pumped through the column rather than centrifugation.

Аферезе аппарат нь өвчтөний цусан дахь хордлого болон эмгэгийн бүрэлдэхүүнийг арилгах үйл ажиллагааг автоматаар хийж гүйцэтгэнэ. Ерөнхийдөө нэг буюу хэд хэдэн эмгэг бүрэлдэхүүн (ө.х. эсрэг бие, хадуур хэлбэрийн эс) ба хордлогыг арилгаж, цусны үлдэгдэл хэсгийг автоматаар дахин эргэлдүүлдэг. Эдгээр аппарат нь ихэвчлэн нэг удаагийн аферезе иж бүрдэл (ж., өвчтөнг Аферезе аппарат руу холбосон иж бүрдэл); шахуурга (жишээ нь, перисталтик шахуурга); центрифугийн хэсэг; тосгуур аяга, шүүлтүүр; хавчаар; хяналтын хэсэг (ж.нь, центрифуг ба шахуургын хурд, нэмсэн уусмалын эзлэхүүнийг хянах); дохиолол; ба хөөс илрүүлэгч зэрэг хэсгүүдээс бүрдэнэ. Зарим эмчилгээний аферезе аппаратад шингээх агууламж бүхий тусгай нэг төрлийн хавтгай багана хэрэглэдэг. Эдгээр шингээгч нь химийн болон эсрэг төрөгч-эсрэг биеийн урвалаар эмгэг төрүүлэгч бодисыг сонгож, плазмийг центрифугтэхээс илүүтэйгээр баганаар дамжуулан шахдаг.



HEMODIALYSIS UNITS, HEPATIC

ГЕМОДИАЛИЗЫН АППАРАТ, ЭЛЭГНИЙ

UMDNS CODE 23427

Hepatic hemodialysis units designed for the partial external support of liver function by removing large amounts of water-soluble and albumin-bound substances. Typically, blood is removed via an extracorporeal circuit, passed through a dialyzer and membrane (e.g., polysulphone) that filters out water-soluble toxic substances (e.g., ammonia, bilirubin, creatinine, urea, fatty acids) and albumin-bound toxins, and returned to the patient. Hepatic hemodialysis machines are available to perform continuous hemodialysis or as intermittent machines used for short periods of time. These units are intended for the treatment of chronic and/or acute liver disease and dysfunction after liver transplantation; the devices usually provide temporary liver function support while the patient waits for recovery or as a bridge to transplantation.

Хепатик /Элэгний/ гемодиализын төхөөрөмж нь их хэмжээний усанд уусдаг болон альбумин агуулсан их хэмжээний бодисыг зайлуулах замаар элэгний үйл ажиллагааны хэсэгчилэн гадны дэмжлэг үзүүлэх зориулалттай юм. Ерөнхийдөө цусыг гадны нэмэлт эргэлтээр диализ ба мембранаар (жишээ нь, полисульфон) дамжин өнгөрүүлж, усанд уусдаг хорт бодис (тухайлбал, аммиак, билирубин, креатинин, мочевин, өөхний хүчлүүд), альбумин агуулсан хорт бодисыг шүүгээд буцаж өвчтөнд юүлэх зориулалттай. Хепатик /Элэгний/ гемодиализын төхөөрөмж нь тасралтгүй гемодиализ хийх эсвэл богино хугацаанд хэрэглэдэг завсрын төхөөрөмж байна. Эдгээр төхөөрөмж нь элэгний архаг болон цочмог өвчин эмгэг, элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах эмчилгээний зориулалттай; Элэгний төхөөрөмж нь өвчтөн биеийн байдал сэргэхийг хүлээх эсвэл эрхтэн шилжүүлэн суулгах хүртэл түр ашиглах, элэгний үйл ажиллагааг дэмждэг төхөөрөмж юм.



SHAKER/ORBITERS, LABORATORY

СЭГСРЭГЧ/ЭРГЭЛДҮҮЛЭГЧ,
ЛАБОРАТОРИЙН

UMDNS CODE 23430

Tabletop laboratory devices designed to combine shaking and/or orbital movement capabilities. These devices typically consist of an automated, electrically powered countertop unit that provides shaking or orbital (e.g., elliptical) movement to containers (e.g., flasks, funnels, test tubes) in several internal or external holders. Shakers/orbiters may also include controls for the frequency and/or the degree (intensity) of the movement. Laboratory shakers/orbiters are intended for use in many analytic procedures, including drug testing, water pollution analysis, and hemolysis. Dedicated tabletop shakers appropriate for operation in the humid and polluted environment inside fume hoods, incubators, and/or other laboratory devices are also available.

Сэгсрэх болон тойрог хөдөлгөөнийг хослуулсан, ширээн дээр байрлуулах лабораторийн төхөөрөмж. Энэ нь автомат, цахилгаанаар ажиллах тоологчтой энэ нь сэгсрэх эсвэл тойрог замаар хөдөлгөх зориулалттай (жишээ нь зууван эргэх) хэд хэдэн дотоод болон гадаад тогтоогчуудад бэхэлсэн хөдөлгөөнт контейнер (жишээ нь колбо, юлүүр, туршилтын хоолой) агуулна. Энэхүү төхөөрөмж нь хөдөлгөөний давтамж, эрчмийн удирдлагыг багтаасан байдаг. Лабораторийн сэгсрэгч/эргэлдүүлэгч нь аналитик шинжилгээ, усны бохирдлын шинжилгээ, гемолиз зэрэг олон аналитик процедурт ашиглах зориулалттай. Тусгай зориулалтын ширээн дээр байрлах сэгсрэгч нь утаатай бүрхүүл, инкубатор болон лабораторийн бусад төхөөрөмж доторх орчны чийгшил, бохирдсон орчинд ажиллах боломжтой юм.



ANALYZERS, LABORATORY, MULTI-
TECHNOLOGY


АНАЛИЗАТОР, ЛАБОРАТОРИЙН, ОЛОН
ТЕХНОЛОГИТ

UMDNS CODE 23465

Laboratory analyzers designed to perform tests using techniques such as immunoassay, molecular assay (e.g., DNA and RNA determinations), and clinical chemistry (e.g., enzymatic assays). These analyzers

Дархлаажуулалтын шинжилгээ, молекулын шинжилгээ (жишээ нь, ДНХ, РНХ тодорхойлох), клиник биохимийн (жишээ нь, ферментийн оношилгоо) зэрэг шинжилгээний аргуудыг ашиглан туршилтыг гүйцэтгэх лабораторийн анализаторыг хэлнэ. Эдгээр анализатор нь

include a multiwell (typically 96 wells) plate; measuring systems, frequently using flow-cytometry techniques; a laser radiation source used to identify each individual microsphere thus allowing multiple simultaneous assessments; an electronic processing unit; and a display. Multitechnology analyzers using microsphere techniques typically apply one of several combinations of fluorescent dyes (e.g., Texas Red) to each sphere for a unique spectral identification of the microsphere sets, facilitating many simultaneous assays using a single sample volume. The analyzers can perform simultaneous tests in the same well using small-volume samples; they are used in clinical laboratories and for pharmaceutical research.



олон дээжийн (ихэвчлэн 96 дээж орох сав) хавтантай; урсгал-цитометрийн аргыг ихэвчлэн хэрэглэдэг хэмжих систем; Олон тооны зэрэгцээ үнэлэлт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор нянгийн масс бүрийг тодорхойлоход ашигладаг лазерын цацрагийн эх үүсвэр; цахилгаан боловсруулалтын хэсэг; болон дэлгэцээс бүрддэг. Микромерын аргыг ашигладаг олон технологит анализатор нь ихэвчлэн нэг дээжний эзлэхүүнийг ашиглан их хэмжээний дээжинд хийх шинжилгээг хөнгөвчлөх зорилгоор микропроцессорын иж бүрдлийг өвөрмөц спектрийн илрүүлэлтийн аргыг тус бүрээр нь спектроскоптой (жишээ нь: Техасын Улаан) хослуулан хэрэглэдэг. Анализатор нь бага эзлэхүүнт дээжийг ашиглан ижил хэмжээний дээжийн саванд агуулагдах дээжинд нэгэн зэрэг шинжилгээг хийж гүйцэтгэнэ. Тэдгээрийг ихэвчлэн эмнэлзүйн лабораторт болон эмийн судалгаанд ашигладаг.

WAXERS, DENTAL LABORATORY

ЗАГВАР ХИЙХ ТӨХӨӨРӨМЖ, ШҮДНИЙ ЛАБОРАТОРИЙН

UMDNS CODE 23492

Equipment designed for use in dental laboratories/workshops for modeling of dental wax to shape and refine a 3-dimensional model created from dental wax impressions of the patient's teeth and gums. The electronic dental waxing unit consists of a handpiece, heating pin, and a set of (e.g., modeling, needle) tips and/or spatulas with hand controls and sometimes foot controls. Tooth veneers, crowns, bridges, and other dental restorations are duplicated from the wax model as shaped by the dental waxer.



Хиймэл шүдэн загварчлал хийх төхөөрөмж. Энэ төхөөрөмж шүдний лабораторт өвчтөний шүд, буйлнаас шүдний лаваар наалдуулан гаргасан хэвээр хэлбэр гаргаж загварчлах, боловсронгуй болгосон 3д хэмжээст загварыг гаргаж авахад ашиглана. Шүдний хэв гаргаж авах төхөөрөмж нь гарны хэсэг, халаагч зүү, гар /зарим нь хөл удирдлагатай) удирдлагатай хүсүүр болон тэгшлэгчийн иж бүрдэл (хэв гаргач, зүү гэх мэт) зэргээс бүрдсэн байдаг. Шүдний өнгөлгөө, титэм, гүүр, бусад шүдний засал чимэглэлийн загварыг энэхүү аппаратыг ашиглаж хэлбэр гаргасан лав загвараар хуулбарладаг.

ELECTROPALATOGRAPHS

ПАЛАТОМЕТР АППАРАТ/ ЭЛЕКТРОПАЛАТОГРАФС АППАРАТ

UMDNS CODE 23501

Recorders designed to measure and record the timing and location of tongue contact with the hard palate during normal speech (i.e., electropalatography, also known as palatometry). These recorders typically include an artificial palate that is molded to fit the roof of the mouth, electrical contacts located on the lingual surface of the artificial palate, connectors to link the artificial palate to a computerized unit, dedicated software to process the information, and a recorder of the tongue-palate contact patterns synchronized with acoustic recording of the speech. Electropalatographs are intended for research, clinical studies, and assessment of speech therapy.

Палатометр бичигч төхөөрөмж нь хэвийн ярианы (electropalatography буюу palatometry гэгддэг) үед тагнайд хэл хүрэх байршил болон хугацааг тэмдэглэж, хэмжих зориулалттай юм. Эдгээр бичигч төхөөрөмж нь амны хөндийд бэхэлдэг хиймэл тагнай, хиймэл тагнайн хэлний гадаргуу дээр байрласан цахилгаан холболт, компьютержсэн хэсэгт хиймэл тагнайг холбох холбогч, мэдээллийг боловсруулах зориулалтын програм хангамж болон ярианы акустик бичлэгтэй синхрончлох хэл-тагнайтай харилцах загварын бичигч төхөөрөмж зэргээс бүрдэнэ. Электропалатографс аппарат нь судалгаа, клиникийн туршилт, хэл ярианы эмчилгээний үнэлгээ хийхэд зориулагдсан.



HEIGHT MEASUREMENT INSTRUMENTS, PORTABLE, NEONATE/INFANT /

ӨНДӨР ХЭМЖИГЧ БАГАЖ, ЗӨӨВРИЙН, ХҮҮХЭД/НЯРАЙН/

UMDNS CODE 23520

Portable height/length measuring instruments designed only to measure the length of neonates and the length or height of infants. These instruments typically consist of a board that permits a comfortable positioning of the baby including a mechanism (e.g., a sliding lever that adjusts to the infant's body) to measure the length of the neonate or infant in a range of up to about one meter (40 inches) with accuracy and reproducibility; other instruments are also capable of measuring infants' height as soon as they can stand up. Some instruments include electronic displays and/or recorders. Portable neonate/infant height/length measuring instruments are intended for periodic assessment of postneonate growth and to perform studies of baby growth.

Өндөр хэмжигч нь зөвхөн шинэ төрсөн нярайн урт эсвэл нярай хүүхдийн өндрийг хэмжихэд ашиглагдана. Эдгээр багаж нь ихэвчлэн нярайн биед тохирсон, ойролцоогоор нэг метр (40 инч) хүртэл хэмжээтэй нарийвчлал сайтай механизм (ж.нь, хүүхдийн биед тохирсон гүлсмал хөшүүрэг); хүүхдэд тав тухтай бандан зэргээс бүрдэнэ. Зарим хэмжигч нь цахим дэлгэц болон бичигчтэй байдаг. Нярайн өндөр/ уртыг хэмжих багаж нь хүүхдийн өсөлтийг төрснөөс эхлэн хянах үнэлэх зорилготой.




INSUFFLATORS, ENDOSCOPIC

ҮЛЭЭГЧ, ЭНДОСКОП

UMDNS CODE 23523

Insufflators designed to maintain a regulated high pressure in a body tract or cavity by blowing a vapor or gas through an endoscope. These devices are typically an electronic unit with a high-flow gas (e.g., carbon dioxide) delivery unit, manometers for an accurate pressure measurement of flow rate and volume, pressure sensors and transducers, an electronic display, controls, and alarms. Endoscopic insufflators are intended to produce and maintain a gas-filled tract during a wide variety of endoscopic diagnostic and/or therapeutic procedures.

Дурангийн тусламжтай биеийн дотоод хөндийгөөр дамжуулан тогтмол утга бүхий өндөр даралттай уур болон хийг үүсгэх зориулалттай Үлээгч. Ийм төрлийн төхөөрөмж нь өндөр урсгалтай хий (CO₂) дамжуулах хэсэг, хийн урсгалын хурд ба эзлэхүүнийг нь нарийн хэмжих манометр, даралтын мэдрэгч, электрон дэлгэц, хяналтын хэсэг, дохиоллын хэсгээс бүрдэнэ. Дурангийн үлээгч нь хийгээр хангах зорилгоор дурангийн оношилгоо, эмчилгээнд өргөн хэрэглэгддэг.



PHOTOTHERAPY UNITS, INFRARED, PULSE LAMP/LASER

ФОТО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨХӨӨРӨМЖ, НИЛ УЛААН ТУЯАНЫ, ИМПУЛЬСЫН, ЧИЙДЭН/ ЛАЗЕР

UMDNS CODE 23544

